

Монголын шилдэг яруу найраг

Ардын хувьсгалын жаран жилийн түүхт ойд зориулж монголын яруу найрагчид бүтээлийнхээ дээжийг уламжлал ёсоороо ном болгон бэлтгэжээ. Энэ номонд манай ахмад, дунд, залуу үеийн зохиолчдын яруу найргийн төрөл төрлөөр бичсэн бүтээл багтан орсон байна.

Хувьсгалынхаа их ойн баярт ард түмнийхээ нэгэн адил манай уран зохиолчид бүтээлийнхээ дээжийг ергэн барьдаг уламжлалтай. Түүний нэгэн тод гэрч нь 1961 онд хувьсгалын дөчин жилийн ойд «Монголын шилдэг яруу найраг», 1971 онд хувьсгалын тавин жилийн ойд «Монголын шилдэг яруу найраг» номыг зориулан хэвлүүлсэн юм. Энэ бол их хувьсгал, монголын ард түмэнд яруу найргийн авьяас билэг, хүч шанадас, урлах эрдмийг хайрлан соёрхсоны баталгаа мөн.

Хувьсгалт уран зохиолын анхны бүрэн дуудлага «Шивээ Хиагт» цангинан дуурсаж хүн олны зүрх сэтгэлийг догдлуулан тэднийг тэмцэл ялалтад зоригжуулсан билээ. Далай баян ардын аман зохиолоос болон Д.Равжаа, Д. Сандаг..... нарын бүтээлээс уламжлал авч монголын шинэ үеийн уран зохиолд Д. Нацагдорж шинэчлэл хийж, Цэндийн Дамдинсүрэн, Сономбалжирын Буяннэмэх нарын авьяас билэгтэн нар ууган холбоочид нь болсон билээ. Хичнээн ч жилийн өндөрлөгөөс эргэн харж, нэхэн бодсон ч монголын шинэ уран зохиолын их цувааны магнайд Д. Нацагдорж «Миний төрсөн нутаг, монголын сайхан орон»- оосоо, «Октябрь»- ийн гэрэлд гялбасан «Нар», «Сар», «Од» -ны зүг сансрын хөлгүүд цойлохыг «мереедел хүслэн биелж байна» гэж саравчилж байх нь дамжиггүй ээ. Яруу найргийн уран дархчуулын их цуваанд Д. Цэвэгмид, Г. Сэр –Од, Ц. Цэдэнжав, Ч. Лхамсүрэн, Д.Тарва, Д.Даржаа, Д. Сэнгээ, Ч.Чимэд, Ц.Гайтав, Б.Явуухулан, С.Дашдооров, С. Дашдэндэв, Д. Гомбожав, М.Цэдэндорж, П.Пүрэвдорж, М.Ширчинсүрэн, Н. Нямдорж, Ш. Сүрэнжав, Д. Шагдарсүрэн, Д.Нямаа, П.Пүрэвсүрэн, П.Бадарч, Ш.Дулмаа.... олон арван авьяастан жагсан жигдэрсэн нь бий. Өнөөдөрөө царай зүс нь тодроогүй авч маргаашийн яруу найрагчид ч их цуваа руу ойртон дөтөлж байгаа.

ДАШДОРЖИЙН НАЦАГДОРЖ «1906 -1937»

Монголын орчин үеийн утга зохиолыг үндэслэгч Дашдоржийн Нацагдорж 1906 онд Түвшээт хан аймгийн Дархан Чин вангийн хошуунд «одоогийн төв аймгийн Эрдэнэ сум» ядуу тайжийн гэрт төржээ.

Балчир багадаа гэрийн боловсрол олж, Орос, Герман улсын сургуулиудад суралцжээ.

Манай утга зохиолын сан хөмрөгт шижир эрдэнэс болсон түүний зохиолын түүвэр 1935, 1945, 1955, 1960 онд тус тус хэвлэгдсэн байна.

Дашдоржийн Нацагдорж зохиол орос, герман, испани, хинди, япон зэрэг дэлхийн олон хэлнээ орчуулагдан хэвлэгдсэн юм.

БНМАУ - ын Сайд нарын Зөвлөлийн 1964 оны 10 - р сарын 7 - ны өдрийн тогтоолоор орчин үеийн сэдэвтэй, үзэл суртал, урлагийн талаар шилдэг уран бүтээлүүдэд Д. Нацагдоржийн нэрэмжит шагнал олгож байхаар тогтоожээ.

МИНИЙ НУТАГ

Хэнтий, Хангай, Соёны өндөр сайхан нуруунууд

Хойд зүгийн чимэг болсон ой хөвч уулнууд

Мэнэн, Шарга, Номины ергэн их говиуд

Өмнө зүгийн манлай болсон элсэн манхан далайнууд

Энэ бол миний төрсөн нутаг

Монголын сайхан орон

Хэрлэн, Онон, Туулын тунгалаг ариун мөрнүүд

Хотол олны эм болсон горхи, булаг рашаанууд

Хөвсгөл, Увс, Буйрын гүн цэнхэр нуурууд

Хүн малын ундаа болсон тойрон бүрд уснууд

Энэ бол миний төрсөн нутаг

Монголын сайхан орон

Орхон, Сэлэнгэ, Хөхвйн онц сайхан голнууд

Уурхай баялагийн охь болсон олон уул даваанууд

Хуучин хөшөө дурсгал, хот балгадын сууринууд

Хол газар одсон харгуй дардан замууд

Энэ бол миний төрсөн нутаг

Монголын сайхан орон

Холхи газраас гялалзсан цаст өндөр хайрханууд

Хөх тэнгэр цэлмэсэн хөдөө хээр цайдамууд

Холын бараа харагдсан ноён шовх сарьдагууд

Хүний сэтгэл тэнийсэн уудам амьсгалт талууд

Энэ бол миний төрсөн нутаг

Монголын сайхан орон

Хангай, Говийн хооронд Халхын уудам нутаг

Хар бага наснаас хөндлөн гулд давхсан газар

Гөрөөс, араатан авласан урт урт шилнүүд

Хүлэг морьд уралдсан хөндий сайхан хоолойнууд

Энэ бол миний төрсөн нутаг

Монголын сайхан орон

Салхины үзүүрт найгасан соргог нарийн ногоотой

Саруулд талд яралзсан сонин янзын зэргэлээтэй

Сайн эрс цугласан байц бэрх газартай
Сүлд тахилга улирсан сүмбэр их овоотой
Энэ бол миний терсен нутаг
Монголын сайхан орон
Нарийн өвс ургасан малын сайхан бэлчээртэй
Нааш цааш сүлжих тэнэгэр сайхан нутагтай
Дөрвөн цагийн улиралд дураараа нүүх нутагтай
Таван зүйлийн тарианы хөрс шороот газартай
Энэ бол миний терсен нутаг
Монголын сайхан орон
Слгий сайхан ууланд өвгөдийг тавьсан газар
Үр, ач, хүүхдийн үржиж өссөн газар
Таван хошуу мал тал дүүрэн бэлчсэн нутаг
Монгол хүн бидний сэтгэлийг сорсон орон
Энэ бол миний терсен нутаг
Монголын сайхан орон
Свлийн тасхийм цагт цасан мөсөн бүрхээд
Болор шилийн өнгө гялтганаж, гялалзсан орон
Зуны найртай улиралд цэцэг, навч дэлгэрээд
Жигүүртэн шувуу холоос ирж гангар гунгар донгодсон орон
Энэ бол миний терсен нутаг
Монголын сайхан орон
Алтай, Хянган хоёрын завсарт атар баялаг орон
Аав, ээжийн минь оршсон ашдын заяасан нутаг
Алтан нарны туяанд энхжин тогтсон орон
Мөнгөн сарны гэрэлд мөнхжин гялалзсан газар
Энэ бол миний терсен нутаг
Монголын сайхан орон
Хүннү, Сүннүгийн үеэс хөгшид өвгөдийн нутаг
Хөх Монголын цагт хүчирхэг болсон орон
Он онд идээшиж олон жилд дассан нутаг
Одоогийн шинэ Монголын улаан туг бүрхсэн нутаг
Энэ бол миний терсен нутаг
Монголын сайхан орон
Өссөн терсен бидний үндэсний хайртай нутаг
Сүнгелзэгч дайсан ирвэл үтэр өшиглөн хөсөн
Хувьтан энэ орондоо хувьсгалт улсаа мандуулж
Хойчийн шинэ ертөнц дээр хүндтэй гавьяаг байгуулья
Энэ бол миний терсен нутаг
Монголын сайхан орон

ОКТЯБРЬ

Нэг мянга есөн зуун арван долдугаар онд ертенц дээр алдарт
Октябрийн хувьсгал мандаж
Энэ едрийн наранд вйлдвэрчин тариачны алх хадуур ендер ендер гялалзав
Уралын баруун этгээдийг гэнэт улаан туг бүрхээд дарлагдсан ардуудын
сэтгэлийг хеделгөв
Зевлелт засаг тогтнож ертенцийн чих нүдэнд хувьсгалын дуу, гэрэл зэргээр тусав
Ильич багшийн ариун суртал, вйлдвэрчин ардын халуун гараар бүтсэн
Октябрийн хувьсгал
Зүүн европ, Умард Азийн оронд урьд үзэгдээгүй гайхамшигт шинэ орчлонг тогтоов
Зуун зуун жилд оршин суусан хааны ширээг түлхэж зальхай Керенскийн
сүрийг зайлуулав
Оросын уудам сайхан орныг бузарласан херенгетен газрын эздээс
Үйлдвэрчин тариачин еерийн орныг цэвэрлэн авав
Түмэн оны харанхуй түвхийг халсан Октябрийн хувьсгалд дэлхий дахин
цугаараа цочин ширтэв
Газар бүрийн пролетари нарт яруу уриа сонсогдоод ергөн жагсаалын
холхи зам тодров
Колони ба хагас колонийн түмэн ардыг нойрноос сэргүүлээд үнэнч шударга
хань нехер нь төрөв
Будангуйрсан ертенцийн байдлыг тэгшлэн засах хвчтэй долгион хөндлөн шуугив
Болшгүй болсон хуучин орчлонгийн бузар явдлыг бут эвдээд бас дахин шинэ
ертенцийг тогтоох Октябрь
Баруун Европт Америкийн вйлдвэрчинд үлгэр болоод таван тивийг
бүрхэх Октябрь
Байн байсаар бүх дэлхийн Октябрь болж хуучин байдлыг цөм халаад,
зөвхөн нарыг үлдээх Октябрь

ОД

Холхи газраас гялалзан харагдах өнгөт одоо
Хязгааргүй огторгуйн дунд зугаалсан олон улаан оч оо
Нарт ертенцийн дотор суугаа марс од оо
Манай хүн терелхтөн чамтай танилцахыг хэдийнээс хүсэв.
Алтай сайхан бие дээр чинь ямар хүн, эрдэнэ оршном?
Уул ус, цэцэг навч чинь юугаар бүтсэн бэ?
Манай ертенц шиг янз янзын юм холин байна уу?
Нийгмийн журам байдал чам дээр тогтсон уу? Үгүй юү?
Од чиний тэндээс энэ дэлхий ямар өнгөтэй үзэгдэнэ вэ?
Орчлонт ертенц гэдгийг чи мэднэ үү? үгүй юү?
Янаглал амраглалын дел аль хэр хурц вэ?
Юунд манай ертенцэд захиа үл илгээнэ вэ?
Эрдэмд марс од оо? Чи нэг нэгээр харж байна уу?
Энэ дэлхийн түмэн байдлыг юу гэж сонирхоно чи?
Огторгуйн оргилын олон эрдэмтэн чамайг хэдийнээс сонирхов

Урьдаар нийгэм журам байгуулж дараагаар чамтай ураг больё гэнэ.
1931 он

ХАВАР

Тааламжтай сайхан хавар,найртай сайхан хавар
Дахин дахин ирж дэлхий дахиныг гийгүүлнэ
Тэргүүнээ ергөж, дөрвөн зүг хандвал
Тэнгэрийн хязгаар цэв цэлийн уудмаар амьсгална.
Алтан наран гийж мөнгөн цасыг хайлуулаад
Амьтан бүхэн телжиж цэцэг навч соёолно
Шар дэлхий ногоон дээлийг өмсөн ёсолж
Цэцгий болжмор жиргэлдэн хөгжим ергөж угтана.
Бургас модны навч зулзага бултайн цэцэглэж
Туулай чандага үүгээр түүгээр харайн наадна
Хурга, ишиг энд тэнд майлалдан давхилдаж
Хоньчин хүү нимгэн дээлийг өмсөн дэвхэцнэ
Голын мөсөн хойд далайд нүүн одож
Булгийн ус хөгжим мэт эгшиглэн мяралзана
Хараацай шувуун хоосон агаарт дураар сүлжиж
Хүүхэд багачууд түүний жиргэхийг дагалдан гүйлдэнэ
Үдшийн жавар нуугдаж өглөөний хяруу ичээд
Морь мал дураар бэлчин зүлгэн дээр хөрвөөнө
Ногооны униар дэгдэж уулын мод хөхрөөд
Буга хандгай сүрэглэж яруу сайхнаар урамдана
Хүн ард бүгчим гэрийн мухрыг огоорон
Уудам талбар,ариун агаарт давхилдан цэнгэнэ
Цэцэг навч телжин тэргүүнээ дээш ергөөд
Цомирлигийн дотроос өнгө бүрээр инээмсэглэнэ.
Хээрийн галуу ирж гангар гунгар донгодоод
Хүний сэтгэлийг хөдөлгөн холхийг мөрсөдүүлнэ
Найртай улирал огторгуйг тулж, дахин шинэдээд
Эрт эдүгээг бодогдуулан, нуугдсан сэтгэлийг сэргүүлнэ
Хүсэлтэй сайхан хавар аа, цэнгэлтэй сайхан хавар аа
Хүн бүхэн чамайг хүлээж, бодис бүгд чамайг мөрсөдөнө.
1931 он

МӨРСӨДӨЛ

Хаврын найртай улирал бас дахин ирж
Бургасны мөчир цэцэглүүлэн эхлэв
Хайртай янаг чи хэзээ хүрч ирж

Миний зүрхийг баясуулан цэнгүүлэх вэ?

Сндер уулын орой дээр гарахад
Холын бараа цэв цэлийн үзэгдэнэ
Сөрийн биед хоёр жигүүртэй болоосой,
Даруй нисч чамдаа очих юмсан

Гэгээн нар нэгэнтээ ойртон ирж
Цонхны дорхийг гэрэлтүүлэн эхэллээ
Хэдийнээ амраг чи одоо учирч
Миний хэнхдэгт зул барих цаг боллоо

Агаарт нисэн жиргэгч шувуу
Малчин хүнд хөгжим зугаа болно
Алс газраас дурсан суугч хонгор чи
Миний сэтгэлд мөрсөдөл болно.
1931 он

ИДЭР ХОЁР

Хос алга нүд минь
Хоёр биедээ солонголно
Холбоо хоёр зүрх минь
Хувирахгүй янаглана
Цолмон хоёр нүд минь
Цогийн халуунаар ширтэлцэнэ
Цогцос хоёр зүрх минь
Цохихын тоогоор ярилцана
Идэр хоёр насны
Эвийг хэн ч эвдэхгүй
Сргөж босгосон тооно нь
Үүрд мөнх мандана.
1933 он

СЭХЭЭТЭН

Зоригт Монголын ач нар, түмэн түмэн үрс
Золбоот хөвүүд охид, цог заль тегс
Хүндэт нэрээ дуудуулсаар хойчийг залгамжлах залуус
Хөдөөгийн уул талаар соёлыг тарих хүмүүс.
1934 он

ТУУРГАНЫ ЗУРГИЙГ ҮЗВЭЛ

Ертенцийн дөчдүгээр бvслvүр дээр оршигч
Итали орон юутай сайхан улиралтай вэ?
Зуны сайхан нар, Генуя хотыг гэрэлтvүлж
Тунасан хөх далай вэсгэлэнт харшид тулжээ.
Гуа залуу охин, мяндсан шvхрийн сvүдэрт
Янагийн дууг дуулах бегеэд
Жавхлант идэр эр, дарвуулт онгоцонд сууж ирэхийг хvлээнэ
Харилцан учралдаж, гар барилдан онгоцонд суугаад
Салхины эсрэг хурдан одох агаад
Гvн далайн эзгvй арал дээр очиж
Мянгантаа тэврэлдэн, тvмэнтээ vнсэлцэнэ.
1930 он

ЖУМЖАНЫ АРГАНБАЙ

Жумжаны Арганбай 1929 онд Баян- Өлгий аймгийн Толбо сумын нутагт малчны гэрт төржээ.
Бага, дунд сургууль, ЗХУ-ын Алма-Ата хотын Багшийн дээд сургууль төгсжээ.
Ж. Арганбайн зохиолын түүврүүд 1960,1972,1977 онд хэвлэгджээ.
Жумжаны Арганбай шилдэг зохиол туурвисаны учир 1978 онд МЗЭ –ийн шагнал хүртжээ.

ХУДАГ

Энэ нутгийг Наран,Шилааш гэж нэрлэдэг
Эцгийнхэн маань олоон үеэрээ андахгүй
Энд мянга асч, түм унтарсан хүсэл бий
Эрх байхгүй надад, түүнийг тойрох.....

Цаст буурал уул цаана нь дүнхийж
Наст хүрэн адарга наана нь барзайж
Тэнгэрийн хаяа хүртэл тэлсэн хөндийтэй
Тэндээ нууцаа хадгалсан тийм нутаг

Цээжин дээрээ ганц овоохой босгуулаагүй
Чийгний зүйл ганц дусал нэвчүүлээгүй
Таван ямаа өөр рүүгээ зүглүүлээгүй
Таана хялгана тэндээ л халиурсан нутаг

Ургасан өвсний нь сүүн шимийг бодвол
Угаас саламгүй сайхан энэ нутгийг
Өндөр тэнгэрийн хүрэн бүргэдээс ондоо
Өвлөж эзэгнэсэн амьтан байхгүй нь гайхам

Муна шиг толгойлсон аагтай сонгиноосоо
Мяндас шиг халиурсан амттай өвснөөсөө
Мал сүрэгт ганц ширхэгийг ч хүргэдэггүй
Мунхаг харамч амьтан шиг нутаг байлаа

Устай бол мөн ч сайхан нутаг юмсан даа
Ухаад үзвэл....гээд олон буурал зориглосон юм
Гандаж хүрэнтсэн хан хуурай цээжлээд
Ганц ч дусал ус гаргахгүй л гөлийлөө.

Устай болгох гэсэн баячуудын хөрөнгө
Ус гаргах гэсэн баатар эрсийн хөлс
Энд ердөө л түүх домог болон үлдэж
Эрээн мөр ч цээжиндээ үлдээхгүй байлаа.

Нэг сүрхий баян эр гарч ирж гэнэ
Энэ нутгийг ганцаараа эзэгнэхийг шийджээ
Хүн малын ундаа ус гаргаж чадах
Хүчтэй эр байвал даруй хүч ир

Ус гаргаж, хүслийг хангасан тэр эрд
Охиноо өгч өрх гэр тусгаар барина
Зуун адуу, мянган хонь өгөхөөр зарлажээ
Зуур замд, харин баяны нэр мартагджээ.

Бардам баяны амласныг авах санаатай
Баатар эрс газар газраас аахилан ирэв
Арай чуу гэж алд дэлэм малтаад цуцав
Асгарсан хөлс, худгийг усыг нь орлов

Малтаж гаргасан шороо овоорон ихэдсээр
Манхан толгод шиг боллоо ч гэсэн
Баян ядуугийн хэний нь ч хэрэг бүтсэнгүй
Балай худаг бахь байдгаараа үлджээ.

Салхи шуурга ээлж ээлжээр үлээсээр
Сайхь худгийг дахин булж хаяад
Хөөрхий газар тэгээд юу үлдэв ээ гэвэл
Хүн гар хүрсний сорви төдийхөн үлджээ

Эрин цаг улирсаар хорьдугаар зуун ирлээ
Эх нутагтаа ард түмэн эзэн боллоо
Ардаан гэсэн элбэрэлт төрийн хайр
Аливаа газрын нууцыг тайлж эхлэв

Шинэ хүн хар тэнхээ заахаа байж
Шидэт техник хүний оюунаар хөдөлж
Хахир тэр нутгийн долоон давхар гүн рүү
Хатан өрөм нугас хатгах мэт орлоо

Ширгэсэн хөхтэй юм шиг байсан нутаг
Ивэлсэн дэлэн шиг өгөөмөр усаа хайрлаж
Наран, Шилааш нутаг худагтай болж
Налгар амьдрал тэнд дэлгэрч эхэллээ

Ахуй нутгийн хаан нь ард түмэн болж
Адуу мал ихтэй нь Наран, Шилааш болж
Эмнэг байгаль эрхт олноо дагаж
Эртний домгийг ард түмэн шинээр цогцлов.

МЭНГЭТ НУУРТ МИНЬ ОЧООРОЙ

Мэнгэт нуурт минь заавал очоорой
Мичид марал түгсэн шөнө очоорой
Малаа манаж, хөгжөөн цэнгээн үүсгэсэн
Манай хүүхнүүд, та нарыг угтах бий.

Хотыржоон ууланд харин өвөл очоорой
Хойлог, хахилаг шувуу болгоомжтой бариарай
Гоёхон лоовуузны гал улаан үнэгийг
Хыргаа уулнаас л агнавал дээр байх шүү.

Нүцгэнээр явбал сайн дулаалж бэлдээрэй
Нүгэлтэй хүйтэн шүү, зун ч цас шуурч мэднэ
Малчин хүний эр зоригийг шалгадаг
Манай нутгийн нэртэй уулсын нэг шүү

Аргаль угалз элбэгтэй уул юм гээд
Алдарт Сарьдагт минь дураар бүү аашлаарай
Ян улаан хаданд нь дүүлэн ассан
Янгир маань ч гэсэн хориотой амьтан шүү

Хар Хадат ч гэсэн уул шиг уул даа

Халууны улиралд сүүдэр нь үнэхээр сайхан
Намрын налгар цагт жимсэнд явахад
Насан үеийн бүсгүйчүүд ч дайралдаж мэднэ

Хонгор-өлөнг ч хэн хүнгүй андахгүй дээ
Хотолсон хонь шиг багтаж ядсан загастай
Дэгээ мэгээ гэхгүй гараар л барина шүү дээ
Тор шүүр хаяж дэг битгий эвдээрэй дээ

Бороотыг мэдэхгүй хүн, хаа ч байхгүй
Борбилсон рашаан нь цууд гарсан уул даа
Эрдэнийн есөн өнгөт чулуунаас нь авч
Элдэв чимэг хийхээ битгий мартаарай

Мэнгэт нуурт минь заавал очоорой
Мичид марал түгсэн шөнө очоорой
Малаа манаж, хөгжөөн цэнгээн үүсгэсэн
Манай хүүхнүүд, та нарыг угтах бий.

ХОНЬЧИНД ТАВЬСАН АСУУЛТ,ТҮҮНИЙ ӨГСӨН ХАРИУ

- Гараасаа салгадаггүй таягаа яагаа вэ?
Гай болоо юу, юунд хаячихаа вэ?
Хонь чинь үргээд хэцүү байна уу?
Хоёр муу гутлаа бас хаячихаа юу?
Өдөр хороох гэж эрхэлж саатаж явдаг
Өнөө хорголоо мөн л цацчихсан уу?

- Таягаа мориор сольсон шүү нөхрөө,
Тамаа цайсан хоньчноо больсон шүү хө
Хоёр муу гутал ч байхгүй түүний чинь
Хог дээр аль хэдийн шидчихсэн шүү дээ
Хоргол морголоор саатахаа эртүү болиод
Хотол олонд нэртэй шатарчин болсон,
Эдүгээ намайг, олон түмэн маань
Эрдэмт хоньчин гэх болсныг, юу гэв?

- Цай чанах, галаа асаах санаатай
Цахиур чулуу хавирч суудгаа яасан бэ?
Айлын ямаа бэлчээрт барьж саагаад
Амны цангаа гаргадгаа бас байсан уу?
Уранхай ноорхой хувцас чирч сөвийчихөөд
Үйлээ үзэж явснаа бүр болио юу, чи?

- Аянгын очийг гартаа барьж атгаад
Дөл угаагүй, галтай суудаг болсон шүү дээ хө,
Ариун хөдөлмөрийн ашиг шимийг хүртээд
Айлын дайтай айл явдаг болсон шүү хө,
Ацаг мөнгөө хурааж цуглуулж байгаад
Аятай гэснийгээ, шилж авдаг болсон шүү хө,
Эрвий биеэ, шахаж шимтэж байгаад
Эрдэм номын захад хүрч явна шүү хө.

- Ам л нээвэл хэрүүл, ховоор зууралдсан
Айхтар омогтой, отот төрлүүд чинь яасан бэ?
Газар нутгаа булаалдан ташуур шийдмээр
Гарзанд гарсан юм шиг толгойгоо хагалалцан
Үйлээ үзэж байснаа, ашгүй болио юу?
Үнэн мөнөөр нь хэлээд орхиоч чи?

- Алаг бөөр шиг эвтэй найртай явахыг
Ачит төр чинь амьдрал болгож өглөө,
Алтан хуулиа өндрөөр тунхаглаж зарлаад
Ахуй нутагт минь эзэн болгож өглөө,
Хахир харанхуй, хуучин цагийг, тэгээд
Хайртай нутгаасаа хөөн тонилголоо бид
Баатар хоньчин гэдэг эрхэм хүндэт алдрыг
Баясгалант төр минь өвгөн надад шагнасан юм.

Б.Бааст монголчлов.

БАБЫЙН АХТАН «1897-1976»

Бабыйн Ахтан 1897 онд Алтайн Шинжаанд ядуу тариачны гэрт төржээ. Идэр залуу насандаа Баян- Өлгий аймагт ирж суурьшсан байна.

Бабыйн Ахтаны түүвэр зохиол 1960 онд анх хэвлэгджээ.

Б. Ахтан шилдэг бүтээл туурвисаны учир 1965 онд МЗЭ- ийн шагнал, 1960 онд БНМАУ- ын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртжээ.

УУДАМ САЙХАН ЭХ ОРОН МИНЬ

Уудам сайхан эх орон минь
Улаан нарны туяагаар гиймэл байна
Цаст Алтайн минь мөнгөн цагаан оргил
Цал буурал аав шиг минь дотно байна
Дуулна би уудам сайхан эх орноо

Дуулна би тансаг арвин баялгийг нь
Дуулна би өсөж яваа жаргалант үеэ
Дуулна би хөдөлмөрч ард түмнээ
Баян сүрэг минь барагдашгүй арвижиж байна
Багачууд минь гэгээн эрдмээр бойжиж байна
Байгуулах нийгэм журмын ялалтад
Бадарсан бат итгэлээр давшиж байна
Уудам сайхан эх орон минь мандан цэцэглэ
Улаан нарны туяа үүрд чамайг гийгүүлнэ
Урамтай зоригтой манай хөдөлмөрч түмэн
Үргэлж чамайг шинэ ялалтаараа цогцлооно.

ЭХ ОРОН

Гоц сайхан эх орноо
Эгц ширтэн харахад
Төв Азийн өндөрт нь
Таван Богдын энгэрт нь
Баян - Өлгий хот нь
Бараа татан харагдана
Даяар олон иргэд нь
Таван хуруу шиг хайрлагдана.

Өлгий хот минь олондоо
Соёлын үр цацна
Өнөр сайхан малчид нь
Баярын инээдээр мишээнэ
Хөндий талаар дүүрэн
Хөгжсөн сууриуд үзэгдэнэ
Хөхрөх уулсыг бүрхсэн
Мал сүрэг нь ярайна.

Баруун талаар тойрч
Баян Алтай сүүхийнэ.
Зургаан давааны эх
Сиргаалаг алсад дүнхийнэ
Соргог сайхан өвс
Тунгалаг рашаан ус
Сүрлэг өтгөн ой
Чимэг нь билээ манай Алтайн!

Ховд голын эх нь
Хорымдыгт байдаг билээ.
Түргэн урсгалдаа тэр нь

Өргөн хэрэгцээт модыг маань
Өнөр олон арддаа
Өргөн ирдэг билээ.
Ай баян Алтай минь
Асралт сайхан нутаг минь!

Зуны сайхан улиралд
Зузаан ногоон ойд нь
Уран хөхөө донгодож
Уяхан гургалдай жиргэж
Балын амттай салхи нь
Байн байн сэвэлзэхэд
Зоригт казак хөвгүүдийн
Золбоо хийморь нь сэргэнэ.

Хайртай эх орондоо
Халуун зүтгэлээ өгсөн
Найртай Алтайн хөвгүүд
Баяртай сайхан цагтаа
«Хар ямаагаа» татаж
Хонгор охидоо магтаж
Баярын дуугаа эхлэхэд
Баян Алтай минь сэргэнэ.

Дуулах дууны минь эх
Урлах шүлгийн минь булаг
Хүрэн бүргэдийн минь баяр
Хөнгөн домборын минь эрч
Ариун дэлгэр эх орныхоо
Алдры нь магтан дуулахдаа
Өвгөн нас залуужин ирнэ
Өндөр Алтай минь инээн угтана.

ИТГЭЛИЙН ОД

Хан өндөр оргилтой эн чацуу сүндэрлэсэн
Хайрт Улаанбаатар чиний халуун цээжнээс
Октябрийн алтан туяатай улс Монголдоо золгуулсан
Онцгой манай баатрууд төрж гарсан түүхтэй.

Уулын ноён оргилын бүргэд зоригт Сүхбаатар
Ухаант Ленинтэй уулзаж, манай замыг гийгүүлснээр
Төрсөн нутгийн минь магнайд, жаргалын наран мандаж
Түмэн ардын цээжинд мөнхийн баяр ирсээн.

Сайхан Монгол орон минь, өнөр бүлийн өргөө
Саруул дэлгэр нутаг минь мөнх хөгжлийн өлгий
Жигүүр болсон домбороо, хөглөн хөглөөд өвгөн би
Жишишгүй чиний гоо үнэнийг магтан дуулаад баршгүй.

Гайхамшигт Алтайн хормойд сэлүүн Ховдын хөвөөнд
Гал улаан цэцэг шиг, миний Өлгий хот цэцэглэж байна
Тэнд амьдарч байгаа казак, урианхай түмний
Тэмүүлж байгаа зүрхний ариун цохилтыг чагнавал,

Үргэлж дэвжин цэцэглэх мөнхийн сайхан үрийг
Үнэндээ Улаанбаатар минь чи, тэнд аваачиж тарьжээ
Итгэл найдварын од - их хүчний тулгуур
Энхрий Улаанбаатар чамдаа түм дахин баярлалаа

Өргөн дэлгэр нутагт минь, өглөө бүрд чи авч ирэлцдэг
Өнгөт алтан нарны гэгээн туяаг угтаж,
Элгэн садан түмнийхээ, халуун зүрхний хайрыг
Энхрий Улаанбаатар чамдаа, өргөн ирлээ бид

Алтайн цэцэг шиг дэлгэрсэн, амжилтын бэлэгтэй ирлээ
Алтан гургалдайн уянга шиг дуу бүжигтэй ирлээ,
Ард түмний минь, сайхан сэтгэлийн бэлэг тэр!
Ахиад чамаасаа сурах, үнэн мөрөөдлийн илрэл тэр.

УУДАМ САЙХАН ОРОС НУТАГ

Өвгөн буурал Алтай шиг
Өндөр настай болсон хойноо
Галт тэргэнд суугаад
Газрын холыг зорилоо би

Молор эрдэнэ мэт хайртай
Монголын минь хээрийн салхи
Аян замыг минь өлзийтэй болог гээд
Араас үлээн үдэх цагт,

Уудам сайхан Оросын
Урсгал зөөлөн салхи,
Урдаас биднийг бас
Угтаж авсан нь бахтай

Уудам орос нутгийн

Урсгал зөөлөн салхиар
Зуны дэлгэр байгалийн
Зуун өнгийн цэцэгийн

Ханашгүй сайхан үнэр
Ханхийтэл үнэртэж байна
Тариа талхны үнэр
Таатай сайхан байна

Барагдашгүй их ойн
Баялаг шилмүүс үнэртэж байна
Бадрангуй олон үйлдвэрийн
Баагьсан утаа үнэртэж байна

Баясгалант олон хотын
Бадамласан гэрэл угтаж байна
Бат зузаан журамтай
Баатар ард нь угтаж байна

Зургаан хоног галт тэргээр
Зогсолтгүй давхих замдаа
Ильичийн гэрэл, орос нутгийг
Ид сайхан гийгүүлснийг үзэв

Бүх ард нь тэгшхэн хөдөлмөрлөж
Эх нутгаа шинэтгэснийг харав
Алх хадуур хоёр - оросын бахархал
Ажилчин тариачин хоёр - үүрдийн нөхөд

Алтан дэлхийгээ өөрчлөн шинэтгэж
Аж амьдралын далайг цалгиулсан
Алдарт зөвлөлтийн ард түмэн мандаг!
Аугаа коммунизмын наран гийг!

АМЬДРАЛ ГЭДЭГ САЙХНАА

Аз жаргал нь заяасан л байвал
Амьдрал гэдэг сайхнаа даа
Өвгөрөх насанд ч дарагдахгүй
Өрнөсөн сэтгэлд автчихаад
Өндөр тэнгэр өөд
Өргөж явчих гээд сайхнаа

Аз жаргал нь заяасан л байвал

Амьдрах гэдэг сайхнаа даа
Өнгөрсөн амьдралаа эгж
Өнөөгийн толинд харахад
Эдүгээгийн энэ жаргалтай

Эртхэн учрах минь яав гэнэм
Аз жаргал нь заяасан л байвал
Амьдрах гэдэг нь сайхнаа даа
Энэ үеийн охь болсон
Эрхэм залуу хөвгүүд минь
Жаргалын сайханд бүү ташуурагтун
Жаргаагч эх орноо хайрлагтун!

ӨЛГИЙ ХОТ

Өндөр уулсын хөндийг дагаж
Өргөн Ховдын хөвөөг барьж
Өлгий хот цэцэглэн хөгжиж
Өнөр олныхоо хайрыг татлаа
Өчигдөрхөн энэ хөндийг харахад
Өл цөлхөн нутаг байж билээ
Өнөөдөр чинийхээ цэцэглэснийг үзээд
Өр зүрх минь яасан их баярлана вэ?
Өлгий хот чинийхээ жишээг аваад
Өндөр уулсын бэл хөндий бүрд
Ирээдүйн жавхлант сайхан хотын
Ид залуу соёо ургаж байгаад баярлах юм
Уулсаар нутагтай ард олныхоо
Урам зоригийг хөгжөөн цэцэглүүлж
Охид хөвгүүдийн минь бяцхан цээжийг
Оюун эрдмийн шимээр тэтгээрэй.
Гэгээн өдөр манайд эхлэхэд
Гэрэлт нарны туяагаар гялбаж
Харанхуй шөнө нэгэнт болбол
Хаш эрдэнийн гэрлээ гялалзуулж
Өлгий хот минь өрнөн цэцэглэ
Өнө үүрд хөгжин мандаарай
Өнөр олны хүсэл ч тийм байна
Өвгөн дуучийн ерөөл ч тийм байна.

АДУУЧИН БҮСГҮЙ

Адуучин би, ардын нэгдлийн гишүүн би
Адуун сүргийг багаасаа маллаж өссөн юм би
Адуучин гэдэг малчин хүнд сайхан алдар юм
Ардын нэгдлийн адуучин гэдэг бүр ч бахтай алдар юм
Өндөр уулсын ногоон бэлийг дамжиж
Өргөн хөндийн уудам цээлд хариулж
Үүрийг угтагч зоригт адуучны цээжинд
Үржилт сүргээ хайрлах эрхэм хүсэл дүүрэн
Түнэр харанхуйг ашиглаж хорт чоно ч гэтдэг
Зүсэр бороог далимдуулж муу хулгайч ч ирдэг
Гэвч түмний сүргийг маллагч адуучны ариун харцанд
Гэнэдэх осолдох цаг үе байдаггүй шүү дээ.
Уудам хээрийг цочтол адуу унгалдах сайхан
Унага даага тоглож дураар байх сайхан
Үүрийг баяртай угтах адууч бүсгүйд сайхан
Үнэндээ тийм адууч олон байгаа нь бүр ч сайхан

МИНИЙ ДУУ

Алтайн цаст уулсаар нутагтай би
Алтан гургалдай шиг дууч ач нартай би
Ард түмэндээ дуу хоолойгоо өргөнө би
Ариун үйлсэд хувь нэмрээ өгнө би
Ачит нам минь намайг хүмүүжүүлж
Амьдрал бүхний минь хангаж өгсөнд
Өвгөн настай гэж хөл жийж суулгүй
Өргөн түмэндээ хүч чадлаа өгдөг билээ
Намтайгаа яваа хүн хөгширч болохгүй
Нас сүүдэр ч яахав, хэд л хүрвэл хүрэг
Харин ганц өдрийг ч гэсэн би
Хамаг олныхоо тусад л зориулна!

Б.Бааст монголчлов

ЄВЄНИЙ БААСАНЖАВ

Євєний Баасанжав 1924 онд Сэлэнгэ аймгийн Тvшиг цагаан - нуур сумын нутагт малчны гэрт төржээ.

Арван жилийн дунд сургууль, МУИС - ийн Монгол хэл, уран зохиолын ангийг төгсөж, «Шvлэг ба дуу», «Сэтгэлийн утас», «Мєнгєн долгио», «Залгамж вєийн тэмvвлэл», «Болзоотын бор толгой», «Бас нэгэн баяр» зэрэг яруу найргийн ном хэвлvүлсэн байна.

ИХ ОКТАБРИЙН ЭХ ОРОНД

Холын холдоо тэмүүлж
Хос шугамаар тэлгүүлж
Хоног хурмыг нисгэж
Хоёр тивийг шаглаж
Галт тэрэг хангинасаар
Газраа танин дунгинасаар
Гайхамшгийн дээд Москвагийн
Ганган тансаг хүрээлэнгийн
Ярославскийн вокзал дээр
Ягуухан очоод зогсдог байна
Яруу алдрын эзэдтэй
Яриа дэлгэж гардаг байна.

Саруул Москваг харах гэж
Сайхан нөхөдтэй уулзах гэж
Санаа сэтгэл яарсаар
Сар нарыг тоолсоор
Ярославскийн вокзал дээр
Яваад ирэхийн босгон дээр
Янз байдал шинээр терж
Яралзтал инээдэг байна
Магнай тэнийтэл инээх нь
Манлайн дээд хүслэн биз
Мах цуснаа шингэсэн
Манай үеийн тавилан биз.

Бемберцег дэлхийг ивээх
Баатар дайчин алхаатай
Болор шиг тунгалаг найрамдалын
Солир шиг хурдан галт тэрэг
Аугаа Ленин Сүхбаатарыг
Золгуулж өгснөө дурсаж
Ахан дүүсэг харилцааны
Судас болон лугшсаар
Монгол-Зөвлөлт түмний
Мөнх наслах найрамдлын
Гүн дотно итгэлтэй
Чин халуун сэтгэлийг
Их цуваандаа тээж
Ид хавтай довтолгож
Бодлын хурдыг гүйцэх
Чадлын цэнэг авсаар

Тэнгэр тосон исгэрч
Тэнхээ заан амьсгалж
Толгой даган жагсаж
Талбай эмжин зогсном.

Ярославскийн вокзалын
Хел ихтэй тавцангаас
Явдлын хүний харцанд
Хөгжлийн сүр цогцлоод
Ерген түмний жаргал тийш
Егсеж одсон замууд нь
Елмийн өмнө зурайж
Ернүүн баясал төрүүлнэм.

Олон салаа замуудаас
Онцгой тодхон дурайсан
Дуулим хорвоод алдартай
Шулуун зам тэндээсээ
Хүний дээд хүн
Хүж дэлхийн амь
Яруу алдрын суу
Ялгуулсан Лениний бунхан тийш
Алхаагийн минь сунгасаар
Аваад очдог, чиг байв
Ариун хүсэл биелэгдэх
Аз заяасан зүг байв.

«Энхийн Москвад алхах
Эхний гараа энэ мөн
Ильич багшид бараалхах
Энгүй цуваа тэр мөн» гэж
Баярласандаа болоод
Бараг дуулдахаар хэлээд
Эргэж хойшоо харснаа
Эгцэлж урагшаа алхлав
Шингэн үс минь сэвэлзэв
Шидсэн хормой дэрэлзэв
Гарын хаялаа ирэлцэв
Хелийн алхаа товолзов.

МОСКВА 1976

ТАЛ ДАХЬ БАЙШИН

Ихийн газар
алдар цуу нь
алслан цууриатсан

Ижил мерен
цэнхэр хадаг шиг
цэлэлзэн урсана

Энгүй тэнэгэр
егеж баян
ерген тал

Энгэр задгай
тэнгэр тосон
дуниартана.

Хараа сунган
алс тэртээг
ажин ширтэхэд

Хачин сонин
енгийн судал
велнэ вий

Хачин сонин
енгийн тэр
велэх судал нь

Хөх, цэнхэр
Дун шараар
Дурайна бий вий.

Зеелен урсгалт
Ижил мерен
ирилзэж цэнхэртэнэ

Звйдэл залгаад
сортой тариа
давалзан шаргалтана

Завсаргүй тэгээд
тэнгэрийн хаяа
тэлэн цэнхэртэнэ

Замиланг ивээгч
алтан наран
мандан шаргалтана

Шангаас халгисан
тариан талбай
тэртээ хойморт

Шовойж үзэгдэх
саарал байшин
сонирхол татна

Шовойж үзэгдэх
тэрхүү байшинд
тулаад очвол

Сергей баатрын

хээрийн ергее
угтах болно.
Газар шорооны
ханхийх үнэр
хамар цохисон
Гарамгай баатрын
аварга гарыг
атган мэндлэхэд
Ахуй нутгийн
алдарт баатар
Алтангэрэлтэй минь
Ах дүү ч юм шиг
адилхан ч юм шиг
санагдана билээ.

Сэрүүн тэнгэр еед
долгио ергөж
даргин шуугьсан
Сэлэнгэ мөрөн
цэнхэр хадаг шиг
цэлэлзэн урсана
Сүмбэр уулсын
үржил шимт
евөр хөндийнүүд
Сүлжээ татан
дөрвөн зүгтээ
дуниартан байнам
Түргэн урсгалт
сэлэнгэ мөрөн
сахран цэнхэртэнэ
Түүнээс залгаад
сортой тариа
давалзан шаргалтана
Тойрон зогсох
ноёлог уулс
ногоотон дүнхийнэ
Толин тунгалаг
мэлтгэр тэнгэр
манхайн цэнхэртэнэ
Алтаар халгисан
тэнэгэр талбайн
тэртээ хойморт
Алсаас үзэгдэх
тэрхүү гэрт
тулан очвол
Алтангэрэл баатрын

нүүдлын ергее
угтах болно!

Түвшин Ижилийн
хормой түлхүү
тэнгэр дор
Түргэн Сэлэнгийн
орой түлхүү
тэнгэр дор
Ижил сэтгэл
онц бүтээлээр
овоглож терсен
Ихэр юм шиг
хоёр баатар
харцанд ургав.
«Таван жилд
хорин жилийг
«алхана» хэмээн
Толгойлж явахыг
том зорилтоор
жигүүр дэвсэн
Үлгэрийн баатрууд
үйлс зүтгэл
нэгтэй байнам
Үлэмжийн сайхан
цогт ирээдүйд
цугтаа дэвшнэм
Түвшин урсгалт
Ижилийн эндэх
шовгор байшин
Түргэн урсгалт
Сэлэнгийн тэндэх
бөмбөгөр гэр
Ариун санаагаар
хана гэрэлтэм
дүүрэн байнам
Алдар гавьяагаар
хараа сунгам
сүмбэрлэж байнам.

1976 он

ПУНЦАГИЙН БАДАРЧ

Пунцагийн Бадарч 1939 онд төв аймгийн Баянжаргалан сумын нутагт малчны гэрт төржээ. Бага,дунд сургууль, тусгай мэргэжлийн техникум төгсжээ.
П.Бадарч «Морьд», «Есөн эрдэнийн орон», «Зургаан мөнгөн мичид», «Алтан тоос» зэрэг шүлгийн ном хэвлүүлжээ.

ЕСӨН ЭРДЭНИЙН ОРОН

Есөн хүсэл бүтэхийн үүд эрх чөлөөг дагуулсан их хувьсгал танаа

Ивээлт, нарны нь цацрал алтан эрдэнэ
Ижий таны минь цацал мөнгөн эрдэнэ
Илчит улаан гал нь шүрэн эрдэнэ
Идээшиж суусан гэр минь танан эрдэнэ
Эрхэс наадах тэнгэр нь номин эрдэнэ
Энгүй ергөн тал нь оюун эрдэнэ
Энх үүрийн туяа нь зэс эрдэнэ
Эгэлхэн бүсгүй нь гоёл сувд эрдэнэ
Эрэлхэг ард түмний нь эв ган эрдэнэ
Эх орон та минь, есөн эрдэнэ

1

Эргэх их дэлхийн уул усан тэгшхэн
Илч гэрлийн гайхамшиг мандсан нар алтан билээ
Энгүй ергөн талын шимт хөрсөнд төлжиж
Эрдэнийн түрүү сугсруулсан амуу тариа алтан билээ
Энэ сайхан монголын удам залгасан бүл
Энхрий хос амрагийн дурсгалын бөгж алтан билээ
Энэрэлт төрийн далбаанд эгнэгт өнгөлөг гялалзсан
Эрдэнийн соёмбо үсэг элэгдэшгүй алтан билээ
Асар гэгээн нэр нь алтан
Ачит төрийн сүлд нь алтан,
Арвайн түмэн түрүү нь алтан
Амраг хосын дурсгал нь алтан,
Миний эх орон алтан эрдэнийн билээ.

2

Саваа дүүрэн мэлтэлзэх Онон, Хэрлэнгийн урсгал
Сартай шөнөөр ажихад мөнгөн хээтэй байв
Саалийнхаа дээжийг ергөж, аянд хүүгээ үдсэн
Санаа нь сүү эхийн, цацлын халбага мөнгөн байв
Сайны ерөөл тогтоож хоёр гардан барьсан
Сайхан хос залуусын хуримын хундага мөнгөн байв

Саатаж алсад суугаад, аавдаа очиж золговол
Санасан эцгийн зэхсэн эмээл мөнгөн байв
Эцгийн зэхсэн эмээл нь мөнгөн,
Ээжийн цацлын халбага нь мөнгөн,
Сар наадсан ус нь мөнгөн,
Сархад мэлтэлзсэн хундага нь мөнгөн,
Миний эх орон мөнгөн билээ

3

Улсынхаа заяаг түшиж хувьсгалч ах нарын
Уухайлан мандуулсан туг шүр адил улаан билээ
Уламж эртнээс дээдэлсэн монгол хүний голомт
Угалз делт гал минь шүр адил улаан билээ
Удмаас буян тегс ергее цагаан гэрийн минь
Унь нь тооно бүхлээрээ шүр адил туяаран билээ
Уул усны савд уран бие найгуулсан
Удвал цэцгийн дэлбээ шүр адил делтен билээ
Хурын улаан цэцэг нь шүрэн,
Хувьсгалын улаан туг нь шүрэн,
Хурц улаан гал нь шүрэн,
Хорол улаан тооно нь шүрэн,
Миний эх орон шүр эрдэнийн билээ

4

Ерген талын элгэнд чандманланхан буусан
Ергее гэрүүд минь танан енгээр цавцайна
Ечнөөн үеийг элээсэн хангайн буурал уулсын
Евген цаст оргил танан енгээр цагаарна
Елзийт ерөөл билэгдэж, өнөр буурал эхийн
Ергесен сүүний дусал танан енгээр цацарна
Енөөдрийн сайхан үеийн бат цагаан харшууд
Евлөж хойчдоо үлээх тана эрдэнэ байна
Хайрын цагаан сүү нь танан,
Ханат цагаан гэр нь танан,
Хангайн цагаан оргил нь танан,
Хашийн цагаан орд нь танан
Миний эх орон тана эрдэнийн билээ.

5

Үүлгвй шөнийн тэнгэрт сүүн заадас татуулж
Өвч түгсэн одод сувд адил гялалзсан
Үелээ татсан талын энгээр тархан бэлчсэн
Үржилт хонин сүрэг минь сувдранхан налайна

Үнэрт тансаг өвсний ширхэг тоолон буусан
Үүрийн ариун шүүдэр сувдан далай байна
Үр буяны «тэнгэр»саальчин монгол хүүхний
Үсний гоёхон даруулга сувдан хээтэй байна
Хөх тэнгэрийн нь одод сувдан,
Хөдөө талын нь сүрэг сувдан,
Энх үүрийн нь шүүдэр сувдан,
Эгэл саальчны нь гоёл сувдан,
Миний эх орон сувд эрдэнийн билээ.

6

Эр биеийн хийморь сэргэж үүрийн талд давхивал
Энгүй тэнгэр зүүнээсээ зэсийн өнгөөр хаяарлаа
Ээлт сүргээ хурааж үдшийн хотонд ирвэл
Энэтээх үүлсийн хормой зэс эмжээр татлаа
Эгшигт дуугаа аялж айргаа аягалан суувал
Идээ сегнесен хувин зэс бүстэй байлаа
Энхийн их ордны ган нуруу холбож
Эвийн гагнуур тавивал зэсийн өнгөөр цацарлаа
Саалийн хувингийн бүс нь зэс
Сайн гагнуурын оч нь зэс
Онгон үүрийн туяа нь зэс
Оройн үүлсийн хаяа нь зэс
Миний эх орон зэс эрдэнийн билээ.

7

Ухаан санаа цэлмэх уулсынхаа хярд гарвал
Ургаа сум шиг гацуур оюу ногоон байв
Уудам талдаа ирээд дөрөө мултлан буувал
Урьхан намрын ганга нь оюу ногоон байв
Уран бидэр татах нуураа хөвсөөн алхвал
Усны цээлд замаг нь оюу ногоон байв
Унаган хүлгээ хантайрч эмээлийн дөрөө авбал
Угалз ширээлсэн гелем нь оюу ногоон байв
Усны зөөлөн замаг нь оюу,
Угалз ширээлсэн гелем ч оюу,
Урьхан намрын ганга нь оюу,
Уулсын сайхан гацуур нь оюу,
Миний эх орон оюу эрдэнийн билээ.

8

Хүү минь заяанд эхийн сүү шиг ариухан
Хүслийн сайхан тэнгэр номин цэнхэр юм

Хүлэг морин гүйх хаврын налгар едер
Хүрээлсэн талын зэрэглээ номин цэнхэр юм
Хүйтэн евлийг халсан дулаан цагийн билэгдэл
Хүвшид ургасан яргуй номин цэнхэр юм
Хүний дээд аавдаа, шинийн нэгэнд золгохдоо
Хүндлэн барьсан баранзад номин цэнхэр юм
Эрхсийн цэнхэр тэнгэр нь номин,
Илбийн цэнхэр зэрэглээ нь номин,
Эхний цэнхэр цэцэг нь номин,
Энхийн цэнхэр хадаг нь номин,
Миний эх орон номин эрдэнийн билээ.

9

Эрмэг хүлэг морь минь хазаар даран хатирахад
Эгшиг шигшиг татах амгай зуузай нь ган билээ
Илч гэрэл ертеелсэн аварга их алхаа
Эрчмийн баганад бэхэлсэн зургаан утас ган билээ
Эх сайхан орныхоо дархан хилийн харуул
Эр цэргийн зэвсэг эмтэршгүй илд нь ган билээ
Эрхэм алдраа бадруулсан өнөр өөдрөг түмэн
Эрэлхэг монгол ардын эв нь ган билээ
Уран хазаарын амгай нь ган,
Урсгал гэрлийн утас нь ган,
Эр цэргийн нь зэвсэг ган,
Эрхт ардын нь эв ган,
Миний эх орон ган эрдэнийн билээ.

Мэргэд цэцэлсэн далай хөлгөн их судрыг
Миний ард түмэн есөн эрдэнээр бичдэг билээ
Мөнх бусыг дагасан ачит буурлаа хүндэлж
Миний ард түмэн есөн эрдэнэ дэвсдэг билээ
Мехелгүй эрдэнийн дээж есөн эрдэм тегс
Миний ард түмэн улсаа бадруулж яваа билээ
Мереедел хүслийн дээд эв хамтад хүрч
Миний ард түмний есөн хүсэл бүтэх билээ.

ЭХ ОРНЫ ДУУЛАЛ

Алтай их хайрхан мөнх цагаан оргилоос
Аварга халимын сэрвээ шиг Буйрын мөнгөн долгио хүртэл,
Аралт тэргэнд хотойсон монгол шарын даваанаас
Алтан элс молцоглосон овоон ингэний ус хүртэл
Энэ насанд ганцхан заяах

Эх сайхан орны минь

Анирхан загасны сэлээнд цацрах дусал нь ч минийх
Алаг нүдэнд ертөхгүй ширхэг элс нь ч минийх
Ханат цагаан гэрт монголын удам бvvвэйлсэн
Хацар улаан нэрт ээжийн минь суугуул нутаг,
Хадган цэнхэр талд ээлт сүргээн адуулсан
Халх монгол ард эцгийн минь уугуул усан,
Энэ насанд ганцхан заяах

Эх сайхан орны минь

Харь газар одохуй алганаа дээжлэх рашаан нь ч минийх
Дөрвөн өнгийн хувьсгал эргэх цагийн аясад
Дөрөөн дээрх «туг» малчны сүрэг налайсан
Дечин өдрийн зам туулж гаршгүй талд
Дөмөнг дуулах хоолой таацах сэтгэл уяраасан
Энэ насанд ганцхан заяах

Эх сайхан орны минь

Далай саваан орхио юу гэмээр баян сүрэг нь ч миний
Далайсан илдтэн буцам ухаалагхан дуу нь ч минийх
Дэлтэй жаахан морьдын минь унаган хатуу туурай
Дэлгэр жаргалын ертөөнд улдаа нь үгвй төрсөн
Дээвэрт цагаан гэрийн минь удмаас өнөр үүд
Дээдлэн мандах нарны өмнөөс өөдлөн төссөн
Энэ насанд минь ганцхан заяах

Эх сайхан орны минь

Дэнжийнхээ зүлгэнд тэнцсэн унаган хвлэг нь ч минийх
Дээж таван тансагт өргөө гэр нь ч минийх
Шивээ хиагтын голомтноос асаж дүрэлзсэн гал
Шинэ төрийг тунхагласан ардын их хувьсгал
Ширүүн тулаанд эрсэдсэн ахмад тэдний дурсгал
Шижир алтаар сийлэвч үнэлж баршгүй бахархал
Энэ насанд ганцхан заяах

Эх сайхан орны минь

Шийдмэг зоригоор авчирсан эрх чөлөө ч минийх
Шинэ нийгмээ бадруулсан эрэлхэг ах нар ч минийх
Үүд тотго доргивол хоймор хот сэрхийж
Үлэмж тансаг орноо хатан зоригтнууд өмгөөлөн
Үй түмэн эрс мордоход, таны л тулд үрэгдэг гэж
Үр харам эх хүүгээн үдэж чадсан
Энэ насанд ганцхан заяах

Эх сайхан орны минь

Үеийн үед хайрласан эрдэнийн шороо нь минийх
Үнэний тулд нөгцсөн түмэн баатар нь ч минийх
Ухаант жанжин Сүхийн хатан баатар нам
Улс ардынхаа замыг ургах нар шиг гийгүүлсэн
Урагш дэвшихийн заяанд удирдагч энхрий намаа
Ухаалаг талбиун сэтгэлт саяар ард нь хүрээлсэн

Энэ насанд ганцхан заяах
Эх сайхан орны минь
Урдын бэрхээс гэтэлсэн дайчин нам нь ч минийх
Удмаас буян тегс далай түмэн нь ч минийх
Итгэлийн цэнхэр хадгаа дэлгэж золгосон цагаас
Эцгийн хоёр хvv шиг зовох жаргахад ханилсан
Их зевлелт ард олны минь тvшиг болсон
Ильичийн гэгээн дэнлvv одны тоогоор гялбалзсан
Энэ насанд ганцхан заяах
Эх сайхан орны минь
Эрхэм нөхрийг таньсан ухаант ард нь ч минийх
Ээрэм талд бадарсан гэгээн одод нь ч минийх
Түмэн намрын еглее алтан шашир намиаж
Түрvvгээн дааж ядах арвай буудай далайлсан
Түнэр шөнийн тэнгэрт гал цацсан яндангууд
Тvvний эзэн баатар гал улаан ган цувьсан
Энэ насанд ганцхан заяах
Эх сайхан орны минь
Түрлэгт далай дүйцэм эрдэнийн тариа нь ч минийх
Тvvхий төмрийг ширээсэн эрхэм ажилчин нь ч минийх
Эртний буурал сүмийн баганын дугуй сууринд
Эвийн улаан тоосгыг нутгийн шороогоор гагнаж
Энэ сайхан вейнхээ бат харшийг сүндэрлvvлсэн
Энэ насанд ганцхан заяах
Эх сайхан орны минь
Эрээн мяраан алагласан хуучин дурсгал нь минийх
Эрдэнийн шигтгээ шиг гялалзсан шинэхэн ордууд нь ч минийх
Тоонот монгол гэрийн элэнц вейн голомт
Тотгот ган тулганы элбэг улаан галыг,
Тохойрсон голын уснаас эрчмийн гал ертеелж
Тоост талаар алхсан ендер хvчдэлд холбосон
Энэ насанд ганцхан заяах
Эх сайхан орны минь
Тоотой насаараа хайрлах угалз улаан гал нь ч минийх
Тосох ирээдүйдээ бэлэглэх аварга их цахилгаан нь ч минийх
Эрдэнийн соёмбо всэгт улаан хөх туг
Элэг бүтэн улсын туурга тусыг баталсан
Ээлт нарны зvг морьтон давхисан сүлд
Энэ гэгээн төрийн учир уггыг багтаасан
Энэ насанд ганцхан заяах
Эх сайхан орны минь
Эртний дээдсийн соёл, соёмбо эрдэнэ нь ч минийх
Энэхэн амиараа хамгаалах, сүлд туг нь ч минийх
Уулсын сайхан богдын тэнгэрт сүрлэх оргилтой
Улсын сайхан нийслэлийн сүр жавхаа дүйцсэн
Усны тунгалаг Туулын сүйх мөнгөн мандалд

Уран чамин хот минь шинэхэн енгее тольдсон
Энэ насанд ганцхан заяах
Эх сайхан орны минь
Учралын мянган зам, уулзах энэ газар нь ч минийх
Уярлын сайхан дуу шиг Улаанбаатар нь ч минийх
Аугаа монгол улс мөнх оршихын билэгдэл
Алаг хонгор үрс минь, жаргал төгс торнисон
Ачийг үүрд санах хойч тэднийхээ нийгмийг
Ард түмэн минь өнөө, хотол даяар бүтээсэн
Энэ насанд ганцхан заяах
Эх сайхан орны минь
Агуужим сайхан сэтгэлт найрсаг түмэн таных
Аялгуу дуугаан ергесен найрагч би таных,

ЭХ ОРНЫ ХИЛЭЭС

Сүлдэт баганын дэргэдэх ширхэг энэ чулуунаас
Сүхбаатарын талбай хүртэл эх орон минь бий
Сая ардын итгэл багтсан Сүхийн их талбайгаас
Тэртээ хилийн багана хүртэл энхрий нутаг минь бий
Эх орноо хамгаалсан хилийн дархан харуул
Эр цэргийн сэтгэлд эх орон нь багтнам
Элэг буруу дайсан ширхэг чулуунд санаархвал
Эгэл бие чигээрээ чулуунд хувилах билээ.
Торойх баганын дэргэдэх ширхэг энэ чулуунаас
Тохой хүрэхгүй зайд дархан хилийн шугам
Торгоны нандин зах шиг сэмлэж болохгүй ариунаар
Торойх түмэн мэлмий шиг намайг ширтэн байна
Эр цэрэг дийлдээ ухарч гэж бодъё л доо
Эхний нэг алхамд хилээн орхих болно
Хайчны хурц ирээр торгоны зах огтчих шиг
Харь дайсны хутган хөл хилийг минь гишгэлнэ
Эр цэрэгт тэгэхээр ухрах газар байдаггүй юм
Эх орноосоо алхам алдахаа жигшдэг юм
Сүлдэт баганын дэргэдэх энэхэн ширхэг чулуунаас
Сүхбаатарын талбай хүртэл эх орон нь байдаг юм
Хилийн ширхэг чулуунаас эргэж нааш харвал
Хээр тал, ухаа толгод хээнцэр цэцгэс
Эзэн нь хайрлан гишгэмгүй эх орны минь
Эрдэнэ адил цогцос ээлжлэн байнам
Эртний буурал дээдсийн нутгаа тэмцсэн зерэг
Энэ л хилийн тулд нөгцсөн дайчны булш
Эрдэнийн номин дуулга шиг одот цэнхэр нуур
Эргийн нь зэгсэнд ганганалдах амраг хоёр ангир

Эхний айл, гүүн зэл, ингэ ботгоны гунганаан
Эмээлт морь шилгээн баясах хусан уяа
Ээлт үүдий нь сөхвөл зол бадрах голомт
Ээж аавын буянт жаргалын цагаан ергее
Хаагуур ухарч би хаяад гарах юм бэ?
Дээгүүр нь дайсан гарч дэвслэх билээ
Эр цэрэгт тэгэхээр ухрах газар байдаггүй юм
Эх орныхоо алхам бүрд амины хайртай байдаг юм
Далайн цагаан тана шиг талын цагаан хот
Тэнгэрийн гэрэлт од шиг түүний түмэн дэнлүү
Мечир дүүрэн шувуутай мянган цагаан хус
Менген саранд болзсон янаг сайхан хос
Уяхан хонгор ээжийн хувин дүүрэн сүү
Ухаан тегс эцгийн хуйвт сунагар уурга
Улаан бүчтэй дүүгийн номын хеерхен ширээ
Уран бэрийн хатгасан цэцэгт цэнхэр алчуур
Хаагуур ухарч би хаяад гарах юм бэ?
Дээгүүр нь дайсан гарч дэвслэх билээ
Эр цэрэгт тэгэхээр ухрах газар байдаггүй юм
Эх орныхоо алхам бүрд амины хайртай байдаг юм
Торгон навчаа шаагиулсан ойн гоёхон тегел
Томхон челеенд нь сүжрэлдсэн зүр гур хоёр
Тоосгүй долгион нь хөөцөлдсөн усны тунгалаг урсгал
Тохой бэлий нь эмжин бэлчиж налайсан сүрэг
Хаврын цэнхэр талд тариачны унагасан хөлс
Халиун шаргал сортой ургацын их үер
Халуун зуухаар амилсан үйлдвэр заводын нүргээн
Хат нь гүйцсэн гангаар ажилчны урласан анжис
Хаагуур ухарч би хаяад гарах юм бэ?
Дээгүүр нь дайсан гарч дэвслэх билээ
Эр цэрэгт тэгэхээр ухрах газар байдаггүй юм
Эх орныхоо алхам бүрд амины хайртай байдаг юм
Сүлдэт баганын дэргэдэх ширхэг энэ чулуунаас
Сүхбаатарын талбай хүртэл эх орон минь бий
Сая ардын итгэл багтсан Сүхийн их талбайгаас
Саяын ширхэг чулуу хүртэл энхрий орон минь байна.

ЦЭРЭГ ОРНЫ ДУУЛЬ

Цэмцийтэл зассан нэгэн ор
Цэргийн байранд байдаг юм
Эгнүүлж тавьсан ечнөөн орны
Эхэнд зассан байдаг юм
Эгээ л саяхан эзэн цэрэг нь

Энэхэн зуур гарав уу гэлтэй
Эвхэж тавьсан алчуур ч дутуугүй
Эзгвй нэгэн ор байдаг юм
Цэрэг эр хаачсаныг гэвч
Цэхэлж жагсах байлдагч бvхэн мэднэ
Цэнхэрлэж харагдах Байтаг уул мэднэ
Цэлгэр сайхан эх орон нь мэднэ
 Онголж хайрлах сэтгэл гэдэг
 Хагацалд дургвй хойно доо
 Орыг нь еглее босоод
 Хармаар санагдаад болдоггвй л юм
Дэндvв хайрлах сэтгэл гэдэг
Арай ч горьдлого тасардаггвй хойно доо
Дэрий нь еглее босоод нэг
Алгаар дармаар санагддаг юм
 Оройн тоогоор нэрс дуудахад
 Олны жагсаалын дундаас нэг нь
 «Байлдагч тэр эх орны телее»
 Байлдаанд амь врэгдсэн» гэхийг сонсоод
 Эргэж яасан ч ирэхгвй гэдэгт
 Итгэхээс еер аргагвй билээ
Балагт дайны хар мер арилаагвй
Байлдагч Тэгшээ салаандаа ирэхгвй
Баянбал гуайн хvв цэргээс халагдахгвй
Байтаг уул харуулаас солигдохгвй.

НУЛИМСТ БОРХОН БОЛЖМОР

Хаахнаас ч юм бэ нисэн ирж
Харуулын бяцхан шовгор дээр минь
Хээрийн хеерхен болжмор суугаад
Хэсэг юм шулганан хэллээ
Зvрхнээс ч жаахан энэ амьтны
Зvрх нь бас догдлон байна
Хенген едее сэrvэгнэн чичиртэл
Хеерсен зvрх нь цээжээ тvлхэлнэ
Ботгоны юм шиг уяхан нvдтэй юм
Болоочгвй бас тvвндээ нулимстай юм.
Бугын бидэр шиг велээ жигvвvртэй юм
Буурал сед еден дунд нь байх юм
Навчин чинээхэн далавчаа эцээн
Наад хеерхен зvрхээ булгиулан
Ботгон нvдэндээ нулимс гvйлгэн
Борхон шувуу минь юв гэж ирээв

Үүрийн ягаан жаварт хеерхий
Үүрэглэж суугаад даарсан ч юмуу даа
Єер шигээ үүрийн жавраар
Єндерт зогсоо намайг гайхна уу
Єерийн чинь хэлийг мэдэхгүй болохоор
Єдет борхон минь чамд би үг хэлье
Хайртай ээжийнхээ мээмийг дэрлэн
Хархан нүдтэй нялххан монгол
Томоогүй наадмаа зүүдлэн мишээхийг
Тооноор нь чи хараад ирэв үү
Агьт талын адуун сүргээс
Алихан унага унтаж хоцроход
Амраг эх нь эрэгцэн хайрлахыг
Ажиглаж чи үзээд ирэв үү
Баатар нь тэр тоглон зүүдэлж
Хүлэг нь тэр томоогүй унтаж
Эр цэрэг би хилийн харуулд
Эх орон тэднийгээ хамгаалж байгаа юм даа.
Хүүгийн бие цээнд хүрэх цагт
Хүлгийн унага шандас чангарах вед
Хүүгээн би сэрээж гэртээ харина
Хүлэг морьтойгоо тэр минь энд зогсоно
Эх орныхоо энхийг хамгаалж
Энэ харуулд тэднийг зогсоход
Єер унага талдаа бас унтаж
Єлгийдєє бас нэг хүү зүүдэлнээ
Эх орноо ухаант хүн гэдэг
Ингэж л уламжлан хамгаалж байдаг юм
Єглєє бүрий нь амгалан байлгах гэж
Єндрийн харуулд цэрэг эрс зогсоо байна
Жаргалтайн дэлгэр эх орон гэдэгт
Жаалхан шувуу минь чи ч багтдаг болохоор
Нулимст борхон минь эндээс цааш хүний газар шүү
Нутгийнхаа зүг эргэж чи минь нис дээ.

1971 он

ИХ САЙХАН, ГУРВАН САЙХАН ХЄХ УУЛ

Сургуулийн багахан насандаа юмсан
Шүлэг номд дурласан весэн
Цэлгэр талаар зам алсарч
Хөнгөн тэрэг түүгээр довтлон
Цэнхэртэх гурван уулсыг зорьсон
Гоё сайхан зурагтай, Лхамсүрэн гуайнхаа

«Говь гурван сайхан» номыг
Амтархан уншиж Довчинтойгоо булаацалдан
Алсын дуртгал енеедер сэргэв
Бага насны дэврүүхэн бодол
Баянхан бардамхан ч байж дээ
Тэр гурван хөх уулсыг үзэхсэн гэж
Тэгэхэд миний сэтгэл мөрсөдөн явжээ
Намайг тэр хүсэл енеедер л гүйцэж
Найрагчид онгод хайрласан гурван хөх ууланд ирлээ
Тэртээ багын минь хүслийг татсан гайхамшиг
Тэнгэрийн юм шиг «гурван сайхаан» та сайн байна уу,
Талын хүн гэж битгий бишүүрхээрэй
Та минь надад онгод хайрлаарай.
Буурал найрагчийн хүрэн моринд сундлалдаж ессен
Буянтай жаалуудын нь л нэг ирлээ шүү дээ
Алсын уулс л цэнхэрлэн байдаг бус уу
Аяа тэгтэл таны хормойд ирэхэд
Тэнгэрийн юм шиг, тэнгэрийн уул шиг
Цэнхэртээд л цэнхэр уул юмаа даа та
Оройн наран жаргахад Хэрлэн голоос харанхуй
Олон цэнхэр уулс баруун зүг давхарлан
Тэнгэрийн хаяа цаана нь бас цэнхэрлэдэгсэн
Тэр цэнхэр хаяа та байсан байх нь ээ
Дэргэд чинь ирлээ, цэнхэрлээд л байх юм
Дээд, тэнгэрийн хаяа мөнессе мөндөс
Оройд чинь гарахуй зүүн зүг цэнхэрлэлээ
Одоо л би учрыг ойлголоо уул минь
Эх орны минь хаяа цэнхэр байдаг байна
Эгэлхэн надад та тэнгэрийн хаяа байна
Хонгор, багахан насандаасан бол
Хормойд чинь сууж гэрээ санан уйлмаар,
Хожуу болсон гучин насандаа енөө
Хонгор сайхан ханиан санан уярмаар
Элэг зүрхэнд мөнх хайрлагдах
Эх орны минь хаяа хязгаарын нэгэн
Их сайхаан, гурван сайхан
Гурван хөх уул та энх орштугай.

Даланзадгад 1971 он

АЖВАА ХОНЬЧИН

Ажваа гуай гэж
Номхон цагаан хонь хариулдаг
Намхан бор хүн бий

Идэрхээн.
Ид дечин дээрээ
Ажилтай ч, олонтой ч хvн.
Ардын их хуралын депутат шvv дээ.
Айдаа хонийг ч нэг хариулна даа
Хонь гэдэг амьтан
Ажваа гуайд, хариулуулах гэж
Хорвоод байгаа юм шиг
Ажваа гуай бол еерее
Хонь хариулахын
Ховор эрдмийг
Хорвоод авч төрсөн юм шиг
Тэгж заяагдсан юм шиг
Тийм сайхан ажилсаг хvн дээ
Зуны гурван л гэнэ
Зудын гурав л гэнэ
Хавсарган гурав л гэнэ
Хайлган гурав л гэнэ
Дөрвөн улиралд
Дереед дээрээ явдаг хvн дээ
Адгуус ч гэлээ
Хонь нэг ухаантай
Араншин аягий нь
Ажваа гуай л мэднэ
Євс ногоо л гэнэ
Єр хоорондоо цем адилгvй
Аль нь хонины хоолыг
Ажваа гуай л танина
Оёдолт дээлээ
Онгож гандтал
Олон цагаан хонио
Оторлоод явахаараа
Олдоно гэж vгvй ээ
Од, сар л мэддэг байх,
Тэгж явахдаа
Тэнvvн талдаа
Таван зуун хонио
Мянга болгоод ирнэ
Теллvвлээгvй байтлаа
Тел бойжуулаагvй хэрнээ
Нэг хонийг хоёртой тэнцэм
Нээрэн тэгж таргалуулаад ирнэ
Хонины ааш зан гэж
Ховор сонин юм ярина
Хонь чинь хє
Аймхай, делгєєн

Амгалан тайван
Том дуугарахаар айдаг
Тойглох аялгуунд уярдаг
Бас гомддог гэж ирээд л
Бараг л хvний араншин шиг
Ховор сониныг ярьж
Хонио хайрлана
Ажваа гуай гэж ийм хvн дээ
Ажилтай ч олонтой ч хvн
Номхон цагаан хонь хариулдаг
Намхан хэр нь ендер алдартай
Энгэрт нь Алтан соёмбо
Их жанжин Сүхбаатарын одон бий
Ачит нам засгийн минь буян
Амгалан цагаан хонины минь буян
Баатар хоньчин ингэж
Бахархан ярина
Ажваа гуай гэж
Номхон цагаан хонины эзэн
Намхан бор хvн бий
Хөдөө сайхан талдаа
Хөрст алтан дэлхийдээ
Хонио хариулсаар яваад
Хөдөлмөрийн баатар болсон хvн дээ.

1974 он

ЖАМЦЫН БАДРАА

Жамцын Бадраа 1926 онд Хөвсгөл аймгийн Бүрэнхаан сумын нутагт малчны гэрт төржээ.

Бага, дунд сургууль, МУИС төгсжээ.

Ж.Бадраа «Уяхан хорвоон хань» дууны шүлгийн ном хэвлүүлжээ.

ХАЛУУН ЭЛГЭН НУТАГ МИНЬ

Элэг зүрхнээс уяатай

Энхрий Монгол нутаг минь

Эцэг эхээс заяатай

Эрдэнийн алтан өлгий еэ.

Цэцгийн шимийг тэтгэсэн

Цэнгэлийн хавар айлчлахаар

Мөрөн гол дуугаа дуулж

Мөнгөн сарьдаг нь мишээдэг ээ.
Сэвүүн салхиа сэвсүүлэн
Хацар нүүрийг үнсэн байж
Сэтгэл дотрыг ариулсан
Халуун элгэн нутаг даа.

ЗАНДАН ШОО

Харцагын шунгах эрмүүнээр
Хадан халилд цойлохдоо
Хаа чиг хүрэх эрээрээ
Хатан туурай нь баараагүй
 Залуу танхил насандаа
 Заяа холбон довтолгосоор
 Замлин хорвоог эдэлсэн
 Зандан Шоо гэгч морьтой сон
Яхир сунгуу бартаагаар
Янгир адил шуугихдаа
Ямар ч давчуу цаг хэмийн
Янагийн болзоонд саатаагүй
 Залуу танхил насандаа
 Заяа холбон довтолгосоор
 Замлин хорвоог эдэлсэн
 Зандан Шоо гэгч морьтой сон
Ганга л царван анхилуулаад
Газар шүргэн дүүлэхдээ
Гаргуун хурдан хатиргаа
Ганцхан ч удаа саагаагүй
 Залуу танхил насандаа
 Заяа холбон довтолгосоор
 Замлин хорвоог эдэлсэн
 Зандан Шоо гэгч морьтой сон
Төхмийн найрын уян дээр
Түмэн гайхаад бараагүй
Төрийн наадмын бариан дээр
Түүрүү магнай алдаагүй
 Залуу танхил насандаа
 Заяа холбон довтолгосоор
 Замлин хорвоог эдэлсэн
 Зандан Шоо гэгч морьтой сон

МӨРӨӨСӨЛ

Цэцэгтэй хөндийгөөр
Цэнгэлтэй ч явж билээ.
Амраг хайрт чамтайгаа
Ахин яаж учирна вэ?
Хатиртай морьдынхоо
Хазаартай хөг нийлүүлж
Хонгор хайрт чамтайгаа
Хоршин дуулж явсан сан
Эрвээхэй нүдний чинь
Эрвэлзэхийн тоолонгоор
Аюулхай зүрхэнд минь
Аз заяа хурдаг сан
Жавхлантай царайг чинь
Жаргалтай олж баясаад
Янаг хайрт чамтайгаа
Яг одоо учраасай.

НАМРЫН ШӨНӨ

Мэлтэлзсэн сүү шиг сарны туяанд
Гялталзсан шүүдэр сувдан өнгөтэй
Мэлрэн хүлээх миний дотрыг
Гялайлгах цайлгах хайрт чамайгаа
Дурсан суусаар
Дуулан саатахаа
Зовлон биш
Зол минь гэлтэй
Сугсалзан найгах өвсний толгойд
Сувдарсан шүүдэр намрын сүртэй
Санан хүлээх миний цээжийг
Саруулсан уужлах хайрт чамтайгаа
Дурсан суусаар
Дуулан саатахаа
Зовлон биш
Зол минь гэлтэй
Түрэлхэн дайрах үдшийн бүрийд
Түгээмэл гийсэн саран цогтой
Тэсэн хүлээх миний зүрхийг
Тэнхрүүлэн таалах хайрт чамайгаа
Дурсан суусаар
Дуулан саатахаа
Зовлон биш
Зол минь гэлтэй

СҮНДЭВЦЭРЭНГИЙН БАЗАРСАД

С. Базарсад 1950 онд Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт малчны гэрт төржээ. 1974 онд МУИС-ийн монгол хэл, уран зохиолын ангийг төгсөж, «Үүрийн цолмон», «Хаврын нахиа», «Тэртээ оддын хүүхдүүд» зэрэг шүлгийн ном хэвлүүлжээ.

ЖАНЖИНД ДУУЛАХ МАГТААЛ

Цэл залуухандаа нар шиг тодрон
Цэрэг эрсийнхээ хүндэтгэлд өргөгдөж
Аагтай цай шиг шимтэй үгээрээ
Ардынхаа сэтгэлийг соронздон татсан
Ардын хувьсгалчдын багш та минь
Алдаагүй амьдрахын жишээ байна
Аавын хайрласан нэр нь цуурайтаж
Айлаас айл руу Сэлэнгэ шиг урсаж
Хонхрын нэг тарсан олны сэтгэлийг
Хооронд нь нээн биесэд нь харуулсан
Ширүүн хувьсгалын ухуулагч та минь
Шивээ Хиагтын эгшиг нь байна
Нарс ганхтал уриалан уухайлж
Навчис гялалзтал дөлгөөн инээмсэглэж
Дарийн утааг харцаараа тууж
Дайсны зүрхийг үгээрээ буудсан
Эрчит хувьсгалын жолоодогч та минь
Энх тайвны давалгаа байнам
Холын аянд Гагарин шиг нисэж
Хонгор мориороо «Салют» шиг дүүлж
Хосгүй Лениний сургаалыг өвөрлөсөн
Цэцэн хувьсгалын гургалдай та минь
Цэнгүүн найрамдалын аялгуу нь байнам
Ширхэг үг нь бороо шиг задарч
Шийдвэр зарлиг нь гацуур шиг мөнхөрч
Бодол хүсэл нь хувьсгал шигээ үлдэж
Бууршгүй тэмцлийн ирээдүйд газарчилсан
Гайхамшигт хувьсгалын бүрээч та минь
Газар дэлхийн магтуу байнам.

1978 он

АЛТАНБУЛАГ

Хаа холоос чамдаа тэмүүлж
Хаврын шувуу шиг ирлээ
Алтанбулагаа?
Айл айлын чинь өргөөнд багтаагүй инээд
Агаарт чинь хангинахыг сонслоо
Алтанбулагаа?
Дөрвөн пулемёт тэндээс буудсийм гэж
Дөрөвтэй жаал чинь зааж өглөө
Алтанбулагаа?
Хувьтай сэргэлэн үрс чинь анх
Хувьсгал гэж хэлд ордог байнаа
Алтанбулагаа?
Хүндтэй хувьсгалынхаа голомтыг бахдаад
Хүмүүс чинь уцаарлах ч дургүй юм
Алтанбулагаа?
Заяаны сайхан алдрыг чинь сэвтээн
Залхуурч хоцрох хүн байхгүй юм
Алтанбулагаа?
Бүгдээрээ эелдэг олны чинь дунд
Бүтэлгүй хүн багтах зайгүй юм
Алтанбулагаа?
Найртай чамдаа хоромхонд дасчихаад
Намрын шувуу шиг хоргодсоор буцлаа
Алтанбулагаа?

ЛЕНИНИЙ ХӨШӨӨ

Ухаант мэргэдийн энгүүн хөшөө
Уянгатай орчлонд минь олршон байнам
Тэдэн дундаа Лениний хөшөө
Тэнгэрийн од шиг олон болном
Зөвлөлт нутгийнхаа хилийг алхаад
Зөндөөн гүрэнд очсон байна
Ухаант Лениний хөшөө боссон нутагт
Уран харшид ядуус орном
Хойноосоо энхийн нарыг дагуулсаар
Хосгүй Лениний хөшөө явж байна
Эрхэс гаригт хөшөө баривал
Эрхэм Лениний даруухан дүрийг
Холын гаригийн бүлээхэн чулуугаар
Хамгийн түрүүнд урлана гэж бодном
Тэнгэрт Лениний хөшөө босгох

Тэр цаг дөхөж байна.

1977 он

БАЯН ХУУР

Од сүүдэртүүлсэн хоёрдугаар дайнд
Орос цэрэг баян хууртайгаа явсан юм
Нуурын цалгиа шиг цээлхэн эгшгийг нь
Нутгийнхан нь сонсоод сэргэдэг байсан юм
Далай буцалгам дайчин аялгууг нь
Дайсны сум гэмтээгээгүй юм
Од сүүдэртүүлсэн хоёрдугаар дайнд
Орос цэрэг баян хууртайгаа явсан юм
Хоромхон саатахдаа хөгжмөө тоглохуй
Хоолны нь амт нэмдэг байсан юм
Дайчин эрсийн шинельд наалдсан
Дарьтай шороо унадаг байсан юм
Бөмбөгөнд дүлийрсэн цэрэг эрсийн
Бөглөрсөн чих онгойдог байсан юм
Од сүүдэртүүлсэн хоёрдугаар дайнд
Орос цэрэг баян хууртайгаа явсан юм
Хөнөөлт дайсны үхлийн сум
Хөгжмийн эгшгийг мөргөөд унасан юм
Хөрст дэлхийг гандахаас авраад
Хөөрөгт хөгжим бүтэн ирсэн юм
Баян хуурын аялгуу гэдэг
Баатруудыг анагаасан эм байсан юм
Эм болсон дуутай хөгжим
Энх тайвныг дуулсаар ирсэн юм.

1977 он

ДАШЗЭВЭГИЙН БАНЗРАГЧ

Дашзэвэгийн Банзрагч 1948 онд Төв аймгийн Өндөрширээт сумын нутагт малчны гэрт төржээ. Д.Банзрагч «Миний уул», «Арван хаврын цэцэг» шүлгийн ном хэвлүүлжээ.

АЛТАЙН ХАНГАЙ

Алтай Хангайн уулс
Агуу сүрлэг
Ар зоон дээгүүр нь
Хурган үүл давж чадалгүй
Хад цохионд нь
Харганын ноос шиг өлгөгдөнө
Алтай хангайгаа
Аялан дуулахад амаргүй
Ахар хоолойн дуу
Хадыг нь мөргөн бутраад
Хяр дээгүүр нь давахгүй
Агар зандангийн дэргэд сэрүүдсэн хүн шиг
Амарч нэг өгөхгүй,
Үүл сэмлэсэн оргил
Үзэгдээд байх нь шаналантай
Өндөр уулсынхаа нэрийг
Өөр дээгүүр нь давуулж
Өргөн энэ дэлхийд хэлээгүй найрагч
Өр зүрхэндээ зовуурьтай. 1979 он

ОРОС АХ

Орос ах нарыгаа би
Орчлонгийн түм дотроос танина
Тэр болгонд заяадаггүй
Тэнгэрлэг сайхан хийморь
Тэдэнд минь бий
Аугаа октябрийн туяаг
Ард түмний заяаг
Авч яваа хүмүүс
Аргагүй ээ
Нүд хаасан харанхуйг
Нүх болсон бурангуйг
Ялж гарсан баатрууд
Яриангүй ээ
Хүнч сайхан сэтгэл
Тусч сайхан сэтгэл
Олон дотроос ялгарах
Орос сайхан чанар
Үгийг минь хурцалсан билүү
Үйлсий минь гийгүүлсэн дэнлүү
Орос ах нарыгаа би
Орчлонгийн түмэн дотроос танина
Хорвоод Ильичийн
Хайр түгээсэн инээмсэглэл

Тийм сайхан инээмсэглэл
Тэдэнд минь бий. 1979 он

ДУУНЫ ДУУЛЬ **Виктор Хара-д**

Мөөмөө эрсэн хүүхэд шиг
Өнчирсөн дуу
Өвөр тэмтэрлээ?
Эцэг нь
Эрсэдсэн жаал шиг энэ дуу
Гил харанхуйд очтон тодорч
Галд тэмүүлсэн
Гал байлаа.
Энэ дууг
Эхлээд сонсоход
Эмнэлгийн газрын түгшүүр шиг чарлан
Эмгэнэлийн аясад чичирхийлж
Хана туурга руу минь
Халуун цус цацах шиг болсон юм
Харууслын туйлд
Чивчирсэн чавхдас
Ёолон хангинаад тасрах шиг
Хара - гаа бид алджээ.
Сэтгэлийн илчээрээ
Итгэлийн хүчээрээ
Хар генералуудыг чичрүүлж байсан
Хара - гийн дууны
Амь нь гэж
Андуурсан дайсан
Яруухан дуучны
Арван хуруунд нь
Ял оноожээ.
Хайр хүслэнгийн дуундаа
Халж улайссан мэт
Хара - гийн
Час улаан гитар
Чавхдсан дээрээ
гаргүйгээр хангинан байна
Аяа?
Илдээр хяргаж болдоггүй
Их хүслэн
Илд адил хатаагдан
Ир нэмсээр байна

Дууг хороож болохгүй
Дуунд шингэсэн амьдралыг
Хөнөөж болохгүй
Дуунд
Мэс халирна
Дуунд
Мөс хайлна
Хара – г хороосноор
Хара - д хороогдож эхэлсэн
Хунт
Хара - гийн дуу
Хангинасан агаарт
Хачин зовуурьтай амьсгална!
Аргагүй ээ, тэд!
Ая дуунд нь яллагдсан
Атаат дайснууд! 1978 он

АГСАМ ХАР

Амыг нь татвал
Амгай химлэн дугтчих
Зоригийг нь дагаж
Жолоогий нь өгвөл
Ар ширээтийн
Шар халзан даваагаар
Аагдуухан давах
Агсам харынхаа араншинг
Анддаггүй байж дээ
Ай, миний нөхөр!
Дэнжийн замаар дэргэдэх нь
Дээлийн хормой босч
Дэргэдэх айлууд
Цагаан толбо шиг
Бүрэлзээд өнгөрдөг сөн.
Урд
Улаан хөлтөн гарахааргүй
Дэрсний салхийг эцтэл
Дэргэдэх морин
Ард
Айлын айраг шуугьж
Асгарам
Агсардаг морин
Хан тэнгэрийнхээ
Аль нэг хаяа руу

Харваж одоод
Ханат гэртээ тогтдоггүй
Хорин насны минь хүсэл
Хачин танхай.
Хойгуур
Урдуур нь гялалзаад өнгөрөхөд
Хорин насыг минь ширтэж байсан
Хотол түмний нүд
Хачин гярхай.
Тэр л насны минь хүсэлтэй
Тэнцэж чадсан
Тэнгэртэй хүлэг морин
Ай, миний
Агсам хар!

ГОВИЙН ӨНДӨР

Ялгуун говийн цэнхэр ууланд
Янгир өөрөө сүрэглэн бэлчинэ
Яралзан бэлчих түүний жавхланд
Явдлын хүн нүд хужирлана

Сүрэг янгир асганд бужигнаж
Сүүдэр нь харин бэлд явна,
Сүүдэр ч биедээ хүргэх дургүй
Сэхүүн янгир оргилд заларна

Тэнгэр түлхсэн оргилын дээр
Тэргүүн янгир ганцаар сүртэй
Уулын сүрийг өргөж байдаг
Янгирын сүрэгт хүн хайртай

Аглагч янгирын сонор хөндвөл
Алтан дэлхийгээс олдохгүй амьтан
Анирч түүнийг оргилд байвал
Ахуй нутаг алзахгүй тайван

Алд хоёр эврийнх нь дундуур
Алтай руу уруудаж наран жаргана
Алтай говийн уулс дундаа
Амьд оргил бүгдээс өндөр.

ГАНЦ ҮГ

Ганцхан үгээр чамайгаа
Гомдооход
Эрэг дээр нь чиний минь
Эрхэлж өссөн нуур
Давстай ус
Нүд рүү цацаж
Надад догширлоо!
Хайрын аз түшсэн
Тэвшин завь шиг сар
Харахын завгүй
Хөлбөрлөө.
Харваас, эргийн зүг
Долоон бурхан
Долоон зэрэг ус самардана
Бодвоос,
Болчимгүй хэлсэн ганц үгнээс
Байгаль хямарч
Бид хагацаж болох нь!

СОДНОМБАЛЖИРЫН БУЯННЭМЭХ

С.Буяннэмэх 1902 онд одоогийн Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын хутагт тержээ. Монголын хуучин нийслэлд, сургуульд суралцаж боловсрол олжээ.
С.Буяннэмэх 1929 онд Монголын зохиолчдын эвлэлийн үүсэл болсон хувьсгалт уран зохиолчдын бүлгэмийг зохион байгуулалцаж удирдаж байжээ.
Түүвэр зохиол нь 1968 онд хэвлэгдэн гарсан юм.

ОКТЯБРИЙН ХУВЬСГАЛ

Октябрийн хувьсгалын их едер
Хүн терелхтний шинэ замыг нээсэн едер
Үйлдвэрчин тариачин ба улаан цэргүүд
Дайснаа дарж чадсан едер
 Анхдугаар европын их дайн бол
 Империализмын хор аюулыг таниулав
 Хүн терелхтний цусыг урсгахад
 Аврагч Октябрь гал мэт бадрав
Лениний тугийн доор хашгиран нэгдэж
Пролетарийн хувьсгалыг бүтээсний хүчээр
Империализмын анхны дайныг дарж

Хаан херенгетний харгис засгийг хувьсгав
Херенгетний ба феодалын ёс суртлыг
Үндсээр нь устган ёрчлөхийн хамт
Бемберцгийн хойд дээрээс үүсгэн
Нийгэм журамт СССР улсыг тогтоов
Октябрийн хувьсгалын хөгжилт нь
Гагцхүү СССР-ийг гэрэлтүүлсэн төдий биш
Түүнчлэн дорно зүгийн дарлагдсан ардууд
Үндэсний эрх чөлөөгөө тэмцэх нь үзэгдэв
Олон жил хятад ба феодалд дарлагдсан
Монголын малчин нүүдэлчин түмэн ард
Октябрийн хувьсгалын үрээр
Сөрийн орны бүрэн эрхийг хөгжүүлэв
Октябрийн хувьсгалыг шүтсэн бүгдээр
Империализмын хорт дайныг дараад
Капитал феодалын дарлах ёсыг устган
Хүн төрөлхтний амгалант эрхийг олгоно
Улаан наран мэт Октябрийн хувьсгал
Херенгетен ертенцийн харанхуйг гийгүүлж
Хүн төрөлхтний үнэн замыг таниулсаар
Хөгжиж бадрахын туйлдаа хүрнэ.

СҮХБААТАРЫН ТУГ

Гайхамшигт баатрын аймшигт сум
Гамин чандруугийн зүрхэнд тусмагц
Гадаадын дайсны сүнс нь цалгиж
Дотоодын харгисын зүрх нь чичирнэ
Ардын цэргийн анхны буу
Алтан даваан дээр тун гэж
Түүний цууриа эдүгээ хүртэл
Эзэрхэгийн чихэнд нижигнэнэ
Алтан үсэгтэй улаан туг
Толгойтын даваанаас намилзахад
Жавхлант улаан гэрэл нь
Бүхий улсад туналзана
Ухаант жанжин Сүхбаатарын
Уянгат сайхан уриа нь
Анхан татсан едрөөс нь эхлэн
Эдүгээ хүртэл дуурсаар байна
Түүний дуудсан эгшигт урианд
Түмэн ардууд эхэлж сэргээд
Түрэмгий дайсны эгц едөөс
Тун ч буцахгүй эрслэн жагсав

Эзэрхэг харгисын хелд байсан
Буурай монголын цогтой ардыг
Эрэлхэг зоригт Сүхбаатар
Эдүгээ вед нэгтгэн дагуулж
Харанхуй засгийг хувьсгал халж
Тунгалаг эрдмийн туяаг тусгаж
Дэлхий дахины шинэ вейн
Дээд меренд тугаа хийсгэж
Арслан барсын хвчин сүртэй
Ардын хувьсгалт баатар цэргийг
Уужим их талын дундаа
Байлдаан сүрээр батлан байгуулж
Хөх тэнгэрийн хөлгийг жагсааж
Хүчит аянгын зэвсгийг барьцгааж
Ган цахилгаан хуягийг хуяглан
Ган болдын бүрээг татаж
Сүргэн түмний амгалан байдал
Үндэсний хувьсгалт засаг терийг
Үүрд батлан хамгаалж чадах
Ардын улаан цэрэг болбоос
Чин зоригт Сүхбаатарын
Чадамгай хурц бие болоод
Чанадаас ирэх дайснуудад
Чангахан хариуг өгч чадна.

ҮРГЭЛЖЛЭН ДЭЛГЭРЧ БАЙГАА ҮНДЭСНИЙ УРАН САЙХАН

Уран сайхны улс терийн хөгжил боловсролын замыг
Уянгат хэдэн шүлгийн үгээр магтаж сайшаан өгүүлэе
Ардын эрхт манай төр нь амар жаргалант сайхан
Ард түмэнтэй найрлан суух радио уран сайхан
Ашдын эрдэм улсын соёлыг хөгжүүлж мандуулах сайхан
Ард түмэн бид бүгдээр баясаж суух нь сайхан
Монгол улс хувьсгалт терийг мандуулснаас нааш
Монгол хэмээх үндэсний соёлоо сэргээн хөгжүүлэх болов
Монгол хэмээх үндэсний соёл нь хөгжөөд ирэхийн хамтаар
Монголын дотор шинэ явдлууд дараалан үүсэв
Ший жүжиг, тоглоом наадам монгол маягаар тоглов
Шалгарсан сайн алдартай дуучид монгол дуугаа дуулав
Шанз хуучир дөрвөл чавхдас монгол янзаар хөдлөв
Шинэхэн янзын хувьсгалт ёсны монголын авьяас сэргэв
Холбоо шүлгүүд намираад гарах нь еерийн хэлний монгол
Хослуулан зохиосон эгшигт дууны үг санаа нь монгол

Хойшид боловсрох соёлын зам дээр нь үндэс болох нь монгол
Хуучин ёсны азийн дундаас шинэ мандсан монгол
Олон түмэн монгол ардын идэр залуу дүү нар
Ухаан сэхээт монгол овгийн уран сайхны авьяас
Сөрийн болох монгол улсын мандаж бадрахыг хвсэж
Үндэсний эрдэм Монголын соёлыг еед нь татахаар зорив
Энэ дор манай Монголд үндсэн соёл хөгжив
Энэ дэлхийд манай Монголын нэр алдар сэргэв
Эрдмийг хвссэн манай монголын бичгийн ардууд хуралдав
Эвдэрч хэмхэрсэн манай монгол бичиг зохиолоо сэлбэв
Шинэ ёсны шинжлэх ухаан Монгол оронд ирэв
Шалгарсан ёсны үнэн эрдмийг Монгол соёлоор угтлаа
Шилж олсон хувьсгалын журмыг монгол соёлдоо шингээж
Сэргэж боссон идэр залуу монгол бид нар суралцана
Өндөр дээрээс хvнгэнэн дуугарагч радио уран сайхан
Сөрийн хэл дээр холбоо шvлгээ өгvүлж байгаа нь сайхан
Үнэн эрдмийн чадал хvч нь үнэхээр илт сайхан
Үг бүрийн дуу хөгжмөөр нийтээр цэнгэх нь сайхан
Шинэхэн мандсан манай монголын үндэсний уран зохиолчид
Шилдэг сайн уран бүтээлийг өдөр өдрөөс бүтээж
Ший жvжиг, дуу хөгжим, радио бүхнээр нэвтэрч
Шимтэй сайхан эрдэм соёл нийтийн дундаа түгнэ
Түмэн ардын баясал болсон уран сайхны чуулган
Төр улсаа чимэг болсон яруу сайхны хурим
Түгээмэл нийтийн хөгжил болсон үндэсний эрдэм соёл
Түвшин энх түмэн ардын утга уянгын хөгжим
Энэ бүхнийг сонсож суугаа олон түмэн та бүхэн
Энэ улсын хайрт болсон малчин нүүдэлчин ардууд
Энэ цагаас эрдэм ухаанд яаран хичээн сурцгааж
Энэ мэтээр үүрд баясан хөгжиж боловсрох нь хэрэгтэй
Манай улсын нам засгийн гавьяат хэрэг олон байна
Малчин нүүдэлчин монгол ардууд даанч мэдэлгvй яахав
Мандаж байгаа манай ардыг гагцхvү зандаг дайсан
Мартаж болохгvй хажуу талд хардаж муулсаар байна
Муулав, муулав, хардав, хардав яаж ч чадна тэд нар
Манай ёс, манай эрдэм үнэний үндэс мөн
Мандуулж байгаа үндсэн соёлоо түргэн түргэнээр
Машид хурц уран сайхнаар чимэн мандуулж хөгжvүлж чадъя.

НАРНЫ ЭРГЭЛТ

Дүгрэг эрдэнийн гэрлийг
Түмэн газар сацруулж
Түгээмэл орчлонт ертөнцийг

Туяа гэрлээр гийгүүлж
Уудам огторгуйн оронд
Алтан хотлыг дэлгэсэн
Асар их тэнгэрийн
Амьд эрдэнэт наран
Тунгалаг туяагаа татуулж
Түмэн амьтныг гийгүүлсээр
Тус ачаа соёрхож
Түмэн бодис баясгасаар
Халуун илчээ хайрлаж
Хамаг амьтныг дулаацуулсаар
Хайр ершеелее хвртээж
Хамаг бодисыг тэтгэсээр
Сглесний ордноос ееделж,
Үдийн ордноо үдэлж
Үдшийн ордноо хэлбийхэд
Үзэгдэл бүхэн угтав
Баруун тэнгэрийн хаяанаас
Билгүүн униар харагдаж
Байдал үзэсгэлэн бүрдсэн
Бэргэн солонго татав.
Таван энгийн үүлүүд
Таван зүгээс хуралдаж
Танан эрдэнийн гэрэл нь
Таван тивийг бүрхэв
Цэгээн номин тэнгэрээс
Цэцгийн хур сийгэж
Цэлмэг тунгалаг огторгуйд
Цэнхэр туяа татав
Улаан шар гэрлээр
Орчлон дахиныг бүрхээж
Урсгал номхон далайд
Снгийн байдал зохилдов
Гайхамшиг их гэрлээр
Газар дэлхийг гийгүүлсээр
Гадаад далайг туулж
Галавын орныг гэрэлтүүлэв
Урин далайн оронд
Улаан туяа соёрхож
Усан ордны амьтад
Учралт жаргалыг эдлэв.

БАЛДАНДОРЖИЙН БЭГЗСҮРЭН

Балдандоржийн Бэгзсүрэн 1929 онд Сүхбаатар аймгийн Халзан сумын нутагт малчны гэрт төржээ.
Бага, дунд сургууль, МУИС төгсөж хөдөө аж ахуйн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалжээ.
Б.Бэгзсүрэн «Хөдөөгийн сайхнаас», «Вьетнамын тэмдэглэл», «Хоёр найраглал», «Хөдөөнөөс түүсэн бодол», «Хүний зан» зэрэг яруу найргийн ном хэвлүүлжээ.
«Тэмээчин» найраглал бичсэний учир 1964 онд МЗЭ - ийн шагнал хүртсэн байна.

БИ ХУВЬТАЙ ХҮН

Хувьсгал ээж хоёроо залуу байхад
Хувьтай би хорвоод төржээ
Хувьсгалын наранд улс орон
Хуучин хувцсаа сольж байхад
Ильичийн наранд шинэ Монгол
Ирээдүйн сайхнаа шулуудах вөд
Хувьсгал ээж хоёроо залуу байхад
Хувьтай би хорвоод төржээ
 Бурангуйг орхиж, дарлалыг устгах
 Буцалсан тэмцлийн илчинд дулаацаж
 Ялалтын уухайн сүрийг сонсож
 Ялагчдын царайг нүдээр үзэх
 Сүдөр шөнө хоёрын зааг дээр
 Сүнд мандах ялалтын эхэн дээр
 Ээж хувьсгал хоёроо залуу байхад
 Энэ дэлхийд би мэндэлжээ
Хорвоод тогтсон шударга нийгмийн
Хоёр дахь орны иргэн нь болж
Эх нутгийнхаа цэнгэлийн эхийг
Энэхэн насандаа үзэн баясаж
Хөрөнгөт нийгмийг алгасан харайсан
Хөдөлмөр тэмцэлд хүчээ өгсөн
Алдартай вөд амьдарч яваа
Азтай түмний нэг нь би юм. 1970 он

ТАЛ

Тэнгэрийн хаяа
Төртээ тэнд цэнхэртэж
Тэрний тэнд
Сонин зэрэглээ сүмбэрлээд

Сэрвүн салхи
Зеелен аясаар илбэж
Сэмжин вүлс
Цэнхэр огторгуйд хевелзене
 Ай хеe тал гэдэг внэхээр сайхан юм
 Тайван эрийн сэтгэл шиг тэнвүхэн юм
Нарийн евс
Дерее швүрэн суялзаж
Гэрийн орой
Хотгор дундаас цухуйгаад
Ханагар талын
Халиурсан их ургацанд
Хариулсан малын
Сэрвээ нуруу нь гевелзене
 Ай хеe тал гэдэг внэхээр сайхан юм
 Таван енгийн гоц нэгэн вээмж юм
Үер цас
Хэдийд орохоо илтгэж
Үүлэн түрвүч
Үдийн газраас цухуйдаг
Аяны тэмээ
Даваа давах зүдрэлгвй
Автын жолооч
Хурд саах учралгвй
 Ай хеe тал гэдэг внэхээр сайхан юм
 Тайван эрийн сэтгэл шиг тэнвүхэн юм

ОЧ

Цагаан тал, цагаан тал
Цасан шуурга хуйларна
Цасан шуурга довтолж
Цагаан тал хуйларна.
Урагшаа довтлох салхитай
Гулсах цас уралдана
Уул толгод нэлдээ
Уралдан хедлех шиг санагдана
Уулын оройгоор шүнгэнэж
Уургын үзүүрт исгэрсэн
Свлийн энэ шуурганаа
Срген дэлхий хеделж
Ургаа олон хайлс ч
Уруудах шинжтэй ганхалзана.
Свлийн энэ шуурга

Ерген дэлхийг хөдөлгөж
Ертөө тохиолдсон бүхнийг
Ертсэн зүг шилбүүрдэвч
Манарах шуургыг серен
Малчин эрс довтолгож
Аргамаг хүлгийн согсоо нь
Ар тийшээ сэргэлзэн
Малчин эзэн нь еерее
Малгай сөхөн дэрвүүлсэн нь
Амьсгал давхцам шуурган дунд
Асаасан галын бяцхан оч
Уруугаа биш еедее сереед
Улалзаж явах шиг санагдана

ЗАЛУУ НАС

Аавын гараас гарч
Агтын дөрөөнд хүрэх
Арван таван нас
Асаасан гал шиг агаад
Үргэлж тийм явахыг
Үлгэр туужид зөгнөдөг
Эр хүн болохын эх нь
Энэ л үес эхэлдээг
Ай хонгор залуу нас
Ахиж ирэхгүй залуу нас
Ухаант хүний сэтгэлд
Унтаршгүй мөнхрөх залуу нас.
Үерхлийн итгэлээс үндэслэж
Дурлалын галд дулаацах
Дуулж ханашгүй залуу нас
Дурлалд бүсгүй шиг агаад
Үргэлж тийм явахыг
Үлгэр туужид зөгнөдөг
Аавын голомтыг бадраах
Амьдрал тэндээс эхэлдэг
Ай халуун залуу нас
Ахиж ирэхгүй залуу нас
Ухаант хүний маргаашийг
Угтан авч ирэх залуу нас
Оюутны ширээнээс босож
Оноосон ажлаа эхлэх
Хорин таван нас
Хорвоогийн өглөө шиг агаад

Үргэлж тийм явахыг
Үлгэр туужид зөгнөдөг
Амьдралдаа юу бүтээхийн
Амжилт тэндээс эхэлдээг
Ай халуун залуу нас
Ахиж ирэхгвй залуу нас
Ухаант хvний хөдөлмөртэй
Уралдаж өнгөрөх залуу нас. 1969 он

БОДОЛ

Байгалийн урьхан хаврын цаг
Баян хангайн ногоо соёолж
Навч цэцэг амилан бултайгаад
Нарны илч дулааран ахуйд

Хvйтэн өвлийн догшин дvр
Хvний сэтгэл санаанаас
Хаврын сөвөлзэх салхитай цуг
Хачин сэмхнээр хийсэн байдаг ажээ.

Амьдралын хvндийг даван туулж
Ашдын жаргалд хvрсэн хvн
Гунигт амьдралын баларшгvй мөрөө
Гутран дурссаар насыг бардаггvй

Жаргалтай хоног золгох тутам
Жам дагуу мартан мартсаар
Сэтгэл зvрхний гуниг нь
Сэмрэн сэмэрсээр хийсэн байдаг ажээ. 1969 он

ТҮҮН ШИГ ЮМАА

Наран мандана, саран мэлтийнэ
Навч найгана, цэцэг ганхана
Хорвоо дэлхий сайхан юмаа
Хосгvй чи минь тvүн шиг юмаа

Уулс сvмбэрлэнэ, тал цэлийнэ
Ус туналзана, модод шуугина.
Хорвоо дэлхий тэгш юмаа
Хосгvй чи минь тvүн шиг юмаа.

Тэнгэр дуниаран дэлхийг ширтэнэ
Тэлгүүн салхи зөслөн илбэнэ
Хорвоо дэлхий сайхан юмаа
Хосгвй чи минь түүн шиг юмаа. 1969 он

ДАМДИНЫ БЯМБАА

Дамдины Бямбаа 1936 онд Дорнод аймгийн Чойбалсан сумын нутагт малчны гэрт төржээ.

Д.Бямбаа 1960 онд МИУС, 1975 онд Зөвлөлт Холбоот Улсын дипломатын академийг төгсөж «Африк эхийн дуулал», «Эвийн чулуу», «Уул усны охин», «Мянган хуурын эгшиг» зэрэг шүлэг найраглалын ном хэвлүүлжээ.

ЭВИЙН ЧУЛУУ

Уугуул нутгаа орхиж холын аянд мордохдоо
Унасан газрынхаа шорооноос нэгэн чулуу авав
Усан болор биш, голдоо нүхтэй цахиурыг
Урт амьдралын замд дурсгал болгон хадгалав
Хүний нүдэнд чулуу
Миний нүдэнд эрдэнэ

Тэгээд би хэлрүүн:

Түмэн уул, мянган гол гатлахаар
Төрсөн нутгаасаа хүү чинь явлаа
Эв нь таарсан цахиурын хагархайг
Эрдэнэ гэж хадгалахаар авлаа
Нөгөө хэлтэрхийг нь тандаа үлдээе
Нөр халуун хайраа өгч үлдээе
Их санасан зүрхний хайраар
Эх нутагтаа ирэх бүрийдээ
Эвийн чулуугаа эвлүүлэн үзээд
Элэг зүрхээ тэнийлгэж байя
Хүний нүдэнд чулуу
Миний нүдэнд эрдэнэ

Тэгтэл нутаг хэлрүүн:

Цагаан дэнжийн минь хэлтэрхий
Цахиур чулууны минь эмтэрхий
Санах үр чиний минь зүрхэнд
Саруул нутгаа орлож явбал

Энэ чулуу эрдэнэ болог
Эх орны чинь энэрэл шингэг
Их санасан зүрхний хайраар
Энхрий хүүгээ ирэх бүрийд
Эвийн чулуугаа эвлүүлэн үзээд
Элэг зүрхээ тэнийлгэж байя
Миний биед эрдэс
Чиний нүдэнд эрдэнэс

Тэгээд би хэлрүүн:

Соёлзоос Хүйтэн хүртэлх орноо
Соёмбо мандсан сүлд тугаа
Соён дэгжсэн хөдөө хотоо
Социализмд дэвшсэн хүн ардаа
Дандаа бодон ажилд шамдах
Дайчин ганц хүсэл байна
Далай баян нутаг Тандаа
Дархан өргөх тангараг байна
Зорьсонд хүрснээ эхдээ харуулах
Золбоот үрсийн нэгэн байж
Эх нутгаа өвөрлөж явна гэж
Энэ чулуугаа элтэл хадгална
Хүний нүдэнд чулуу
Миний нүдэнд эрдэнэ

Тэгтэл нутаг хэлрүүн:

Хэт холоос улай горилж ирсэн
Хэрээний сүүдэр зулай дээрээ тусгаагүй
Хиртэшгүй ариун, өртөшгүй дархан
Хийморь тэгширсэн ард олноо
Дандаа би хайрлан ивгээж
Даамай хөгжилт өнөөгөө бахдаж
Даанч сайхан ирээдүйгээ үзэж
Далд хадгалсан эрдэнэсээ нээлээ
Ээлтэй сайхнаа үрсдээ үзүүлэх
Энхжингийн орны нэгэн байж
Энхрий үрсийнхээ заяаг даасны баяраар
Эвийн чулуутай хүүгээ хүлээнэ
Миний биед эрдэс
Чиний нүдэнд эрдэнэс

Тэгээд би хэлрүүн:

Эх орны минь шороонд
Эцэг өвгөдийн минь нас бий
Энэ биений минь цусанд
Эх нутагын минь цус бий

Яруухан нутаг Таны тасархай
Яльгүй чулууны энэ хэлтэрхий
Харийн орны хаана ч таарахгүй
Нарийн эвцтэй сэтгэл бий
Үүнтэй би яг адилхан
Өөр оронд идээшин дасахгүй
Нутагтаа татагдах цогцос билээ
Нууцхан сэтгэлтэй чулуу билээ
Хүний нүдэнд чулуу
Миний нүдэнд эрдэнэ

Тэгтэл нутаг хэлрүүн:

Үрээ хайрлах эхийн сэтгэлээр
Үйлс заяанд чинь баярлаж байна
Өөр оронд бас чулуу бий шүү
Өөгүй ариун сэтгэл бий шүү
Тийм л чулуутай таарч яваарай
Хиймэл чулуутай бүү таараарай
Галд орвол ган болоорой
Холд явбал хань болоорой
Тэнгэрийн чинь хурын шим тоссон
Дээдсийн чинь ариун хөлс дуссан
Түмний чинь хайр тэгш ууссан
Тийм болохоор чиний хадгалсан

Энэ чулуу эрдэнийн чулуу
Эв мод шиг эвийн чулуу

Тэгээд би хэлрүүн:

Хилийн харуул хайч солилцохдоо
Хэн хэнээ таних тэмдэг
Эв модоо үзүүлдэг
Эцэг өвгийн минь ёс бий
Энэ заншлаар зүрхтэйгээ ихэр болгож
Эвийн чулуугаа хамт хадгална бий
Эндээ л бий эх орноо хайрлана
Эргэн ирэхдээ эвлүүлэн баясна
Эхээс төрөхийн хайраа өргөсөн
Ээлтэй жаргалтай хамагаа өгсөн
Элгэн халуун эх орон тантай
Энэ чулуу эрдэнийн чулуу
Эвийн мод шиг эвийн чулуу
Уугуул нутгаа орхиж холын аянд мордохдоо
Унасан газрынхаа шорооноос нэгэн чулуу авав
Усан болор биш голдоо нүхтэй цахиурыг
Урт амьдралын замд дурсгал болгон хадгалав

Эвийн чулуу эрдэнийн чулуу
Эрхт монголын өлгийн чулуу

АМЬДАЙ

Нэр нэгтэй олон сайхан амьдай нар
Нөр хичээнгүй ажилч эрхэм анд нар
Эх орны дуудлаганд чих нэгтэй байдаг юм
Их бүтээлийн замд чиг нэгтэй явдаг юм
Саятан жолооч баатрын машин дээр ч
Шатрын мастер эмэгтэйн ширээн дээр ч
Олны танил туужич зохиолчийн номон дээр ч
Онош алддаггүй эмчийн тамган дээр ч
Амьдайнхаа нэрийг хараад би баярлаж
Алдар хүндийг нь бишрэх сэтгэл төрөх юм
Ард түмэндээ хүч ухаанаа зориулдаг
Ажилсаг хүмүүстэй амьдай байхыг хүсэх юм
Дуудвал нэр нэг - амьдай байж
Дугтарвал хүч нэг - аварга болж
Дуулбал хоолой нэг - аялгуу нэмж
Дундаа бид нэг нэртэйдээ баясах юм
Хайрлан санах эх орон нэгийг учир
Хаана ч явсан монгол гэвэл аан? гэх
Хачин сонор чих нэгтэй төрснөө бодоход
Халуун элгэн монгол хүн бүр амьдай юм.
Эрх жаргалтай хүн ардын мянган нэр
Их бүтээлийн цол чимэгтэй мөнх нэр
Энэ л олон амьдайн нэр - миний нэр
Эндэлгүй сахих ариун алдар - Монголын нэр

ОРХОН ОХИН ХОЁР

Хундан улаан үүрийн туяанаар Орхоны эрэгт
Хувин барьсан охин инээн баяссаар ирлээ
Хувь заяа нэгийн учир Орхон охин хоёр
Хуучин, шинийн тухай ингэж ярилцахыг сонслоо.

Охин хэлрүүн:

Орхон ээж минь Та Түшээ гүн цолтой
Олон мянганы газар урсах зам холтой
Оргил хангайн бэл, энх талдаа ачтай
Орон нутгаа хайрлах энэ бие минь азтай

Хамгийн сайхан дуунд ээж хэмээн дуурсавч
Харин Таны зэрэг цол юунд эс нэмэгдэв?

Орхон хэлрүүн:

Дайн тулааны үед үрс юугаан хамгаалсан гэж
Дайсны цэргийн урдуур эрс ширүүн урссан гэж
Дайллага тахилга хийж, тийм цол хайрласан юм
Далан лангийн ембүү тэртээ эргээс хаялсан юм

Өгсөн цол нь харин, язгууртны хэргэм байлаа

Өргөсөн мөнгө нь хайран, ядуусын хөрөнгө байлаа

Түшээ гүн цолтойдоо бахархаад байх юм байдаггүй

Түмний ээж гэгдсэндээ баясаад баясаад бардаггүй

Айхтар үерлэж би, эрэг саваан халиагүй

Алдар горилж би, зэрэг нэмэхийг хүсээгүй.

Охин хэлрүүн:

Хөндий дүүрэн тариаланг ханатал нь усалж
Хүчит цахилгаан станцыг халтал нь хөдөлгөж
Хүн ардаа баясган, хөгжимтэй юм шиг шуугьж
Хөгжүүн нутгаа ундлан, хөхүүртэй айраг шиг шаагьж
Амрахыг үл мэдэгч ачит Орхон ээж минь
Амьдралын хамаг учир юунд байдгийг хэлнэ үү?

Орхон хэлрүүн:

Усны минь түмэн дуслыг цусандаа авч төрсөн
Удамт монголын үр, уран гоолиг охин минь
Ухаант хүний нийгэмд ээжээс илүү энхрийлэгч
Урьд хожид байхгүйг насан турш бодож

Дайсан хэрэв халдвал дарах чадалтай байхыг

Даваа саад таарвал, давах дадалтай явахыг

Даяар олны найрамдлыг дандаа үнэнч сахихыг

Дархан хүний ухаанаар эх орноо хөгжүүлэхийг

Амьдралын хамаг учир гэж эрин үедээ итгээрэй

Ашдын сайхан жаргал гэж ач үрсдээ хэлээрэй

Эндүү худалд итгээд - эзгүйрсэн Эрдэнэ - зуу

Эвдрэл хямралд автаад - эндэгдсэн Хар - хорум

Эв найрамдал түшээд - энхэжсэн Хархорин

Энэ байна, бэлхэн - эх түүхийн үнэн!

Орхон ээж нь умард хязгаарын уулс тийш

Октябрь гийсэн учрал ерөөлтэй улс тийш

Одоо ирээдүй хоёртоо хүн төрөлхтний итгэлтэй

Ойр дотно нөхдийн бүтээлд баясан урсдаг юм

Амрахыг үл мэдэх минь урсгал ихийн чадал юм

Алагчлахыг үл мэдэх минь угийн их жаргал юм

Усаа ширгээж би, эрэг болохыг хүсэхгүй

Угсаа сэргээж би, зэрэг нэмэхийг хүсэхгүй

Үүнийг тунгаан бодож, эх орныхоо төлөө

Үнэн ариун зүтгэлээр алдар хүндийг олоорой

Тэгж олсон алдар, арчивч ердөө арилахгүй!

Тэгж олоогүй «алдар», ачивч ердөө тогтохгүй!
Охин хэлрүүн:
Өнөр олны бүтээлийг мандалдаа тусгасан долгио
Үлгэр домгийн үнэнийг мянгантаа хэлсэн харгиа
Үтрэм дээрээс дуулдах алтан буудайн шаргиа
Үйлдвэр дээрээс сонсдох аварга машины доргио
Шим хураа өгсөн Орхон ээжийн минь дуу байна
Шинэ үеийн олондоо Орхон түшээ гүн байна
Түмнээ түшихийн чинээ түшээ сайхан мөрөн байна
Түүний утга гүн шигээ гүн цэнгэг усан байна

Яриаг сонссон миний адилтгал:
Орхон мөрний ингэж ярьсанд эргэлзвэл
Орхон нутгийн эмээтэй та уулзаарай!
Осолгүй үнэн ийм л үг сонсоод
Орхон хүн хоёрын амь нэгтэйг бодоорой!
Орхон охин хоёрын нэгэн хувь зохиол нь
Орхон охин хоёрын нэн яруу зохицол нь
Олон түмнээ гэсэн нийлэмж их бодол нь
Ондоогоор ер тохиохгүй ховор зураг байна
Охины үс хархан, үүрийн туяанд очтой
Орхоны ус хархан, үүрийн туяанд одтой
Охины царай өнгөлөг, үргэлж баяслын мишээлтэй
Орхоны цараа тунгалаг, үүрд баярын мяралзаатай
Охины бүтээл их, хүн бүхнээс сайшаалтай
Орхны бүтээл их, хөндий дүүрэн магтаалтай
Охины төрсөн ээж - монголын сайхан авгай
Орхоны гарсан эх - монголын сайхан хангай.

АЛЁША

Хөшөөг амьд юм шиг хийж чадсаныг гайхмаар
Хөөрхөн жаалхан цэргийн дүрийг хараад баймаар
Хөл доорхи уул нь болоод өргөж эвийлмээр
Хөгжүүн хот Половдив болоод үргэлж энхрийлмээр

Уулан дээрх энэ хөшөө баатар эх зоригтных
Уг алдры нь хэл гэвэл бахдам их зөвлөлтийнх
Уяран хайлж урласан хүмүүс нь Болгарынх
Утга учирт нь автаад уйлсан би монголынх

Өөрийн нь алдар нэр, хэн байсныг бүү мэд
Өргөсөн нэр нь Алёша гэдэг нь бүхэнд тод
Өөдөөс минь явсаар ирлээ, бүр дэргэд

Өөрийн дүү шиг үнсье гэтэл, тэр хол үүлэнд

Малгай бүс хоёрт нь таван хошуу товгор
Магад ялах итгэлтэй зоригт нүд нь торомгор
Манлайд нь яваа цогтой дайчны нуруу тэнэгэр
Магнайд нь гийх золтой баярын бодол дэлгэр

Атганд нь бараг томдсон автомат зэхээстэй
Алуурчныг бардам хядах сум нь эгнээстэй
Хөлөөрөө, дайсныг сунатал өшиглөсөн шинжтэй
Хүчээрээ, хортныг сөнөтөл дарсан янзтай

Татсан нум хөмсгөн дээр малгай нь хэлтгий
«Тайван цаг ирнэ» гэсэн мөрөөдөл нь илэрхий
Тэгшхэн мөрөнд нь шүргэн шүргэх үүл сэмэрхий
Тэртээ өндөрт баатар хүүгийн дүр нь эрэмгий

Үнэнч дайчны зүрх цохилоостойн билэгдэл
Өлмий дороос нь тунгалаг булаг урсмал!
Үүрд мөнхжих алдры нь өргөсөн бишрэл
Үүгээр ирсэн бүхэнд Алёшаг бодох дурсгал!

Ай хөөрхий, бага жаалхан Алёша минь дээ
Алс холын монголд ах дүү чинь бий дээ
Заяанаасаа тэр л ууланд мөнх ургасан гэлтэй
Зайсан толгойн оргилд цэргийн хөшөө сүртэй!

Алдар нар нь хэн байсныг бид мэдэхгүй
Алёша гэхэд буруу гэж хэн ч мэтгэхгүй
Аз жаргал авралцсаны нь огтхон ч мартаггүй
Ачтай тийм Алёша олон гэдэгт маргахгүй.

Удамт баатрын зүрх цохилоостойн билэгдэл
Утаагүй улаан гал монгол тулганд асмал!
Урагшаа гэж тэмүүлсэн хүслийн нь биелэл
Уулын орой дайчин туг нь мандмал!

Тэрслүү дайсныг хиар цохисон газар бүрд
Тэнд эндхийн хот тосгон талбай бүхэнд
Ачийг нь бодсон урчууд аль л ухаанаа зарсан
Амийг нь гээхгүй гэсэндээ амьд юм шиг хийсэн

«Нэргүй баатруудын» хөшөөнд бөхийж хүндлэхдээ
Нээрээ эд чинь Алёша гэж бүгдийг нь нэрлэхдээ
«Зөвлөлтийн» гэсэн нэгэн овогтойд нь бахархдаг
«Баатрууд» гэсэн нийтлэг алдартайд нь баясдаг.

ЦЭВЭГМИДИЙН ГАЙТАВ «1929-1979»

Ц.Гайтав 1929 онд Свэрхангай аймгийн Богд суманд төржээ. Бага дунд сургууль, санхүү эдийн засгийн техникум, УБДС төгсжээ.

Ц. Гайтавын «Шүлгүүд», «Улаан туг», «Гэрэлт хөшөө», «Дамдины Сүхбаатар», «Карл Маркс», «Фридрих Энгельс», «Сайхан эх орон» зэрэг шүлэг, найраглалын 30 гаруй ном хэвлэгдсэн юм.

Шилдэг бүтээл туурвисаны учир 1961 онд БНМАУ-ын төрийн шагнал, 1971 онд МХЗЭ - ийн шагнал, 1979 онд БНМАУ - ын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртжээ.

ЛЕНИНТЭЙ БИ ЯРЬДАГ

Хэний ч өмнө

Ленинтэй ярьдаг гэж

Хэлэх эрхтэйдээ

Бахархаж байдаг би.

«Хүрэн зандан»

«хаалгыг» нь нээгээд

Хүндэт багшийн

«тасалгаанд» нь би орлоо.

Сайхан магнай нь

сар шиг туяарч

Саруул нүд нь

од шиг гэрэлтэж

Мишээмэл царайгаар

Над еед инээгээд

Миний урдаас

Эелдгээр угтаад

Наашаа суу

хүү минь гээд

Намайг урилаа

Ленин багш.

Сур! Сур!

бас дахин сур гэж

Сургаж хэлснийг нь

ойлголоо би

Суут их чадалтай

сургаал үгийг нь сонслоо би

Үүнээс эхлээд би

Ленин багштай

Үргэлж ярьдаг

болсон юм.

Намын хvний тухай
 гишvvn над сургасан
Намч зохиолын тухай
 зохиолч над ярьсан
Хамгийн хэцvв асуултад
 хариултыг Ленин егдөг
Хазайж муруйх явдлаас
 хамгаалж намайг тvшдэг
Хvрэн өнгөтэй
 хавтсыг нь нээгээд
Бvрэн чадалтай
 зохиолыг нь уншаад
Ильич багштайгаа
 ингэж ярьдгийг,
Ихийн ихийг
 тvvnээс сурдгийг
Хэний ч өмнө
 Ленинтэй ярьдаг гэж
Хэлэх эрхтэйдээ
 бахархаж байдаг би
Аугаа Ленинтэй
 ингэж би ярьдаг
Ахиад нэг хэлчихье!
 Ленинтэй би ярьдаг!

УЛААНБААТАР

Уудам Азийн цээжинд
Ардчиллын од болж гялалзсан
Улс Монголын нутагт
Хөгжлийн зvрх болж сацарсан
 Москва хот ахтай
 Менген Туул эмжээртэй
 Менх жаргал бадраатай
 Миний хайрт Улаанбаатар
Байгуулах их ирээдvйгээ
Эрчимт хөдөлмөрөөр далласан
Бат нягт ардынхаа
Энхрий хайрыг булаасан
 Москва хот ахтай
 Менген Туул эмжээртэй
 Менх жаргал бадраатай
 Миний хайрт Улаанбаатар
Ханагар чөлөөтэй алхлахад

Эзэн бидэндээ бахдалтай
Хаа ч явж байхад
Ээжтэй минь адил санагддаг
Москва хот ахтай
Менген Туул эмжээртэй
Менх жаргал бадраатай
Миний хайрт Улаанбаатар

САЙХАН ЭХ ОРОН

Түмэн веийн
цасны ширхэг нь
болор болж гялалзаад
Төрсөн нутгийн
салхины ариун нь
түүнийг илж арчсан
Жигүүртэн шувууд
оройд нь хүрэмгвй
тэнгэр баганадсан
Жин хвйтэн
евел менх
ендер уултай
Зуун веийн
усны ундраа нь
менх оргилж
Зурж гаргасан мөр нь
вхэр чулууг
врэл шиг мелийлгөсөн
Хөнгөн салхины
хөл цуцах
урт мөрөнтэй
Он цагийн
ханхар цээж нь
чилшгвй тэнийгээд
Огторгуйн нарны
халуун илчийг
хөлс даатал шингээсэн
Замын урт,
дурангийн хараанд
зай тавьсан
Захаас захад нь
дуу чөлөөтэй
өргөн талтай
Сайхан энэ орноороо

Санаа дүүрэн бахархдаг би!

Мод нь ногоон,
цэцэг нь алаг
ус нь тунгалаг
Монгол нутгийн
салхи нь урин
тэнгэр нь цэлмэг
Говийн нь нар халуун
хангай нь тагт сэрүүн
Гоёо нь амттай
агь нь шимтэй.
Бороон сувд
цасан навчийг
байгаль нь соёрхоод
Боргоцойт самар
болсон жимсийг
дэлхий нь дэлгээд

Тогоонд загсаасан ерөм шиг
хужир шүүтэй
тойром бүрд
Тоонотой гэрийн буурины
хуучин ортой
толгодын энгэр
Далай гэмээр зэрэглээнд
даваа болж гүвээ
ендерлен харагдаад
Далан гэмээр тевиж
дардан харгуй нь
еөдөөс босоод
Ээх наранд
элэг нь гялалзаж
толь тусгаад
Эдүгээг хүрсэн
евген буурал
ханан хадтай
Сайхан энэ орноороо
Санаа дүүрэн бахархдаг би?
Сэрүүн хангайн хяр руу
Сэртгэр хамраараа
«Хөгжим» татаад
Сэлмэн эвэртэй сарлаг
Саваг хийсгэн
Бууж ирсэн
Сэргэлэн дэнж дээгүүр,

сэмжин үүлс доогуур
Хонь ямаа
Сэржигнэх салхи серж
идээшлэн бэлчсэн,
Шижир элсэн далайд
шир шир
Хөхрөх зэрэглээн
долгион дунд
Ширээ бөхтэй тэмээд
хелег онгоц санагдуулан
хөл тавьсан
Малчин хvн
малаа малладаг
уурга шилбvврээрээ
Мандах нарыг даллаж
жаргах нарыг
vдэж дадсан
Цагаан гэр
тооноороо бургилсан
цэнхэр угааг
Цагийн дөрвөн
улирал сарын
уур савсуулсан
Хөхөө өвөл
цасны нимгэнээр
зам зурайж
Хөхvүн зун
усны захаар
мал багширсан
Сайхан энэ орноороо
Санаа дvүрэн бахархдаг би!
Ам хөндийгөөр нь айл
суга бэлээр нь сум
Зам дарднаар нь машин
зай бvхнээр нь хөгжил
Тэнгэрийн оддын доор
эх нутгийн
ярайсан одод
Тээр дээр ч
дэргэд энд ч
ялгаагvй одод.
Бие биетэйгээ
хурц нvдээрээ
анивчин мэндэлж
Биндэръяа адил
өнгө зvсээ

харалцан баясаад
Гандан хийдийн
ганжир суваргыг
доор үлдээж
Яндан цамхгийн
ендер орой
дээр мандаад
Эртний монголын ч
эдүгээгийн монголын ч
эх нутаг минь
Эрэлхэг ардын
эрдэм чадлаар
хувьсан босжээ.
Сайхан энэ орноороо
Санаа дүүрэн бахархдаг би?
Байгалийн сайхан
баялгийн арвин,
хөгжлийн ихээр
Баярын совин
нүүрэнд минь дандаан
татуулж байдаг
хүн нь даруу,
хөдөлмөр нь яруу
хүүхэд нь өнөр
Хүсэл тэмүүлэл
хүч зориг
өвч бүрэн
Нэг нэгэндээ
туслахын сайхан
елзий бүрдэж
Цуг цагтаа
амьдарч ажиллахын
аз оршсон
Айл саахалт
ах дүүтэйгээ
Ам муруйдаггүй

Ардын сайхан
ариун уламжлал
цэлмэж гийсэн
Баруун Алтай
Зүүн хянганы хоёрыг
Алдлан байгаа
Баатар түмний
зүтгэл бүтээлийг
алтлан яваа

Сайхан энэ орноороо
Санаа дүүрэн бахархдаг би!
Умраас ирэх
 урин салхийг
 угтаж дассан
Ургамал бодисыг
 тэндхийн вүл
 тэтгэн соёрхсон
Хоймор талаараа
 хувьсгалын хаалгыг
 анх нээж
Хийморь цогоороо
 эх орноо
 мөнх гийгүүлж
Шинэ монгол
 шинэ эх орон
 туяарч гарсан
Шинийн нэгэн
 хорин нэгэн он
 хаярч ирсэн
Сайхан энэ орноороо
Санаа дүүрэн бахархдаг би!

НАМДАА ЄРГЄХ ҮГ

Настандаа хадаг
 найздаа цэцэг
 барьдаг журам
нарлаг монголын
 найман зүгийнхний
 нандин ёс
Намдаа шүлэг
 үгийн сувдаар
 хэлхэж ергөх
Найрагч хүний
 насан үүрдийн
 баяр бах
Хэлсэн үг
 бүхэнд минь
Хэлэх гэсэн
 үнэн санаа минь
Баатар намын
 гэгээн мэлмийд
Бадаг бадгаараа

гэрэлтэж хврээсэй!

««««

Ууланд нь цас
усанд нь мөс
тогтдог ч гэсэн
Ургамлын нь енгө,
улирлын нь зан
хувирдаг ч гэсэн
Дарь хvxрийн
бузар буртаг
биед нь наалдаагвй
Хир тортог
буруу vзэл
оюунд нь халдаагвй
Срген тэнэгэр
Монголын сайхан
эх орон
Сгеемер ачит
намынхаа хайраар
зврх нь халуун.
Үйлс шударга
монголын саруул
ард тvмэн
Сндер дээд
намынхаа ивээлээр
vзэл нь шулуун
Үvрийн улаан
туяа тусаад
еглее болоход
Үзэсгэлэн тегс
хувьсгалын тугны
енге бадраад
Үдшийн гялаан
од гялалзаад
шене эхлэхэд
Үvрдийн цогтой
ардын жавхаа
бас тодроод
Хорин дөрвөн
цагийн алинд ч
эх орон минь
Хорвоогийн дөрвөн
улирлын алинд ч
эгэл эх орон

Золбоо хиймориор
дандаан гэрэлтэж
явахын бэлэгтэй

Зорьсон вйлс
зөндөө бүтэж
байхан ерөөлтэй.

Нэгдэлч түмний
налайтал бэлчсэн
сүргийг харахад

Нэлэнхүй ургасан
тариаг ажихад

Үйлдвэрийн цехэд
велзтэл гаргасан
барааг үзэхэд

Үзсэн хичээлдээ
үнэлэлт сайтны
царайг тольдоход

Ажил сурлагын
бүх салбар дээр
хүн ардыгаа

Амжилт бүтээлийн
бүх самбар дээр
хүүхэд настныгаа

Шинэ үеийн
шижгэр эзэд гэж
биширч хайрлаад

Өнө үлдэх
шижир алтаар
бичмээр санагдана

Гэр нь цагаан
нэр нь ариун
нэгдэлч ардаа

Сүр нь өндөр
дүр нь даруу
ажилчин олноо

Сурагч оюутан,
эрдэмтэн мэргэд
аль алиныгаа

Сургаж хүмүүжүүлсэн
суут намдаа
баярлан бахархана.

«««

Малчин ардын

елгийд мэндэлж
хэлд ороод
Маркс Лениний
цагаан толгойгоор

хэлд ороод
Улсыг удирдах
залгуур жолоог
ултай барьж
Ухрахыг мэдэхгүй
хүрдийг нь ямагт
урагш залахдаа

Их Маркс,
Ильич Лениний
алтан дэнлүүг
Итгэл зүтгэлийнхээ
илч гэрэл
болгож асаагаад

Түмний түрүү
олны манлай
манай нам

Түүхийн далайд
онгоцоо мэргэн
олж жолоодоод

Замбараа байхгүй
феодалын хар
хог дундаас гарч

Заяа муутай
хөрөнгөтний есдгүй
лаг дээгүүр дүүлж

Тунгалаг өнгөтэй
социалист шинэ
нийгмийн далайд

Туг далбаагаа
содон хурц
хийсгэн зорьсон юм

Харь газраас
хар салхи
явах замд нь
саад тарьж

Хамжиж бас
дотоодын шуурга
явуулахгүй санаатай
садаа хийж

Замыг нь беглеж
зайг нь таглах гэж

хичнээн оролдсон ч
Зад цохиулаад
тэд еерсдее
хийсэж арилсан юм.
Гэрэлт социализмын
ерген далайд
сэлэн явах замд
Гэдрэг татсан
хувийн емч
бул чулуу шиг
Суут намын
урагшлах замд
бэрхшээл болж
Суурьтай бодож
буурьтай шийдэх
ухаан шаардлаа.
Мэргэн жолоодогч
Ленин багштай
нам маань зөвлөж
Мэдлэг дадлагын
далай их
давалгаа нэмж
Хорин нэгэн
онд хийсэн
хувьсгалтай тэнцэх
Хоёр дахь их
нэгдэлжих хөдөлгөөний
хувьсгал хийлээ.

Ариун социализмын
галт онгоцон дээр
ажилчин малчин
Алх деш
уурга шилбүүртэйгээ
хамтран сууж
Нэг бүлийн
зайгвй халуун
нөхөд болж
Нэг нь нийтийн
нийт нь нэгнийхээ
телее явж байна.
Тэр их
хвчирхэг онгоцны
залуур жолоог
Тэргүүн манлай

Манай нам
бат бариад
Цэлмэг тэнгэрийн доогуур
цэнхэр далайн дээгүүр
Цэвэр агаар
цэнгэлийн манлай
зорьж явна.
Мянган жилийн
монголын түүхэнд
хэн ч хийгээггүйг хийсэн
Мятаршгүй баатар
монгол ардын
хувьсгалт нам минь
Түших сайн
зөвлөлт түмэнтэй,
дэмжих сайн
дэлгэр нөхөдтэй
Төрсөн орны
заяаг холбож
замыг нийлүүлсэн
ачтан юм.
Намаар минь
дэлхий дахин
биднийг таньж
Намтраар минь
дэлгэр түүх
биднийг бичиж
Насаар минь
эрин цаг
биднийг хэмжиж
Найдвараар минь
эрхэмсэг коммунизм
биднийг угтаж байна.
Зовлонг
намтайгаа хамт
давж туулснаа
Золбоог
намтайгаа цуг
ергөж дуулснаа
Зоригийг намтайгаа нэг
Барьж ирснээ
Зогсохгүй
чамтайгаа урагш
баатарлаж явахаа
Намынхаа
өндөр саруул

тэргүүнд ёсолж
Намынхаа
свч бат
тэмцэлд бахархаж
Намын гишүүн,
намын хүүгийн
ёсоор бид
Намдаа ергэх
үг болгон
дэвшүүлж байна.

БҮРЭН ЭРХТ АРД УЛС МИНЬ

Аз жаргалын
Ариун елгий
Дэлгэр нутагтай
Ашид тунгалаг
Арчсан толь шиг
Цэлгэр тэнгэртэй
Алтан Соёмбо
Цацран гялалзсан
Гэгээн далбаатай
Ард нийтээр
Санаа хвчний
Бат холбоотой
Арвин дэлхийн
Шударга түмэнтэй
Ганзага цуг
Амгалан энхийн
Ариун жагсаалд
Гар нэг
Бүгд найрамдах
Бүрэн эрхт
Ард улс минь
Бүх дэлхийд
Нэр төрөө
ендер ергелее.
Тэнүүн орныг нь
үүрдийн наран
ээж гийгүүлсэн
тэмцлийн түүхийг нь
үндсэн хууль маань
гийж гэрэлтүүлсэн
Тэнхээ тамирыг нь

Хүчит нам
Хөвчилж өгсөн
Тэмүүлэх чадлыг нь
Хүн ард
Хөгжүүлж ирсэн
Дэвшлийн шатандаа
Хөрөнгөт нийгмийг
Алгасан гарч
Дэлхийд анх
Феодализмаас социализмд
Баттай хүрсэн
Бүгд найрамдах
Бүрэн эрхт
Ард улсдаа
Бүх нийтээр
Бүгд олноор
Бахархан баярладаг
Дарлах дарлагдах
ёсыг үүрд
халж хаяад
даяар тэгш
эрхийг үүрд
шилж олоод
буурал настны
магнай дандаан
тэнүүн явж
бумбагар жаалуудын
манцуй дандаан
дулаан байж
эх орныхоо
элгэн дээр
энх амгалан
энх төрийнхөө
энэрэл дор
энхжин жаргаад
Бүгд найрамдах
Бүрэн эрхт
Ард улс минь
Бүх олны
Бүгд нийтийн
Ачтан мөн юм.
Төрийн далбааныхаа
Улаан цэнхэр
Гэрэл доор
Төрж бойжиж
Төлжин өссөн

Эх орон
Гар нь ганзаганд
Хел нь дөрөөнд
Хэдийн хүрээд
Газрын бөмбөрцгийн
Хөгжлийн твшинд
Хэмжээ нэмээд
Зам нь товч ч
Тvvх нь дэлгэрэнгvй
Тvмэн нь бадрангуй
Заяа дээд
Залуур мэргэн
Манлай намтай
Бvгд найрамдах
Бvрэн эрхт
Ард улс минь
Бvх дэлхийд
Бvргэдийн дэвэлтээр
Дээшилж ирлээ
Уулын орой,
Талын эн
Усны мандлаар
Улаан наран нь
Нэгэн зэрэг
Нэлэнхvй туссан
Улирах жилийн
Дөрвөн улирал
Арван хоёр сард
Ундрах хөгжил нь
Жирийн ардын
Гараар жигдэрсэн
Урагшлах зам,
Ургах ирээдvй
Урдаас нь дандаан
Угтан авч
елзий тегс
еєд залсан
Бvгд найрамдах
Бvрэн эрхт
Ард улс минь
Бvх нийтээр
Эрин ve
Ирээдvй хойчид мандана.

ТӨРИЙН СҮЛД

Нарны сайхан цацралд
Морины жолоо залж
Хүрд араа хvнгэнvүлэн
Сорт тариа найгуулан
Бvгд найрамдах улсын
Бvрэн эрхт иргэн
Сайхан коммунизмын зvг
Санаа дvүрэн явна.
Цэнхэр тэнгэр дээр нь
Толь мэт мэлтийгээд
Цэлгэр нутаг дор нь
Торго мэт дэлгэгдээд
Ачит гэгээн төрийн
Алтан сүлдэн дунд
Алсын хурц хараатай
Ард хvн бараатай.
Челее, жаргал, эрхийг
Чедерлеж байсан нийгмээс
Суга vсэрч дvүлсэн
Суу алдарт тэр хvн
Тал нутгийн халх
Таван богдын казак
Буурал хэнтийн буриад
Булган голын торгууд
Тансаг монголын ард
Та, чи, би!
Таван тивийн тvмэнтэй
Тангараг нэг бид!
Хорин дөрвөн онд
Хотол даяар баталж
Ариун монгол нутагтаа
Алтан vсгээр бичиж
Yнэн эрхийн жаргалыг
Yй олондоо олгосон
Yндсэн хуулийн туяагаар
Yvр нь гийсэн тvмэн
Yндсэн хуулийн хавтас дээр
Yй тvмний гар дээр
Сонгогчийн vнэмлэх дээр
Сонгуулийн хайрцаг дээр
Төр улсын тамга дээр
Тvмний гавьяаны одон дээр
Нарнаас ойрхон гийсэн
Сарнаас саруул гэрэлтсэн

Төвшин энхийн хийморь
Төрсөн гэрийн хоймор
Заларч байдаг сүр
Төрийн иргэний хийморь
Засаг төрийн минь сүлд!
Туг далбаа хоёроо
Цуг дэргэдээ мандуулж
Нэг санаат ардынхаа
Цог залиг бадрааж
Даяар ялах коммунизмд
Биеэр хүрэх азтай
Ардын гэгээн төрийн
Алтан сүлд сацарч байна.

ПАРТИЗАН

Буурал сайхан үсээ
Жаргалын цагаан сүүгээр
Мялаалгасан юм шиг
Буянтай саруул царайгаа
Жаргалын гэгээн туяагаар
Гийгүүлсэн юм шиг
Авхаалж цогтой нүдэндээ
Аварга тэмцлийнхээ түүхийг
Анилгүй авчирсан юм шиг
Ардын хувьсгалын
Анхны партизан нар
Зогсож байна.

Элгэнд нь
Алаг зүрх нь
Баяртай цохилж
Энгэрт нь
Алдрын одонгууд
Наранд гялалзаж
Үндсэн ястан
үр ач нарынхаа
телее зангирсан
Шандас ихт
Тэдний булчин
Хүчтэй байна.
Ган, сэлэм,
Галт зэвсэг
Гартаа барьж

Гамин бароны
Галзуу этгээдийг
Бут ниргэж
Жанжин Сүхбаатар
Хатан баатрын
Гараар хүмүүжсэн
Жавхаатай энэ
Партизан нөхөд
Жаргал авчирчээ.

Угаасаа
Хувьсгалын төлөө
Төрсөн юм шиг
Багаасаа
Хувьсгалын галд
Ган шиг хатуужсан
Тэр хүмүүс
Хангайн нуруу шиг
Дүнхийж харагдаад
Тэнэгэр уудам
Халхын тал дээр
Ханхайж байна.
Ясаа амраах гэж
Хэзээ ч тэд
зүгээр суугаагүй
Тусаа нэмэх гэж
Хэзээ үргэлж
Зүтгэж ирэхдээ
Нам, төр
Ард түмнийхээ
Үйлсийн төлөө
Нас бие,
Хүч чадлаа
Үнэнч зориулжээ.
Партизан гэхэд
Хөндий тал
Уужраад ирэх шиг

Партизан гэхэд
Хүн ард
Дээш дээш залаад
Өлзийт үйлст
Өндөр их
гавьяа байгуулсан
Өвгөн настан
тэднийг дандаан

хүндэлж байна.
Пионерийн зүүсэн
Улаан бүчийг
Хүзүүндээ намируулсан
Та нарын хийморийг
Хөгшид хараад
Залуу болж
Залгах хойч маань
Алдрын тань сайхан
Зам мөрсөр
Засаг төрийнхөө
Ариун хэрэгт
Ааг нэмэх юм.
Дайн тулалдаан
Тайван энх
Аль ч цагт
Дайсантай тулж
Бэрхшээлийг ялж
Бэрхийг давсан
Хорин нэгэн оны
Ардын хувьсгалын
Ахмад партизанууд
Бүрэн эрхий минь
Бүгд авчралцсан
Бүргэд шонхорууд юм.

Он онд
Нэр нь мөнх
Дүр нь энх
Олон даяар
Сүр нь ендөр
Ач нь гүн
Их жанжин
Сүхбаатарын партизаны
Түмэн гавьяаг
Эх орон
вөийн вөд
дурсан хүндэтгэнэ!

ЗӨВЛӨЛТИЙН ХҮМҮҮСИЙН ДУНД ЯВАХАД

Гарыг нь барьж
Нэрийг нь олон
Дуулж дассан

Гал цогтой
Зөвлөлтийн хүмүүсийн
Дунд явахад
Элэг зүрхэнд минь
Ээх элч нь
Нэвт тусаж
Шүлэг зохиолд минь
Шүлт амт
Нэмэгдээд ирэх юм.
Ах нар гэж
Ардын минь нэрлэсэн
Учиртай үг
Эх орны
Нэрийн өмнөөс
Хэлсэн үг юм.
Бүх Зөвлөлтийн
Шулуун сайхан
сэтгэлтэй хүмүүс
Их багагвй
Халуун сайхан
Итгэлтэй хүмүүс юм.
Суут мэргэн
Ленинийг төрүүлж
Тэргүүндээ залсан
Сургаал үнэн
Үзлийг нь бадруулж
Тэмцэлдээ ялсан
Анхны социалист
Их гүрэн
Өргөн дэлгэр
Ариун хөгжил
Асар өндөр
Өлмий бат
Газар нутаг шигээ
Хүн ардын нь
Сэтгэл тэнэгэр
Гарынхаа илч шиг
Гүн халуун
Итгэл дүүрэн
Анд найз
Зөвлөлтийн хүмүүсийн
Дунд явахад
Алхаа хөнгөн,
Цээж цэх
Юутай сайхан бэ?
Хар буруу юм

Хаа хэзээ ч
Санаж яваагвй
Хайр сэтгэлтэй
Зөвлөлтийн хүмүүсийн
Дунд явахад
Харь гэдэг
Хачин вг
Оргож алга болоод
Гэр гэдэг
Ойр вг
Ургаж цэцэглэх юм.
Үндэс ястан нь
Үүдэн хоймор
Зайгвй дотно
Үйл ажил нь
Үзэл бодолтойгоо
Завсаргвй нягт
Даян дэлхийн
Тэнхээ тамир
Зөвлөлтийн хүмүүсийн
Буян заяагаа
Бурхнаас биш
Бултаараа олжээ.
Тунгалаг талст шиг
Манай найрамдлын
Яруу гэрэл
Туулсан замыг минь
Насан елзий
Сөд хетелж
Хоцорсон монголыг
Сацарсан монгол
Болгож өгснийг
Хорвоо ертенц
Хотол даяар
Андахгвй мэднэ.
Улаан Москвад ч би
Зөвлөлтийн хүмүүсийн
Дунд явлаа
Улаанбаатарт ч би
Зөвлөлтийн хүмүүстэй
Хамт явлаа.
Хаа ч бол хаа
Зөвлөлтийн хүмүүс
Тулах багана
Туслах хань
Хамгийн энгийн

Хань нөхөр
Халуун элгэн
Немер болж байна
Зөв буруугаа
Цус хөлсөөрөө
Түүхэнд шалгасан
Зөвлөлт – монголын
Бат найрамдлыг
Бахархал болгон
Бичнэ би!
Гарыг нь барьж
Нэрийг нь олон
Дуулж дассан
Гал цогтой
Зөвлөлтийн хүмүүсийн
Дунд явахад
Тулах ийм
Түшигтэй гэж
Сэтгэл өөг
Туслах ийм
Ханьтай гэж
Итгэл дүүрэн!

ЯРУУ НАЙРГИЙН ГАЛЫН ДЭРГЭД

Яруу найргийн
галын дэргэд
Яралзтал жагсъя цемсээр!
Том бага гэлтгүй
Тойрон зогсё бөгдээрээ!
Өндөр нам гэлтгүй
Өргөн нарийн гэлтгүй
Дугаар байхгүй эгнээгээр
Дугуйран зогсё хамтаараа!
Яруу найраг ч
биднийг бадраана.
Яруу найргийг ч
бид бадраана
Улам гэрэлтэх
Ухаанаа заръя!
Улаан дөлий нь
Туяаг цацраа!
Түүдгийг минь анх
Хэн асаасныг

Тvvхээрээ бид
Сайн мэднэ.
Хелд орж байгаа
Найрагч ч наашаа!
Хөгшин буурал
Найрагч ч наашаа!
Яруу найргийн
галын дэргэд
Яг нэг
эгнээнд зогсьё!
Уриа бол
Ухрахын нэр биш
Урьдах хойтохоо
Хаяхын нэр биш
Улс нийгмээ
Хамтран бадраахын
Учиртай сайхан
Билэгт нэр юм.
Яруу найргийн
галын дэргэд
Яралзтал жагсья цемеерээ!
Дугаар байхгvй эгнээгээр
Дугуйран зогсьё хамтаараа
Үзлээрээ гал бадрааж
Үзгээрээ дел сацрааж
Яруу найргийн
халуун галд
Хуруу нэмж
Хувиа оруулья!

ЯЛАЛТ

Урин хаврын
Улаан наран
Дорно тэнгэрээс
Мандаж гарахдаа
Урд байгаа
Хуанли дээр
Улаан тоо
Дагуулж ирлээ.
Мартагдах аргагvй
Дечин таван оны
Таван сарын есний
Мандсан ялалтыг

Цусаар бичсэн
Улаан тоо гэрэлтлээ.
Сая сая хвний
Урсгасан цусны
Улайдмал ган болсон
Салахын аргагвй
Хайлахын эрхгвй
Энэ тоо
Нүргэлсэн их
Тэмцлийн цараар
Биеэ тэлээд
Нүдэнд багтахгвй
Тэнэгэр болж
Дэлхийг бүрхжээ.
Шимширч евдсэн
Бум буман
Хвний зүрхнээс
Ширмэн бембегний
Шивж орсон
Хэлтэрхийг авч
- Дахиад чи
Хвний зүрхэнд
Бүү ор! Гэж
Дайнтай нь чулуудсан
Энэ тоо
Их ялалтын
Илд юм
...Хар угаан доогуур
Харжигнах танкууд
Сүртэй мелхеж
Хас тэмдэгтэй
Фашистын цэргүүд
Сүүдэр шиг нүүж
Хүчин үзсэн
Нисэх онгоцууд
Тэнгэрт орилолдсон
Дечин хоёр он
Зүүд адил
Толгойд орлоо
Москвагийн дэргэдээс
Мелхехийг нь гэдрэг
Зад ухрааж
Мергеж унатал
Мехелийг нь ойртуулан
Бут ниргэж
Мэс жадыг нь

Улаан арми
Хуга цохиж
Хас тэмдгийг нь
Улан дороо
Хог болгож
Хүндийг давж
Берлин хүрэх
Урт замд
Хүч төгс
Зөвлөлтийн арми
Урагшилж давшаад
Баруун зүг
Үй түмэн
таван хошуу гялалзан
Бараан хар
Тэнгэр доогуур
Таван тив
Харагдаж байна.
Батгана шиг бужигнасан
Фашистын онгоцыг нь
Газарт зоож
«Барс» гэгч
Барддаг танкны нь
Гавлыг нээж
Хүн араатан –
Цэрэг армийг нь
Бахардуулан хеесэн
Хүчирхэг зөвлөлтийн
Улаан цэргийн
Уухай сонсогдлоо.
Катушийн амнаас
Суга үсэрсэн
Сумнууд харваж
Кавказ, Украинд
Хас толгойтныг
Хохимой толгой болгож
Тэнгэр газраар
Фашистын армийг
Яйргал цохисон
Тэнхээт ялалтын гар
Тивээс тивд ирж
Гар барилаа.
Хурдан агтныхаа сайныг
Зэлэн дээрээсээ
Барин авчирч
Хувцас хунарынхаа дулааныг

Бэлэн зэлэн
 Үйлдвэрээсээ ачаалж,
Хуруувч хийж
 Уран хvvхнvvд
 Юм оёод
Тvрийвч нээж
 Тегрег менге
 Цем зэхээд
Балчир бага,
 Хөгшид настан
 Хамаг олноор
Баатар зевлелтдее
 Гар сунгаж
 Бэлэг илгээхдээ:
- Яргачин фашистыг
 Бут ниргэхэд
 Буу зэвсэг бол! гэж
Ялахын итгэлтэй
 Ереэлийн vгээ
 Хэлж байх дуулдлаа
Дөрвөн жилийн
 Их дайны
 Дэгдсэн тvймэр унтарч
Тvвшин цагийн
 Эх булаг
 Дэлхийн хоймор ундарч
Ялсан баатруудаа
 Эх эхнэр,
 Хvvхэд цэцгvvд тэвэрч
Ялалтын одонгууд
 Эрvvл, шархтай
 Олон цээжинд
 Зэрэг гялалзлаа.
Алтан Москвагийн тэнгэрт
 Улаан бадамрагнаас нь
 Гэрэлт очууд сацарч
Ачит Лениний
 Ухаант царай
 Улам баясалтай мишээж
Аугаа ялалтын
 ёслолын сvрт
 буудлагын дуу
Алдарт «Аврорын»
 Дvv болж
 Дvvрэн цуурайтлаа.
Эхийн нvдний

Доголон нулимс
Ялалтын гэрэлд
Эцгийн сэтгэлийн
Доторхи гуниг
Ялалтын туяанд
Баярын нулимс,
Баярын сэтгэлээр
Байр сольж
Баатар зөвлөлт
Бат орон,
Бат гүрэнд зоригжууллаа.
Уриг хаврын
Улаан наран
Дорно тэнгэрээс
Мандаж гарахдаа
Урд байгаа
Хуанли дээр
Улаан тоо
Дагуулж ирлээ
Мартагдах аргагвй
Дечин таван оны
Таван сарын есний
Мандсан ялалтыг
Цусаар бичсэн
Улаан тоо гэрэлтлээ.
Арван долоон оны
Арван нэгэн сарын
Долооны едрийн
Тоотой адил
Аргын улирлуудын
Алдар гавьяаны
Алтан хуудасуудын
Элгэн дээр
Таван сарын
Есний едрийн
Улаан тоо
Улаан од болж
Таван тивийн
Цусан барилдалгаатны
Хуанли дээр
Хуучрахгвй гялалзана.

ДОЛГОРЫН НЯМАА

Долгорын Нямаа 1939 онд Дундговь аймгийн Ёлзийт сумын нутагт малчны гэрт төржээ.

Д.Нямаа бага, дунд сургууль, Улаанбаатар хотноо хvн эмнэлгийн техникум, 1966 онд ЗХУ – д М.Горькийн нэрэмжит утга зохиолын дээд сургууль төгсөж « Тэнгэрийн хаяа », « Их газрын чулуу» , « Тэмээний нутаг» , « Шинэ тэнгэр » зэрэг яруу найргийн ном хэвлүүлжээ.

Яруу найрагчийн шvлгvүд орос, болгар, чех, югослав, япон, узбек, эстон, халимаг, буриад зэрэг хэлнээ орчуулагдсан байна.

Д.Нямаа «Тэмээний нутаг» яруу найргийн ном бичсэний учир 1974 онд Монголын зохиолчдын эвлэлийн шагнал хүртжээ.

ЭНД НАМАЙГ ИРЭХЭД

Энд намайг ирэхэд
Тулгын чулуу ч байгаагvй газар
Туулайн бvжин унтаж байсан гэж
Эрдэнэтийнхэн ярих юм.

Энд намайг ирэхэд
Хээрийн салхинд хаяа нь дэргэсэн
Хэдэн майхан , бас хайгуулчид байсан гэж
Эрдэнэтийнхэн ярих юм.

Энд намайг ирэхэд
« Социалист Эрдэнэт хотыг энд барина » гэсэн
Содон харагдах тэмдэг байсан гэж
Эрдэнэтийнхэн ярих юм.

Энд намайг ирэхэд
Сургуулийн барилга сая эхэлж
Суурийн чулууг нь тавьж байсан гэж
Эрдэнэтийнхэн ярих юм.

Энд намайг ирэхэд
Нацагдоржийн гудамжны
Наймдугаар байшинд гэж хvн гэрээ заасан
Эрдэнэт байлаа.

Энд намайг ирэхэд
Нэрт дуучин Виктор Харагийн дуу
Нээлттэй цонхоор нисэж чихэнд унасан

Эрдэнэт байлаа

Энд намайг ирэхэд
Хайгуулчийн тосгон, ажилчны клубт
Хамгийн сүүлчийн шинэ кино гарсан
Эрдэнэт байлаа

Энд намайг ирэхэд
Байгал-Амарын төмөр замыг
Байгуулж байгаа нүргээн чимээ нь сонсогдсон
Эрдэнэт байлаа

Энд намайг ирэхэд
Өндөр хүчдэлийн ган шонгууд
Өдөр шенегүй Ильичийн гэрэл тээсэн
Эрдэнэт байлаа

Энд намайг ирэхэд
Аварга том Белазын бүхээгт
Алёша Бор хоёрын нөхөрлөж жолоо залсан
Эрдэнэт байлаа

Энд намайг ирэхэд
Амаржих газар сая төрсөн хүүдээ
Аав нь Ган-Эрдэнэ гэж нэр өгсөн
Эрдэнэт байлаа.

Энд намайг ирэхэд
Огторгуйн цэнхэр дэвсгэр дээр
Октябрийн яруу алдар гэж нарны гэрлээр бичсэн
Эрдэнэт байлаа.

ХҮРЭЭТ ГУАЙ УЛААН ТАЛБАЙД

Хүрээт гуай Улаан талбайд
Хүрч ирсэн зогсож байна.
Зүүдэлсэн юм шиг итгэж ядан
Зүг зүг тийшээ харж байна.

Хээр талдаа дууг нь сонссон
Кремлийн цаг уянгалан цохилж
Гайхам тунгалаг тэр дуу нь

Газар дэлхийд дуурсаж байна.

Тэнгэрийн хаяанд Хврээт гуай
Тэмээгээ хариулж суухдаа
Холын Москвагийн цагны дууг
Хоногтоо хэд сонсдог байсан юм.

Єнеедер гэртээ хэн буусныг
Єдертеє бараг мэдэхгвй хэрнээ
Тэртээ Москвад юу болсныг
Тэрхэн дор нь олж сонсдог юм.

Хашаатын хендийн усан цэнхэр...
Хааш хаашаа уужим цэлгэр...
Тэнгэрийн хаяаг холдуулан тууж
Тэмээ мал бэлчих нь үзэсгэлэнтэй.

Нам жим талын гvнээс
Нарийн шингэн эгшиг vвсч
Чихний vзvврт дуулдахын тедий
Чимээ ергех нь сонсоход уянгатай

Тэнгэр уужим
Тал бас уужим
Тэр хоёрын аль нь уужим юм
Мэдэхгвй.

Тэнгэр ендер
Тэмээ бас ендер
Тэр хоёрын аль нь ендер юм
Мэдэхгвй.

Хєх тэнгэрт
Говийн нар тогтуун
Хендий талд
Тэмээн сvрэг тогтуун.

Зээр гєрєєс
Хvний нvд дагуулж
Зэрэглээн дунд
Тоос ергєн алга болно.

Аглаг хээрийн
Анир амьсгал гэмээр
Халуун амьдралын
Хань бараа гэмээр

Галын шинэ угаа
Газраас ургав бололтой
Цэх дээшээ
Цэнхэрлэн хєсрєв.

Хвлээн авагчаар
Єерийн Москваг чагнан
Хврээт гуай энд
Үдийн цайгаа чанадаг юм.

... Тийм холоос Улаан талбайд
Тэмээчин хvн ирчихсэн явдаг
Чимэгтэй яруу цагны нь дуу
Чихэн дээр яг уянгалж байдаг.

Хvний зам урт юм гэж
Хврээт гуай энд бишрэн бодов
Тvvнээс цааш эх орон
Тvvх намтраасаа эргэн санав.

Он жилийн уртыг туулж
Олныг хэдий vзсэн ч гэлээ
Улаан Москвад ирнэ гэж
Ухаан санаанд ороогvй юм.

Ийм газар хєл тавьж
Их Лениний мавзолей vзэж
Євдєг тэнvvн алхана гэж
Євгєн болтол зvvдлээгvй юм.

Улаан талбайд Хврээт гуай
Удаан зогсож хармаар санагдав
Оргил Кремлийг ширтэн байж
Олон юм бодмоор санагдав

Тоононы нар буухын ємнє
Уяан дээрээсээ мордсон юм
Тогоотой цай буцлахын зуур
Улсын хил давсан юм

Хоёр нарны хооронд багтаж
Холын Москвад ирдэг байна
Хоногийн зєрєєг vзэж амжилгvй
Улаан талбайд буудаг байна

Тэмээний нутгаас Улаан талбай
Тэнгэрийн од шиг хол байх юм
Хайрлан суухад Улаан талбай
Халуун зүрхэнд ойр байх юм

Монгол нутгаас Улаан талбай
Мориор хүрэмгвй алс байх юм
Хүрээд ирэхэд Улаан талбай
Хүний зүрхэнд ойр байх юм

Хээр талдаа дууг нь сонссон
Кремлийн цаг уянгалан цохилон
Гайхам тунгалаг тэр дуу нь
Газар дэлхийд дуурсан тарав.

« Дэлхийн том цагны дууг
Дэргэд нь ирж сонсов» гэж
Орчлонгийн зайд жаргал зарладаг
Октябрийн цагийг бахархан харав

Бугуйн цагаа Хүрээт гуай гаргаж
Буурал Кремлийн цагтай тааруулав
Монголын тэмээчин ардын цаг
Москвагийн цагтай яг таарав.

РАЗЛИВ НУУР

Үзээгвй байхдаа Разлив нуурыг би
Үзсэн юм шиг санадаг байв

Торгон зах нь хүнд харагдахгвй
Том нуур бий гэж боддог байв
Ажилчин Емельянков сайхан сэтгэлтэй
Амьдарч суудаг жижигхэн байшинтай
Разлив нуур зөөлхөн долгиотой
Архан талдаа өвсөн овоохойтой

« Хаана байна. Ленин » гэж
Харгис засгийнхан эргэдэг байсан юм.
Нууцхан анир гарах нь уу гэж
Нуурны долгиог чагнадаг байсан юм.

Хээрийн бяцхан энэ нуур тэгэхэд
Хэнд ч нууцаа алдааггүй юм

Их Ленинийг дайснаас нуусан
Ийм нуур дэлхийд байдаг юм
Тэгэхээр Разлив хамгийн том нуур
Тэрнээс том нуур би мэдэхгүй юм

САМАРКАНДЫН ШЕНЕ

Сар чанх дээр нь хонодог
Самаркандын шене тагтан дээр суухад
Салхи сэм сэмхэн үлээж
Сайхан арц модны үнэрийг над авчирна.

Дэлхийн гэрэлт цэг Самарканд гэж
Дээр веес нүдэнд туссан газар
Дорно дахины их шүлэгчдийн
Домог цуутай яруу найргийн елгий

Намрын сарны саруулд
Намайг танихгүй евген хот налайна
Багил ногоон цэцэрлэгийн дунд
Багачууд хvvхнvvд дуу аялна.

Эрдэнийн чулуун хана туурга
Эртний тvvхийн чулуун хуудас
Үзэмж тансаг Самаркандын шене
Үлгэрийн юмс амилж ирэх шиг болно

Сайхан терсен Биби-ханум
Сарны гэрэлд туяа татуулан явна
Тvмэн боол чулуу vvrэн бөхийж
Тvvний урдуур цувж енгөрөх vзэгдэнэ

Этгээд холын аян дайнаас тэр
Эр нөхрөө ирэх дөхсөнийг санана
Харш ордоо гүйцээж эс чадвал
Хаан эзний уур хилэн бадарна

Тvргэн улирах хоног өдрийг дагаж
Тvгшvvр аймшиг хаяанд бүр ойртоно

Ууртай хаан тоос татуулан ирвэл
Уран Мамуржаны хар толгой енхерне

Биби-ханум:

Харь холын аян дайнаас
Хань нехер минь ирэх боллоо яана
Алд биеэ үнэний тангараг няцвал
Амь нас аюулд учирна яана

Мамуржан:

Хатагтай минь та миний үгийг сонс
Харш ордыг би товлосон едрее гүйцээнэ
Зүйргүй хеерхен Биби-ханум чи л
Зүрх сэтгэлээс гарахаа болилоо яана

Биби-ханум:

Эр нехертее хатуу тангарагтай
Эхнэр хүн намайг та ершсене үү
Хэдэн мянган боолынхоо дундаас би
Хэн дуртайг чинь танд егье

Мамуржан:

Санаанд оромгүй сайхан хүүхэн
Самарканд хотод еер байхгүй
Би хараагүй хеерхен хүүхэн гэвэл
Биби-ханум чи шүү дээ

Биби-ханум:

Будагтай ендегнүүдийг та хар
Бусдаас ялгарах енге енгийн хэрнээ
Бүгдийг хагалж үзвэл аль нь илүү байх вэ
Бүсгүйчүүл гэдэг ийм юм шүү дээ

Мамуржан:

Адилхан энэ хоёр жүнзэнд та
Архи ус хоёрыг нэг нэгээр нь хий
Халуу оргиж аль нь амыг согтоох вэ
Хайр гэдэг ийм шүү дээ

Ене эртний домогтой Биби-ханумын сүм
Енее хүртэл алдартай уран ядуусын бүтээл

Гарах хаалганд ургасан тоорой модны хаяагаар
Гадаад холын жуулчин толгой сэгсрэн цувжээ

Үлгэр домгийн мянга нэгэн шенийн
Үргэлжлэл гэмээр Самаркандын шене
Холхи оддын тэртээ гал гялалзаж
Хоёр замд онгоц яваа үзэгдэнэ

Дэлхийн гэрэлт цэг Самарканд гэж
Дээр веес нүдэнд туссан газар
Дорно дахины их шүлэгчдийн
Домог цуутай яруу найргийн елгий

Сарны доор яруу найрагч олон
Самарканд хот энэ дэлхийд ганц
Дурсгалт Самаркандыг үзээгвй бол
Дуулал шүлгээ дуусаагвй найрагч

ОСВЕНЦИМД АВАХУУЛСАН ГЭРЭЛ ЗУРАГ

Освенцимд авахуулсан гэрэл зураг минь
Ондоо хvн шиг гарчээ
Нvврэнд сvүдэр унаж
Нvдэнд дайсан үзэгджээ

Харагдах л юм, Освенцим
Халуун тамын Освенцим
Ширvүн улаан гал тэр!
Ширмэн хар зуух тэр!

Үзэгдэх л юм, Освенцим
Үхэл зовлонгийн Освенцим
Хvvxнvүдийн хайран гээг тэр!
Хvvxдийн ерeсeн бойтог тэр!

Санагдах л юм, Освенцим
Саяын тэр Освенцим
Дечин гурван он тэр!
Дервен сая хvн тэр!

Бодогдох л юм, Освенцим
Болж eнгeрсeн Освенцим

Звйргвй хэргийн мөр тэр!
Зврхэнд орсон сум тэр!

Освенцимд авахуулсан зураг минь
Ондоо хvн шиг гарчээ.
Нvүрэнд сvүдэр унаж
Нvдэнд дайсан vзэгджээ.

ТООНО

Хорол тооно барьсан хvнтэй
Хотод би гэнэт таарав
Удахгvй барих гэрийн тухай
Урамтай бодол надад төрөв

Тэр тоонын том гэдэг
Тэнгэрийн нар бүтэн багтана
Барьсан хvний нь залуу гэдэг
Харсан хvн цем бахадна
Гэрээ баривал говьд бариарай
Гэгээн тэнгэрийн нь тооноор хараарай
Мал авбал тэмээ аваарай
Манай нэгдлийн гишvүн болоорой

Сайхан говийн нар нь том
Саруул тооно танд хэрэгтэй
Загийн говийн тэмээ нь олон
Залуу хvн тэнд хэрэгтэй

ОЮУТНЫ ХОРОО

Хэцvү гантай тэр жил
Оюутнууд энд хороо барьжээ
Хэцийн чулууг адуу шиг нурааж
Хажуу газар зееж барьжээ.

Нам гvмхэн толгойн евэрт
Хvн амьтан гэнэтхэн бууж

Нарнаас емне нэг еглее
Хүрз жоотуу хангинасан байлгвй.

Газар газрын хүний үрс
Гараа гарган хороо барих гэж
Этгээд халуун зуны наранд
Энэ чулууг зеесэн байлгвй.

Нураасан чулуу зеегсгвй нь лав
Нуруу биеэ наранд шатааж
Хондны захаар гортиг татан
Хороогоо эхэлж ерсен байлгвй.

Магадгвй бас холын нэг нь
«Манай тэнд сайхаан» гэж
Хүний газар нутгаа магтан
Хүнд чулуу үүрсэн байлгвй.

Хүчээр мөхөс нь ергөсөн чулуугаа
Хүргэж чадалгвй зуур алдаж
«Амь нь хаанаа явдаг юм» гэж
Амьтны тохуу болсон байлгвй.

Бееренхий чулуу ховх татаж
Беен вймээн гэнэт дэгдэж
Энд тэндээс гвйлдэн цуглахдаа
«Энд могой, могой» гэж шуугьсан байлгвй.

Цуглаан хийж дүнгээ гаргаад
Уралдаан авсан бригад гэж
Чулуун хорооны нэг үзүүр дээр
Улаан туг дэрвэсэн байлгвй.

Хеерхен охинтой нэг нь танилцаж
Хөвөнтэй бээлийгээ ээлжээр өмсөж
Хоног хоногоор ойртон дассаар
Хотод очоод гэрлэсэн байлгвй.

Майхны дэргэд гал асааж
Май тавин цайгаа чанаад
«Буцаллаа цайгаа уугаарай» гэж
Бусдыгаа тэндээс дуудсан байлгвй.

Хааяа энд баяан хангинаж
Хайрган дээгүүр бүжиг эргэж
Оюутан тэдний дуулан байхыг

Ойрын айлууд чагнасан байлгвй.

Хэцүү гантай тэр жил
Оюутнууд энд хороо барьжээ
Хэцийн чулууг адуу шиг нурааж
Хажуу газар зееж барьжээ.

Нарны халуунаас таслан авсан шиг
Намрын хонд бүлээхэн байна
Насныхаа халуунаас таслан өгсөн шиг
«Оюутны хороо» дулаахан байна.

ИХ ТАМИРЫН ХЕНДИЙД ТЭНГЭР ДУУГАРСАН ШЕНЕ

Тас хийж
Тэнгэр дуугарах эгшинд
Тамирын гол
Цалгин цалгин одов.

Тамирын голд
Тэнгэр дуугарсан шене
Тайхар чулуу доргин доргин суув.
Малгай шүүрэх
Шенийн ширүүн салхинд
Майхан газраас
Тасран завдан байв.

Их Тамирын хендийд
Тэнгэр дуугарсан шене
Хадтай хангайн уулс
Цууриа татан хонов.

ӨНДӨР ГАЗАР

Өндөр газар
Өөр юм....
Өвөл зун хоёр
Айл байх юм.

Гэнэтхэн энд
Цас орох юм
Гэрийн тооноор
Үүл унах юм.

Ёндер газар
Ёер юм....
Од чулуу хоёр
Ойр байх юм.

Сарлаг энд
Ёндерт асах юм
Сартай хамт
Хээр хонох юм.

НЯМБУУГИЙН НЯМДОРЖ

Нямбуугийн Нямдорж 1934 онд Хэнтий аймгийн Батширээт сумын нутагт малчны гэрт төржээ.

Бага дунд сургууль, ЗХУ – д М.Горькийн нэрэмжит утга зохиолын дээд сургууль төгсжээ.

Н.Нямдорж «Үүлэн бор», «Онон хангай ээжий», «Хөдөө», «Хөвч», «Хүн чулуу» зэрэг яруу найргийн ном хэвлүүлжээ.

МИНИЙ АРД ТҮМЭН

Босгоны ёроолд
Боол мэт
Бохирч суухаа больж,
Хаалганы аманд
Харц гэгдэж
Хавсарч суухаа байж
Хувьсгалаар хувьсаж
Хувь заяандаа эх орондоо
Дархан эрхт эзэн болон
Дархлагдсан миний ард түмэн!

Мөнгөн цагаан гэрийнхээ
Мөөгөн хүрээ шиг зайд
Цэцэн цэлмэг ухаанаар
Цэвэр тунгалаг сэтгэлээр

Дундгвй дvврэн
Дутмаггвй хангалуун
Ахиухан хийж
Арвихан авч
Амьдралаан тегс утгаар нь
Авч явах боллоо.
Хvvxэд бvхэн маань сургуульд,
Хегшид бvхэн маань тэтгэмжинд
Нам тер маань ард иргэдээ
Нар шиг халуун ивээж байна.
Хайр ихт терийнхее
Халамж хvртээгвй хvн vгвй.
Энх энэ засгийнхаа
Энэрэлд ивээгдээгвй зон vгвй.
Хvн бvхний
Хvсэл сэтгэл
Хvчтэй болж
Хvндтэй болж
Ард бvгдийн
Ажил вйлс
Ахицтай болж
Алдартай болж
Ажилласан бvхэн
Ахуй цагийнхаа бахархал баатар
Олныхоо омгорхол болон яригдаж
Олныхоо сvр болон дуулагдаж байна.
Эд нар цем
Их нэр терийг
Хулгайлж олоогвй
Худалдаж аваагвй
Хуйвалдаж гараагвй
Энгvvn их зvтгэлээрээ
Илvв тод ялгарсан юм.
Ажилласан бvхэн
Ахуй цагийнхаа бахархал баатар болон
Нvвр бардам алхалж
Нvд дvврэн харагдаж
Сэтгэл дvврэн санагдана.
Хэлсэндээ ч эзэн
Хийсэндээ ч эзэн
Хариуцсандаа ч эзэн
Хаа ч эзэн болж
Явал хелсее, хvчээ гаргаж
Явал ихийг бvтээх вэ гэсэн
Яруухан омог санаа хvн бvхний
Яс маханд хадаастай бий.

Миний ард түмэн
Ийм л улс
Миний эх орон
Ийм л иргэдтэй орон.
Ажлыг алдаршуулсан
Ажилчин бvгдийг алдаршуулсан
Алдар гавьяаны их зуун
Агуу их ve минь мандтугай.

ЯВЛАА ДАА

Явлаа даа...
явлаа даа...
явлаа даа...
Яагаад ч сэтгэл минь тогтохгvй нь
Унасан нутгийнхаа хавартай
Учрахаас нааш болохгvй нь
Нарлаг сайхан нутаг минь
Намайгаа гэнэт дурсав уу
Сөгшин дассан газраа би
Серийн эрхгvй vгvйлэв vv
Яагаад ч сэтгэл минь тогтохгvй нь
Явлаа даа...
явлаа даа...
явлаа даа...
Буцлаа даа...
Буцлаа даа...
Буцлаа даа...
Бухимдсан сэтгэл минь тогтохгvй нь
Бууралхан ээжийнхээ дугараанаас
Булхаж л гарахгvй бол болохгvй нь
Сэтгэлээр сайхан ээжий минь
Сэмхэн намайг дурсав уу.
Уулаас санах ээжийгээ би
Ухаандаа гэнэт vгvйлэв vv.
Бухимдсан сэтгэл минь тогтохгvй нь.
Буцлаа даа...
Буцлаа даа...
Буцлаа даа...
Харилаа даа...
Харилаа даа...
Харилаа даа...
Хайрхан сэтгэл минь тогтохгvй нь
Халуухан насныхаа амрагтай

Харалцахаас нааш амрахгвй нь
Гэнэхэн насны минь дурлал
Гэнэтхэн намайгаа дурсав уу
Арванхан хэднийхээ дурлалыг
Алагхан зүрх минь үгвйлэв үү.
Алагхан зүрх минь
Хайрхан сэтгэл минь тогтохгвй нь
Харилаа даа...
Харилаа даа...
Харилаа даа...

НЕРУДЫН ОРОН ЧИЛИ

1.

Андын урт нуруу шиг
Асар урт
Андын ендер нуруу шиг
Аймшигт ендер
Тэнгэрлэг сайхан
Тэр орон
Нерудын орон
Найргийн орон
Альендын орон
Амгалан орон
Чилийнхний эх орон
Чили байлаа.

2.

Чилийн газар шорооны
Чийг нь шим нь
Шимж ургасан бүхэн нь
Чили - чинийх
Чили хэзээ ч ийм
Чили байгаагвй
Чили
Чилидээ яг хүрэх гэсэн,
Чили
Чили ёсоороо болох гэсэн
Орны царай
Ондоо байлаа
Олны сэтгэл
Оргилуун байлаа.

3.

Энэ орны чулуу нь
Эгэл хөх тэнгэр нь
Ээх сайхан нар нь
Эвдрээгвй бүтэн байлаа
Талын ялдам цэцэг нь
Тариа будаа ургац нь
Тансаг хот суурин нь
Тайван сайхан байлаа.
Цэцэрлэг сургууль хvvхэд дvvрэн
Цэнгэлдэх хvрээлэнд суудал дvvрэн
Хагас юмгvй энэ орны
Хамаг бүхэн нь бүтэн байв.

4.

Ер бусын амгалан тэр еглес
Ерөнхийлөгчийн угас
Юунд хангинав
Амгалан делгесен
Альенде
Учиргvй гэнэт уурлаж
«Урвагч» гэж хэнийг хэлэв
Зовлон дуулгах
Золгvй мэдээ
Зоригоор долгион цацав уу
Эх орны чих бас
Ингэж эрт хангинав уу

5.

Ард зондоон
Амь
Амьсгал
Амьдрал болсон газар шороо нь
Алт шиг санагддаг
Адилхан харагддаг
Асар баялаг зэсийн орон Чили
Урвагчдын улан доор
Унасан байнам
Улаан цус нь
Урсан байнам.
Энд - хvнлэг хvн
Хvн биш болжээ
Энд - хvнлэг ёс
Ёс биш болжээ.
Жадан дээр
Засаг тогтох уу
Жадан дээр жаргал байх уу.

6.

Ганц үгийн зэрээгвй
Галзуу офицер
Гаррисон...
Үнэн хvн хоёртой
Үгээр харьцах
Тийм ёсон
Тэр даргад байсангвй
Тэнгэрт тэрэнд
Тэнэгэр сэтгэл хайрласан ч үгвй
Эх орноон
Эгэл орныхоо хөгжил дэвшлийг
Эвдэн сүйтгэлцсэн
Чи
Эх орныхоо
Эцэг болсон
Эмч болсон
Энэрэн хайрлагч болсон
Эргүүлэн шинэтгэгч болсон
Альендийг
Чи ал луу.
Алуурч ...
Аж төрөхийн дайсан
Ард түмний дайсан
Нүглээн удахгвй
Нүдээрээн үзэх вий.
Тэр лав еерийгөөн
Тэнэг биш
Цэцэн гэж бодож яваа
Чили орныхоо хувь заяанаас урваагвй
Чин үнэнч гэж бодож яваа
Харгантай баатарлан тулалдсан
Хатуу зоригтон гэж бодож яваа
Хамаг олноо хайрлан энэрэгч
Халуун сэтгэлтэн гэж бодож яваа
Үгвй... тэр
Үхлийг будаа мэт таригч
Үзэшгвй хар нүгэлтэн.

7.

Нерудын орон унаж
Нерудын зүрх шаналж
Нерудын дуун хилэгнэв.
Найргийн орны
Найр нь хиртэж

Эрэлхэг ардын цус
Эгэл цээжнээ буцлав.
Орныхоо
Олны хvзvvнд
Олс зvvж
Үхлийн дарцаг
Сндерт ергев.
Генерал Пиночет
Генерал Пиночет
Пиночет - Гитлер
Гитлер - Пиночет
Слгий орноо
Шорон болгоод
Сереен vүдэнд нь
Хуяг болжээ.

8.
Генерал Пиночетын
Үхлээр далайлгах
Үзэл бодол
Генерал Пиночетын
Жадан дээр тогтох
Засаг тер
Эх орныхоо жаргалыг
Эгэл олныхоо амьдралыг
Харалгvй гишгэлж
Хахалгvй залгижээ.
Нерудын орон
Найргийн орон
Луис Рекабаррений орон
Луис Карваланы орон
Чилийнхний эх орон
Чили ялна.

ИРЭЭДҮЙ

1.
Ирээдvй - энэ цохигдоогvй туйпуу
Ирээдvй - энэ засагдаагvй чулуу
Ирээдvй - энэ нээгдээгvй уурхай
Ирээдvй - энэ vндэслээгvй хот
Ирээдvй - зуун зуунаар цуварч
Ирээдvй - миний урд байна
энэнийг би барьж босгоно

Ирээдүй - хvvгий минь урд байна
тэрнийг хvv минь барьж босгоно.
Ирээдүй - ач гуч нарын минь гарт байна.
Тvvнийг ач гуч нар маань барьж босгоно.
Хvн нийгмийн тэмvүлэлт хөгжил
Хvрч очих туйлын сайханд
Аж төрөх хязгааргvй азтай
Алс зууны цуут иргэн танд
Атаархнам баярланам.

Огт санаанд оромгvй
Ой ухаанд багтамгvй
Гайхамшигт дэвшилт давшилт
Ганцхан - хvний цуут ухаанаар
Гал мэт илчит гараар бvтэх бvхнийг
Төрөөгvй ач нарын гарыг
Тэдний үр саданы гарыг
Санан санан хvлээнэ
Саатан саатан хvлээнэ.
Үелэн цуврах зуун зуун жилvүдэд
Үнэтэй дуун, яруухан дуун болон
Санаагаар биш хvний гараар бvтэх
Сайхан ирээдүй өөд
Омголуун хелег шиг дугтран тэмvүлнэм
Оргилсон булаг шиг халгилан тэмvүлнэм
Оволзсон зvрх шиг догдлон тэмvүлнэм
Өглөх гэгчийг мэдэлгvйгээр
Үхэл гэгчийг vзэлгvйгээр
Ухаант нийгэмтэйгээ цуг
Улиран мөнхрөхийг хvснэм.

2.

Зvүн нь vгvй бол баруун нь vгvй
Зvрх нь vгvй бол судас vгvй
Үр нь vгvй бол удам нь vгvй
Цагийн явц цаашлах хууль ийм билээ
Ирээдүй - энэ өвгөрч яваа та
Ирээдүй - энэ өсөж яваа би
Ирээдүй - энэ анхны бэрийн гал
Ирээдүй - энэ өлгийн уян дуу
Ирээдүй - энэ шинэ нээгдэх сургууль
Ирээдүй - бидний байгуулж буй нийгэм
Барьж байгаа барилга
Бас нэмж босгох бvхэн
Ингээд босоход ирээдүй гэдэг маань
Их л наанаас эхэлнэ.

Харцны минь доорхиноос
Хамрын минь үзүүрхнээс
Харгилан урсах шиг
Хавтгайран ергежих шиг...
Єдер єдрийн явцуу хүрээнд эргэж
Єне холын их хэргээ мартвал
Єнер орны иргэн болж төрсөн
Єндер алдар минь унах нь тэр...

3.

Улс хөгжнөө гэж сайхан юм
Урьдын бүхнээ мартаж
Зоогоо үүрд тэнийлгэх юм.
Нусгай банди явсан
Нуруугаа зодуулж байсан
Євгед єнөө үлгэр адил
Єнгөрсөн цаг харуулна.
Зовхи нь буусан
Зол нь буурсан
Хуучин үеийн
Хөх Монголыг
Эндээс
Эрэгт далайгаас алс төв Азиас
Эрээд дэмий. Цагийн гарз.
Энэ нь Монгол улс сөнөсөн ч гэсэн үг биш
Эх орноо хаяад нүүсэн ч гэсэн үг биш
Тэмдэг ч үгүй болтлоо хөгжлөө гэсэн үг
Эрин цагийн
Иргэн бид
Хийх гэснээ хийж
Хэлэх гэснээ хэлж
Хүслийн уртад боогдохгүй болжээ.
Хүний доор орохгүй болжээ.

4.

Гэр болгонд гэрэл нь хүрч байдаг
Хүн болгоны хүсэл нь биелж байдаг
Ард болгонд ач нь хүрч байдаг
Ардын засаг бэхэжтүгэй.
Єнеєдрийн Монголын
Єнер царай
Залгамж хойчийн
Залуу дууг
Єргөн дуулах
Єр зүрхний хүслэн.
Єглөө орох шинэ байраа

Ууршиж буцлах халуун цайгаа
Инээж сэрэх алаг үрээ
Эрин цагаа
Эгэл нехдее
Эгшиглэн дуулнам
Ирээдүй - бидний хувь заяа
Ирээдүй - тойрог дээрээ хазгай орчлонгийн хувь заяа
Тэнхлэгээ эргэх бөмбөрцөгөө
Тэнхээгээ олсон хөгжлөө
Хар дайны аманд
Хаяж хэзээ ч егөхгүй.
Ирээдүй коммунизм!

ДОВЧИНГИЙН ОТГОНСҮРЭН

Довчингийн Отгонсүрэн 1946 онд Архангай аймгийн Хайрхан сумын нутагт малчны гэрт төржээ.

10 жилийн дунд сургууль, МУИС – н Монгол хэл уран зохиолын ангийг төгсөж, « Ургах наран зүг», « Уулын горхины шуугиан», « Миний цэцэрлэг » шүлгийн ном, « Уран зохиолын хэлний тухай» зэрэг уран зохиолын судлалын ном хэвлүүлжээ. Д.Отгонсүрэн 1977 онд хэл бичгийн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалжээ.

ҮР ТАРИА

Би үр тариа билээ
Би бүр учиртай үр тариа билээ
Нервийн салбарласан судал шиг
Нийслэлээс салбарласан зам шиг
Ишнээс салбарласан их үндсээ
Эх дэлхийдээ бөх суулганам
Энэ дэлхий минь намайгаа дүүрч
Эх дэлхийгээсээ би зуурч
Бид хоёр бие биеэ
Бие сэтгэлээсээ энхрийлэн тэвэрнэм.

Хөх манхан тэнгэртээ
Тэргүүнээ би ергенем
Хөдөө талынхаа салхинд
Түрүүгээ би ергенем
Хөрст дэлхийнхээ гүн тийш
Үндсээ би суулганам
Шим ертөнцийн нарны

Шижир сацрагаар амилан
Шиврэн буух хурын
Шаагих дуслаар ундаалнам.

Ээх нар минь
Шингээд орчихдог нар биш
Буух хур минь
Ширгээд хатчихдаг хур биш
Суух херс минь
Шим нь дуусчихдаг херс биш.

Тийм болохоор би
Тив дэлхийд дуулиантай
Тэнгэр огторгуйд дуулалтай
Тийм болохоор би
Ертенцийн салхинд халиурах
Ердийн тарианаас учиртай.
Наргвй, хургвй, херсгвйсэн бол би
Нармийж хорчийгоод хатчихсан байгаа.

Тэр гэхийн тэмдэг мергвй
Тив дэлхийгээс тонилчихсон байгаа.
Нартай хуртай херстэй болохоороо би
Намжаа дэлхийг нар шиг баясааж явдаг
Уяхан замбуутив маань намайг тарьсан юм
Уяхан замбуу тивдээ би таригдсан юм.
Би тариа болохоор
Би таригдсан болохоор
Хураах ургацтай хувьдаа бэлэгтэй.

Ургацаа егех л гэж би
Унтах нойроо
Умартан яарнам.
Ургацаа егех л гэж би
Улирах мечтэй
Уралдан яарнам.
Би ургацаасаа таригдах
Үрийг үзэх гэж яарнам
Би угтаа
Маргаашийн тариаг тарилцах гэж яарнам
Тэр цагт энэ бие маань
Ургасны хэрэг гвйцэх байна
Тэр цагт эх дэлхий маань
Ургуулсны хэрэг бүтэх байна.

МЭЛМИЙ

Минжин хангайн хархан нүдэн гэлтэй
Мэлмэлзэн урсах намрын харз шиг тунгалаг
Мичид түгсэн шенийн саран мэт гэрэлтэй
Мэлмий, нүдний сайхан мэлмий тормойно.

Хеевч үл баригдах солонгын адил зугтамхай
Хүслийг татах далдын шид нуугдаастай
Мэдэл үгвй дуу алдам тэр мэлмий
Миний өмнөөс үг хэлэм инээмсэглэв.

Ботгон нүдний цавчих тоолон шаналж
Борхон зүрх минь хэмнэлээ алдан булиглав
Бороонд норсон мойл шиг хархан мэлмий
Бодлын сувдан хэлхээг хувэнхэн талимаарав.

Болчимгвй алдсаныг сэм сэмээр мартуулан
Богинохон энэ насны нэгэн жаргал эдлүүлэв
Илүү маяггвй тэр мишээлд нь найрсаж
Элгэн хайр өөрийн эрхгвй хөвсөлзөв.

Ижилгвй хөөрхөн тэр нүдний талимаанд
Эдэлдэг жаргал бүхнийг амтлан жаргая гэтэл
«Сайхан юм бүхэн өөрийн тавилантай » гэж
Санааны үзүүрт нууц түгшүүр харвалаа.

Ажин саатвал, хархан нүдний талимаанд
Амраг хайрын оч гялсхийн үзэгдэв
Хэрийн хүнд нандин түвнийгээ өгөхгвй гэх
Хэрсүү бодлын сүүдэр төдхөн бас халхлав.

Хаа хэзээний өнчрөл гунигаа далдалж
Хайр хүргэн мэлмэлзсэн мэлмийг харахад
Холын хоёр ертенцийн таталцах хүчин мэт
Хос зүрхний хооронд соронзон айлчилна.
Их ус харвал ядаргаа арилдаг гэж
Эцэг дээдсийн минь хэлсэн үг учиртай л
Намрын харз шиг тунгалаг хархан мэлмийг
Насаараа харах хүн хамгаас азтай л.

СЭТГЭЛИЙН УТАС

Шаширлах тариан түрүүнд исгэрэх
Салхин шивнээ
Шижирлэх долгио хаялан мэлтэлзэх
Голын шуугиан
Шинэхэн цэцгийн цомирлог ундлах

Хурын шаагиан
Шимээр ногоорох мөчрөө тэлэх
Навчсын сэргжигнээн
Сэлгүүн орчлонг бүхлээр нь багтаах
Сэтгэл дотор минь амилан байна

Ай, миний сэтгэлд
Хүрвэл яруу тунгалаг аяс эгшиглэх
Хөгжмийн утас хөвчлөөстэй байнам
Дардас бүхнээс нь өнгө аялгуу цацран
Даамай симфони, баатарлаг марш ч төрмөөр байна.

Гагцхүү арван наймтын сэтгэлд л төрөх
Гайхамшигт уянга ч бас л эгшиглэх билээ
Сэрүүн салхинд намрын навчис газардахуйд
Сэтгэлийн минь утас доргин дуугарнам
Миний сэтгэлд
Хүлгийн төвөргөөн
Бөмбөрийн цохилт шиг дэргэдүүр тачигнаснаа
Хөндий талынхаа арвинд уусах мэт
Алслан алхалсаар намжих адил
Аялгуу айзам эгшиг бий.

Ай, миний сэтгэлд
Голын шуугиан
Хурын шаагиан
Салхин исгэрээн
Навчсын сэргжигнээн амилан бий

Ай, миний сэтгэлд
Баатарлаг марш, симфони
Баярын сонат
Хайрын уянга
Харууслын хөгжим аялан бий.

ИХ ДАЛАЙН ДАВАЛГААН

Эрэг хязгаар нь олдомгвй
Их далайн давалгаанд
Эрхийн чинээ завьтай
Эр тэнцэн явнам, би

Тэнгис далайн тэртээг
Тэнгэрийн хаяа дэрлэн
Тэр гэж ялгаж заахын
Тэмдэг мергвй цэнхэртнэм
Далай завийг минь сэгсчиж
Даамай зоригийг минь тэнсэнэ
Их далайн гvнд
Хел алдан живэхээ
Эх газраа зорин
Хvч мэдэн серехеэ
Гарын булчин мэднэ
Ганцхан зориг л мэднэ.

Далай давлах давалгаатай
Дайвж цалиглах нь нvргээнтэй
Сахрах долгион нь vзэх енгетэй
Саатан чагнам, сайхан аялгатай
Далай завийг минь сэгсчин
Даамай зоригийг минь тэнсэг.
Дөрвөн зvг тэмтэрч
Дvйвээнээр би яваагвй
Усанд унасан навч шиг
Урсгал даган хевеегвй
Найр тавих наран зvг
Намайг угтах маргааш тийш
Сэтгэл бодлоо нум шиг хевчлэн
Сэлvvр амраалгвй хевнэм.

ТООМОЙН ОЧИРХҮҮ

Тоомойн Очирхүү 1943 онд Говь – Алтай аймгийн Тамч сумын нутагт малчны гэрт төржээ.

Бага дунд сургууль, АУДС, ЗХУКН – н Төв Хорооны дэргэдэх нийгмийн ухааны академи төгсжээ. Т.Очирхүү « Сэтгэлийн үер», « Тэнгэрийн хаяаны од», « Алтайн унага» зэрэг яруу найргийн ном хэвлүүлжээ.

ИЛЬИЧИЙН ХУУЧИН ХҮРЭМ

Суут Ильичийн хүрэм
Сугандаа нөхөөстэй байх гэж үү
Анхаарлын цусан тэмдэг шиг
Асгарсан цусны дусал шиг
Очиж очиж улаан утсаар
Оёж шидсэн байх гэж үү.
Их түүхийн музейд зочид гийчин олон
Ильичийн хүрэмний дэргэд зогсож саатах нь олонтой
Өрөө би зүрхэндээ шарх олсон шиг
Өмнө нь очиж удаан зогсов
Сэтгэлд гэнэтхэн хар бууж
Сэрүүн зүүд шиг бодолд дарагдав
Сум дайрсан энэ хүрэмний цаана
Суут хүний зүрх цохилж байсан гэж бодов.
Улаан тэмдэгт тэр л цоорхойг
Урвагчийн бууны сум чиглэж ирсэн гэж бодов
Тэр сум гэвч Ильичийн зүрхийг оноогүй
Тэнгэрлэг их Лениний амь насанд хүрээгүй
Буурал түүхийн их хүний өөдөөс
Буруутан дайсны гар чичирсэн байж таарав.
Сэтгэлд гэнэтхэн хар бууж
Сэрэмжлэгтүн гэж зүрх минь шивнэв
Буяны хорвоод ийм урвагч байсныг
Сумны ортой Ильичийн хүрэм хэлж байна.
Хаа нэгтэй дайсны сум бийг
Хал үзсэн коммунистын зүрх хэлж байна.
1978

АРГАМЖААНЫ ЧУЛУУ

Төө зайгүй хайртай эх орноо санаж
Түмэн бээрийн чанадаас бодол бэлчээн суухад
Таталт сайтай дуран шиг нэхэн дурсах сэтгэлд минь
Танхил багын нутаг нэгд нэгэнгүй тодрох юм.
Өргөн Ширтийн зуслан нүдний өмнө илхэн
Өвст судгийн эхэнд аргамжааны чулуу тодхон
Гучин жилийн тэртээ яг л байсан газраа
Гурвалжин хөх чулуу явсан ч үгүй янзаараа
Хэн нэгний морь аргамжаатай байгаа санагдана
Хэнзхэн ногооны үнэр анхилж байх шиг бодогдоно.
Унаа морио бөхлөхтэйгөө болж дээ хүү минь гэж
Урамшуулж хэлсэн эцгийн үг
Бядгүй балчирхан насны минь бяцхан гарын оромтой цуг
Аргамжааны тэр л чулуунд арилшгүй үлдсэн бий

Ширхэгхэн ганц чулуу нь ч сэтгэлийн угт уяатай
Сэрүүн Алтай нутагтаа би хүлэг морин шиг аргамжаатай
Аргамжааны тэрхэн чулууг тойрон идэшлэх хүлэг шиг
Аяа эх орон чамдаа би тоосны үзүүрээс эргээстэй.
1978

ЭМЭЭЛ

Цэнхэрийн говийн намаржаанд малчин өвгөн
Цэрэгт яваа хүүдээ эмээл төхөөрч байв
Мөнгөн чимэгт эмээлийнхээ ганзага олмыг тааруулж
Мөдхөн ирнэ хүү минь гэж хоног тоолон байв
Албаа хааж дуусахад тавхан сар үлдлээ гэж
Аав нь хүүдээ эмээл төхөөрч байна.
Нэг л өглөө хөтөлгөө морьтой Хонгорын шилийг давна гэж
Нэгдлийн малчин өвгөн инээмсэглэн ярьж байна.
Санаа цайлган ардын маань энхийн сайхан хүслэн
Сайхь тэр өвгөний төхөөрсөн эмээлд байна
Цэргээс ирэх хүүгийн эмээл тохох хүлэг
Цэцэг бүрхсэн талдаа оноотой тарган байна
Эмээл хүлэг хоёр эзнээ хүлээж
Эх орон маань амар тайван байна.
Цэнхэрийн говийн намаржаанд малчин өвгөн
Цэрэгт яваа хүүдээ эмээл төхөөрч байна.

НАЙРАГЧИЙН ӨРӨӨНД

Амьд сэрүүн цагийн нь алтан мөр болж
Азербайджан найрагчийн өрөөнд хуучин пянз эргэж байна
Сайхан сэтгэлт түмэндээ зүрхний үгээ хэлж
Самед Вургун найрагч шүлгээ уншиж байна.
Ганцхан заяах эх орныхоо тухай
Газар дэлхий, эрх чөлөөний тухай
Уулын цовоо эрсийн тухай
Улаа бугарсан охидын тухай
Яг л дэргэд минь идэр залуугийнхаа дуугаар
Яруу найрагч шүлгээ уншиж байна.
Хорвоогийн мөнх бусыг үзсэн найрагчийн өрөөнөөс
Холдож ч чадахгүй, салж ч чадахгүй
Хол ойрын хүмүүс тойрон эргэж байна.
Үсэн буурал үеийнхэн нь
Үйлсийг нь залгах хойчийнхон нь

Үзэг нэгт нөхөд нь тойрон эргэж байна
Гарцаагүй, энэ амьдрал мөнхийн гэрч
Гадаа гудамжаар их бага тойргоор
Үй түмэн машин тэрэг хүн зон
Үдшийн Бакуг тойрон эргэж байна
Найрагчийн дуу нэг тодорч, нэг бүдгэрч
Хуучин пянз эргэж байна
Намар оройн салхин гэгээвчээр үлээнхэн байна
Гарцаагүй, энэ амьдрал мөнхийн гэрч
Газар дэлхий, он цаг, хүмүүс
Нарыг тойрон эргэж байна
Найрагчийн хуучин пянз амьдрал адил эргэж байна
Амьдрал гэдэг үнэтэй
Алтаар хэмжишгүй үнэтэй
Амьд сэрүүн цагийн нь алтан мөр болж
Азербайджан найрагчийн өрөөнд хуучин пянз эргэж байна
Сайхан сэтгэлт түмэндээ зүрхний үгээ хэлж
Самед Вургун найрагч шүлгээ уншиж байна.
Баку 1977

ГЭРЛИЙН ТУХАЙ БОДОЛ

Орой болсон хойно цонхоо нээж
Орон хотын гудамжийг харвал
Шөнө дөлийн их хот
Өнгө өнгийн гэрлээр ярина
Улаан хэрээстэй түргэний тэрэг
Урагшаа шурхийн өнгөрлөө.
Оч үсрэх шиг гялсхийсэн энэ тэрэгний гэрэл
Орчлонд нэг шинэ хүн төрлөө гэж хэлнэ үү дээ
Хаа нэгтэй айлын цонхны гэрэл
Харанхуйн дунд гялсхийн аслаа
Гэрийн эздийг баярлуулж
Гэнэтхэн тэнд холын зочин оройтож ирэв үү дээ
Тэртээ тэнд эгнэсэн олон гэрэл
Тэрэг, машин хүмүүсийн чимээ чих дэлсэнэ
Тэнд аварга үйлдвэрийн зүрх лугшиж
Тэнхээт ажилчин хүн шөнийн ээлжиндээ гарч байна уу даа
Хойд талын байшингийн хоёр цонхны гэрэл
Холгүй зайтай асаж унтраад байх юм
Анхны хүүгээ төрүүлсэн залуу хос
Алдрайхан хүүгээ хуурайлах гэж сандарч байна уу даа
- Хол ойр гэрэл асч унтарч
Хойш урагш машин тэрэг сүлжиж

Их хот шөнөжин гэрлээр ярина
Ээдээ, энэ гэрэл гэдэг амьдрал юм даа
Яралзсан хотын гэрлийг харахад
Яруу шүлгийн санаа бууна
Гэрэл ... бас нэг айлын гэрэл
Гэнэтхэн ирсэн онгодоо гүйцэж ядан
Гэрэлтэй тэр цонхон доор найрагч шүлгээ бичиж эхлэв ээ
1978

* * *

Хүмүүс ээ ! Надад урам хайрла !
Хүсэл зориг бадраах халуун дулаан үг хайрла
Анх хөлд орж байгаа алдрай жаахан хүүд
Алхаарай, алхаарай гэж дэм хайрла
Эрдэнийн үсэг хэлхэж суугаа сургуулийн жаахан охинд
Эрдэмтэй хүн болноо, хичээ гэж урам хайрла
Анхны цалингаа аваад баярлаж байгаа хөвгүүнд
Аавын хүү эр хүн болж гэж шан хайрла
Амьдралд нэг эндээд гэмшиж суугаа хүнд
Ахиад алдахгүй ээ хө гэнэдэж гэж ухаан хайрла
Өдий жил ч хол байна даа гэж хүлээж суугаа амрагт
Өө юухан байхав гэж итгэл хайрла
Өндөр нас ч дарлаа даа гэж гуньсхийж суугаа бууралд
Өвөө та ануухан байна даа гэж урам хайрла
Хүмүүс ээ ! Надад урам хайрла !
Хүч тэнхэл өгөх бүлээн дулаан сэтгэл хайрла !
1978

НАМЖИМИЙН ОЧИРБАТ

Намжимын Очирбат 1939 онд Булган аймгийн Могод сумын нутагт малчны гэрт төржээ.

1957 онд 10 жилийн дунд сургууль, 1962 онд МУИС-ийн монгол хэл бичиг, утга зохиолын анги төгсжээ.

Н. Очирбат «Хан хурмаст», «Хүн хүнээ дуулна», , «Насан үүрдийн өлгий», «Тэнгэрт нүдэлсэн цэцэг» шүлэг, найраглалын ном хэвлүүлжээ.

НУТГИЙН ШОРОО АЛТ

Нууран дундаа шувууд чуулаад
Нургин хийлэн үймж эхлэв
Нутаг нутгийн залуус дарвиад
Нулимс мэлтрэм дуулан хайлав.

Уран зэллээ мэтгэн дэвсээр
Урин орныг зорих шувууд
Уртын аяндаа тасарч ядан
Уймран ганганах юусан билээ.

Эрхэст тэнгэрт хөөрөх жигүүр
Эхээс төрүүт заяаж өгсөн
Цэнгэг ус нь соронзон адил
Цэрвэн нисэхэд нь татаа юмуу?

Оюун санаа баяжаам сэргэг
Олны үр сад найрсан баясаад
Эрдмийн далайд умбах атлаа
Эргэн хургах юусан билээ

Үйзэн хорвоод нэргүй мэндлүүт
Үрийн ёсоор тосож авсан
Нутгийн шороо алт болохоор
Нууцхан нэгийг шивнээ юмуу?

ХҮҮ ТӨРЛӨӨ

Ургах нартай
Уралданхан
Хүү төрлөө.

Уйлаан дуулиан
Хадаанхан
Хүү төрлөө.

Энэрэлт ээжээ
Мэлмэрүүлэнхэн
Хүү төрлөө.

Эгшигт бүүвэй
Аялууланхан
Хүү төрлөө.

Ачлалт ааваа

Уярууланхан
Хүү төрлөө.

Алаг зүрхийг нь
Хайлууланхан
Хүү төрлөө.

Хөрст дэлхийг
Хотойлгонхон
Хүү төрлөө.

Хөх тэнгэрийг
Гүдийлгэнхэн
Хүү төрлөө.
1963

«НАЙРАМДАЛ» ЛАГЕРЬ

Үсээрээ, зүсээрээ ялгаатай бидний
Үерхэн нөхөрлөх үүдийг нээсэн
Нэрээрээ нүүрээрээ учраагүй нөхдийг
Нэгэн эхийн үрс шиг дасгасан
Найрсаг монгол ээж шиг ээлтэй
«Найрамдал» лагерь энхийн дуутай.

Хэлээрээ, заншлаараа ондоохон бидэнд
Хэзээ ч ариун итгэл төрүүлсэн
Хайрлан хүндлэх нандин чанарыг
Хатан зүрхэнд мөнхлөн шингээсэн
Найрсаг монгол ээж шиг ээлтэй
«Найрамдал» лагерь энхийн дуутай.

Тэнгэрийн одод шиг жавхаалаг төрөөд
Энгэрийн цэцэг шиг өнгөжин дэгжсэн
Бидний сэтгэл сүү шиг цагаан
Биеэсээ түших ах дүү шиг үнэнч
Найрсаг монгол ээж шиг ээлтэй
«Найрамдал» лагерь энхийн дуутай.

Алсаас алсад хараа сунган
Улсаас улсад урин дуудсан
Бидний уриа-интернационал
Биелэх ирээдүй-саруул коммунизм

Найрсаг монгол ээж шиг ээлтэй
«Найрамдал» лагерь энхийн дуутай.